Нисэх онгоцны буудал, авто болон төмөр замын өртөө, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн барилга байгууламжууд, хог хаягдлын цэг, оршуулгын газар хот орчмын бүсэд байрлана. Хот орчмын бүс нь ногоон байгууламжтай, түүний дотоод хязгаар нь хот тосгоны барилгажих нутаг дэвсгэрийн хил байна. Барилгажих хилийн дагуу 500 метрээс багагүй өргөнтэй ойн зурвас байгуулна. Зуслангийн бүс нь улирлын чанартай суурьшин амьдрах нутаг дэвсгэр байна.

Хот тосгоны ус хангамжийн эх үүсвэрийг газрын дээд талд суурьшлын бүсийн ойролцоо байхаар сонгоно. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хатуу дэглэмийн 1-р бүс, хязгаарлах 2 ба 3-р бүс гэж ангилан тогтооно.

Хүснэгт №3.18. Гүний усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгаалалтын бүс

Эх үүсвэрийн нэр	Хэмжих нэгж	Зай хэмжээ
Гүн өрмийн худаг		
1-р бүс	Метр	50
2-р бүс	Метр	100
Нэгдсэн усан сан	Метр	150

Гүний эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх нөхцөлтэй, эсвэл урсгал уснаас шууд тэжээгдэх нөхцөлтэй бол эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд, хөрсний уснаас хамгаалагдсан нөхцөлд 200 метрээс доошгүй зайд хамгаалалтын бүсийг тогтооно.

Ус хангамжийн эх үүсвэрт гадаргын усыг ашигладаг нөхцөлд гол горхи булгийн эргээс 200 метрээс доошгүй зайд 1-р бүсийг, урсгалаас дээш 50км-ээс доошгүй, урсгалаас доош 500 метрээс доошгүй зайд хязгаарлалтын бүсийг тогтооно.

Ус хангамжид усыг цэвэршүүлэх шаардлагатай нөхцөлд цэвэршүүлэх байгууламжийг бий болгож түүний эдэлбэр газрыг хүчин чадлаас нь хамааруулж тогтооно. Үүнд:

0.8 мян.м ³ /хон	1 га
0.8 - 12 мян.м ³ /хон	2 га
12 - 32 мян.м ³ /хон	3 га
32 - 60 мян.м ³ /хон	4 га
10 - 125 мян.м ³ /хон	6 га
125 - 250 мян.м ³ /хон	12 га
250 – 400 мян.м ³ /хон	18 га
400-800 мян.м ³ /хон	24 га

Хот тосгоны бохир ус цэвэрлэх байгууламж нь зонхилох салхины доод чигт, гадаргын нам хэсэгт байрлана.

Хүснэгт №3.19. Бохир ус цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын дээд хэмжээ

№	Бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал мян.м ³ /хон	Эдэлбэр газрын хэмжээ, га		
		Цэвэрлэх байгууламж	Лагийн талбай	Бохир усны гүн цэвэрлэгээ, биологийн цөөрөм
1	0.7 хүртэл	0.5	0.2	-
2	0.7-17	4	3	3
3	17-40	6	9	6
4	40-130	12	25	20
5	130-175	14	30	30
6	175-280	18	55	-

3.3. Хот суурин газрын газар ашиглалтын бүсийн төлөвлөлт

Алаг-Эрдэнэ сум


Засаг захиргаа, соёл үйлчилгээний барилга байгууламжийн бүс нь 20.54 га, нөөц нь 14.61 га байна. Соёл ахуйн үйлчилгээний барилгуудыг газрын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр барихад хүрэлцээтэй.

Гэр орон сууцны бүс 69.43 га, нөөц газар нь 191.8 га байна. Энэ нь нэг өрхөд ногдох эдэлбэр газрыг норм болон олгогдсон газрыг багтаасан хангалттай нутаг дэвсгэр юм. Үйлдвэр аж ахуйн бүсийг сумын төвийн зүүн хойд талд 3.77 га талбайд төлөвлөсөн.

Хогийн цэг 10.05 га-д байрлана. Хогийн цэгийг бульдозероор дотогш түрж талбайн хэмжээг багасган хашаажуулах арга хэмжээ авах.

Зам дагасан авто тээврийн үйлчилгээний цэгийг 49.36 га-д төлөвлөв.


Оршуулгын газар 3.04 га-д байрлана. Цаашид хумих шаардлагатай.



Зураг №3.2. Алаг-Эрдэнэ сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Арбулаг сум


- Засаг захиргаа, соёл үйлчилгээ барилга байгууламжийн бүс нь 24.76 га, нөөцийг 4.85 га талбайд төлөвлөж байна.
- Гэр орон сууцны бүс 34.49 га, нөөц газар нь 59.69 га байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг сумын төвийн зүүн талд 4.12 га талбайд төлөвлөсөн. Тус бүсэд дараах үйлдвэр, аж ахуй байрлана. Үүнд:
 - ✓ Сүү цагаан идээ боловсруулах үйлдвэр
 - ✓ Барилгын материалын үйлдвэр
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгийг 1.87 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 29.1 га-д байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай.
- Оршуулгын газар 0.79 га-д байрлана.



Зураг №3.3. Арбулаг сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Баянзүрх сум

- Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжийн бүс 17.66 га, нөөц нь 13.54 га байхаар төлөвлөв.
- Гэр орон сууцны бүс нь 77.3 га, нөөц нь 80.05 га газартай байна. Суурьшлийн өмчлөлд бүрэн хангалттай нутаг дэвсгэр юм.
- Үйлдвэр аж ахуйн бүс нь сумын төвийн баруун талд 8.06 га газарт төлөвлөв. Тус бүсэд дараах үйлдвэр аж ахуй байна.
 - ✓ Хүнсний үйлдвэрлэл
 - ✓ Сүү цагаан идээ боловсруулах үйлдвэр
 - ✓ Ахуйн үйлчилгээний цэг
 - ✓ Талх нарийн боов
 - ✓ Эсгийний цех
 - ✓ Аялал жуулчлалын отог
- Зуслангийн газрыг сумын төвийн зүүн талд 38.55 га-д төлөвлөж байна.
- Хогийн цэг 2.24 га-д байрлана.
- Оршуулгын газар 4.5 га-д байрлана.



Зураг №3.4. Баянзүрх сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Бүрэнтогтох сум


- Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжийн бүс 16.13 га, нөөц нь 6.4 га байхаар төлөвлөв.
- Гэр орон сууцны бүс нь 54.98 га, нөөц нь 63.44 га-д багтаж баруун тийш тэлнэ.
- Үйлдвэр аж ахуйн бүс нь сумын төвийн зүүн талд 2.72 га газарт байрлана. Тус бүсэд дараах үйлдвэр аж ахуй байна.
 - ✓ Фермерийн аж ахуй
 - ✓ Жимс жимсгэний үйлдвэр
 - ✓ Мод боловсруулах үйлдвэр
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутаг 9.58 га-д сумын төвийн баруун урд чиглэлд төлөвлөв.
- Хогийн цэг 14.21га-д байрлана. Цаашид хумих шаардлагатай.
- Амралт зугаалгын бүс нутаг 2.38 га-д байрлана.
- Оршуулгын газар 21.27 га-д байрлана.



Зураг №3.5. Бүрэнтогтох сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Галт сум


- Барилга байгууламжийн бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа, үйлчилгээ, зам гудамж байрлана. Одоогийн байдлаар 24.47 га газар, нөөц нь 2.47 га байна.
- Гэр орон сууцны бүс 129.4 га, нөөц нь 52.94 га газар байхаар төлөвлөв.
- Үйлдвэр аж ахуйн бүс газар сумын төвийн зүүн талд 2.59 га-д төлөвлөсөн. Үүнд:
 - ✓ Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр
 - ✓ Мод, модон эдлэлийн үйлдвэр
 - ✓ Ахуйн үйлчилгээний цэг
- Эрчимжсэн мал аж ахуйн бүсийг сумын төвийн баруун урд талд 12.63 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 10.22 га-д байрлана. Хогийн цэгийг бульдозероор дотогш түрж талбайн хэмжээг багасган хашаажуулах арга хэмжээ авах.
- Ногооны талбай сумын төвийн зүүн талд 0.38 га-д байна.
- Амралт зугаалгын бүс газар 3.79 га-д байрлана.
- Оршуулгын газар 0.67 га-д байрлана.



Зураг №3.6. Галт сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Жаргалант сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. Одоогийн байдлаар 19.77 га, нөөц нь 7.84 га байна.
- Гэр орон сууцны бүсийн газар нутгийн хэмжээ 130.59 га байна. Нөөц нь 135.67 га байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг сумын төвийн зүүн талд 10.31 га газарт төлөвлөв. Тус бүсэд дараах үйлдвэр аж ахуй байна.
 - ✓ Блокны үйлдвэр
 - ✓ Мод, модон эдлэлийн үйлдвэр
 - ✓ Ахуйн үйлчилгээний цэг
 - ✓ Эсгий гутлын цех тус тус байрлана.
- Ойн зурвас байгуулж, ойжуулах шаардлагатай нийт 115.77 га газар байна.
- Хогийн цэг 19.11 га-д байрлана. Хогийн цэгийг бульдозероор дотогш түрж талбайн хэмжээг багасган хашаажуулах арга хэмжээ авах.
- Амралт зугаалгын бүс 0.73 га-д байрлана.
- Оршуулгын газар 2.65 га-д байрлана.



Зураг №3.7. Жаргалант сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Их-Уул сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. Одоогийн байдлаар 27.16 га газар байна. Нөөц нь 24.05 га газар байна.
- Гэр орон сууцны бүс. Одоогийн байдлаар 136.58 га талбай байна. Нөөц нь 288.8 га газар байна.
- Үйлдвэрийн бүсийг сумын төвийн зүүн урд 12.28 га газарт төлөвлөв. Үйлдвэрийн бүсэд дараах үйлдвэр аж ахуй байгуулах боломжтой.
- Ойн зурвас ногоон байгууламж байгуулах 8.6 га талбай байна.
- Хогийн цэг 10.86 га талбайд байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай байна.
- Ногооны талбай 15.16 га талбайд байрлана.
- Зам дагасан авто тээврийн үйлчилгээний газрыг 99га-д төлөвлөв.



Зураг №3.8. Их-Уул сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Рашаант сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. Энэ бүс одоогийн байдлаар 22.31 га талбай байна. Нөөц нь 31.15 га байна.
- Гэр орон сууцны бүс одоогийн байдлаар 209.79 га талбай байна. Нөөц нь 64.45 га байна.
- Үйлдвэрийн бүсийг сумын төвийн урд хэсэгт 5.57 га талбайд төлөвлөв. Энэ бүсэд дараах үйлдвэр аж ахуйн бүсийг байгуулах боломжтой байна. Үүнд:
 - ✓Тоосгоны цех
 - ✓Хужир боловсруулах үйлдвэр
 - ✓Талх нарийн боовны үйлдвэр
 - ✓Халтар арвайн гурил, чихэр боловсруулах үйлдвэр
- Хогийн цэг 10.86 га талбайд байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай байна.
- Ногооны талбай 10.96 га талбайд байрлана.
- Амралт зугаалгын бүс 3.49 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 1.08 га талбайд байрлана.



Зураг №3.9. Рашаант сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Ренчинлхүмбэ сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. Бүсийн нутаг дэвсгэр нь 24.97 га байна. Нөөц нь 6.3 га байна.
- Гэр орон сууцны бүс газрын нийт хэмжээ 263.32 га талбай байна. Нөөц нь 520.79 га байхаар төлөвлөв.
- Үйлдвэр аж ахуйн бүс. Тус бүсийг 7.19 га талбайд төлөвлөв. Энэ бүсэд дараах үйлдвэр аж ахуйн бүсийг байгуулах боломжтой байна. Үүнд:
 - Хогийн цэг 6.74 га талбайд байрлана.
 - Ногооны талбай 0.95 га талбайд байрлана.
 - Амралт зугаалгын бүс 2.2 га талбайд байрлана.
 - Оршуулгын газар 3.6 га талбайд байрлана.



Зураг №3.10. Ренчинлхүмбэ сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Тариалан сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. Одоогийн байдлаар нийт барилгажсан талбай 60.02 га байна. Нөөц нь 4.08 га талбай байна.
- Гэр орон сууцны бүс газар одоогийн байдлаар 369.61 га талбай байна. Нөөц нь 762.19 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг сумын төвийн баруун урд 13.23 га талбайд төлөвлөв. Үүнд дараах үйлдвэр аж ахуй байгуулах боломжтой юм.
 - ✓ Өндөр технологи бүхий гурилын үйлдвэр
 - ✓ Фермерийн аж ахуй
 - ✓ Авто засварын газар
 - ✓ Зоорины аж ахуй
- Хогийн цэг 7.01 га-д байрлана.
- Амралт зугаалгын бүс 1.86 га-д байрлана.
- Авто тээврийн үйлчилгээний газрыг 40.62 га талбайд төлөвлөв.
- Оршуулгын газар 12.49 га талбайд байрлана.



Зураг №3.11. Тариалан сумын төвийн газар ашиглалты бүсчлэл

Тосонцэнгэл сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар 14.06 га талбай барилгажсан байна. Цаашид 13.05 га талбайн нөөцтэй байна.
- Гэр орон сууцны бүс газар одоогийн байдлаар 96.28 га талбай байна. Нөөц нь 65.46 га талбай байна.
- Үйлдвэрийн бүсийг 14.64 га-д төлөвлөж байна. Тус бүсэд байгуулах боломжтой дараах үйлвэрүүд байна. Үүнд:
 - ✓ Хүлэмж зоорины аж ахуй
 - ✓ Фермерийн аж ахуй
- Эрчимжсэн мал аж ахуйн бүс газрыг сумын төвийн баруун урд 15.62 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 16.39 га талбайд байрлана.
- Амралт зугаалгын бүс 0.85 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 20.56 га талбайд байрлана.



Зураг №3.12. Тосонцэнгэл сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Төмөрбулаг сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон байгууламж байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 15.37 га газар, нөөц нь 2.96 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 51 га, нөөц нь 57.6 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг сумын төвийн баруун урд талд 3.61 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Зоорины аж ахуй
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгийн сумын төвийн зүүн талд 4.66 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 29.92 га талбайд байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай байна.
- Ногооны талбай 0.88 га талбайд байрлана.
- Амралт зугаалгын бүс 0.59 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 14.05 га талбайд байрлана.



Зураг №3.13. Төмөрбулаг сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Түнэл сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 12.38 га газар, нөөц нь 6.17 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 163.23 га, нөөц нь 720.076 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 297.83 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Хүлэмж зоорины аж ахуй
 - ✓ Мод, модон эдлэлийн үйлдвэр
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгийг 887.37 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 16.98 га талбайд байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай байна.
- Амралт зугаалгын бүс 1.44 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 4.52 га талбайд байрлана.



Зураг №3.14. Түнэл сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Улаан-Уул сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 19 га газар, нөөц нь 18.79 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 139.58 га, нөөц нь 169.86 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг сумын төвийн урд талд 8.41 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Малын тэжээлийн үйлдвэр
 - ✓ Цайны ургамлын үйлдвэр
 - ✓ Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр
- Хогийн цэг 14.6 га талбайд байрлана.



Зураг №3.15. Улаан-Уул сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Ханх сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 103.79 га газар, нөөц нь 18.74 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 173.37 га, нөөц нь 293.13 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 105.73 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгийг 5.24 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 2.63 га талбайд байрлана.
- Амралт зугаалга, аялал жуулчлалын бүс 37.9 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 6.19 га талбайд байрлана.



Зураг №3.16. Ханх сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Цагааннуур сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 30.13 га газар, нөөц нь 22.55 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 168.55 га, нөөц нь 307.48 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 11.96 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - Хогийн цэг 4.34 га талбайд байрлана.
 - Ногооны талбай 0.89 га талбайд байрлана.
 - Амралт зугаалгын бүс 0.72 га талбайд байрлана.
 - Оршуулгын газар 15.22 га талбайд байрлана.



Зураг №3.17. Цагааннуур сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Цагаан-Уул сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 24.74 га газар, нөөц нь 26.808 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 360.43 га, нөөц нь 601.09 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 13.46 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгийг 17.85 га талбайд төлөвлөв.
- Ойн зурвас ногоон байгууламж байгуулах бүс газрын нийт талбай 24.41 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 55.57 га талбайд байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай байна.
- Амралт зугаалгын бүс 3.46 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 18.25 га талбайд байрлана.



Зураг №3.18. Цагаан-Уул сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Цагаан-Үүр сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 14.28 га газар, нөөц нь 0.71 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 206.17 га, нөөц нь 422.01 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 23.44 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Зөгийн аж ахуй
 - ✓ Аялал жуулчлалын отог
- Эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс нутгийг 16.02 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 5 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 2.13 га талбайд байрлана.



Зураг №3.19. Цагаан-Үүр сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Цэцэрлэг сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 13.78 га газар, нөөц нь 1.59 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 88.88 га, нөөц нь 50.61 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 15.94 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Малын тэжээлийн үйлдвэр
 - ✓ Барилгын материалын үйлдвэр
- Хогийн цэг 26.17 га талбайд байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай байна.
- Оршуулгын газар 1.51 га талбайд байрлана.



Зураг №3.20. Цэцэрлэг сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Чандмань-Өндөр сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 9.24 га газар, нөөц нь 1.92 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 241.6 га, нөөц нь 416 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 12.63 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Зөгийн аж ахуй, зөгийн бал боловсруулах үйлдвэр
 - ✓ Мод, модон эдлэл боловсруулах үйлдвэр
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгийг сумын төвийн урд 11.74 га талбайд төлөвлөв.
- Хогийн цэг 15.26 га талбайд байрлана. Цаашид талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хумих шаардлагатай байна.
- Амралт зугаалгын бүс нутгийг 131.48 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 0.83 га талбайд байрлана.



Зураг №3.21. Чандмань-Өндөр сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Шинэ-Идэр сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 22.89 га газар, нөөц нь 1.32 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 45.27 га, нөөц нь 75.23 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 2.6 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Тоосгоны үйлдвэр
 - ✓ Малын тэжээлийн үйлдвэр
 - ✓ Мал нядалгааний цех
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгийг сумын төвийн баруун урд 6.69 га талбайд төлөвлөв.
- Ойн зурвас ногоон байгууламжын бүс 0.44 га-д байрлана.
- Амралт зугаалгын бүс нутгийг 0.95 га-д байрлана.
- Оршуулгын газар 1.46 га талбайд байрлана.



Зураг №3.22. Шинэ-Идэр сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Эрдэнэбулган сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 27.66 га газар, нөөц нь 4.33 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 166.09 га, нөөц нь 201.08 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 57.17 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Фермерийн аж ахуй
 - ✓ Зөгийн аж ахуй
- Хогийн цэг 3.19 га талбайд байрлана.



Зураг №3.23. Эрдэнэбулган сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Мөрөн сум


- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, зам гудамж, худалдаа үйлчилгээ, ногоон суулгамал байрлана. Бүсийн нутаг дэвсгэр нь 371.08 га байна. Нөөц нь 1393.02 га байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 698.31 га, нөөц нь 436.63 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 484.76 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Мах боловсруулах үйлдвэр
 - ✓ Стандартын дагуу хөргүүртэй зоорины аж ахуй
 - ✓ Хүнсний ногоо нөөшлөх үйлдвэр
 - ✓ Сав баглааны үйлдвэр
 - ✓ Шахмал түлшний үйлдвэр
 - ✓ Ахуйн үйлчилгээний цэг
 - ✓ Пенобетоны үйлдвэр
 - ✓ Ноос ноолуур угаах үйлдвэр
 - ✓ Дулааны цахилгаан станц
 - ✓ Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр
 - ✓ Жимс боловсруулах үйлдвэр
 - ✓ Эмийн үйлдвэр
- Онгоцны буудал 87.45 га талбайд байрлана.
- Ойн зурвас,ногоон байгууламжын бүс 595.02 га талбайд байрлана.
- Хогийн цэг 57.42 га талбайд байрлана.
- Ногооны талбай 15.588 га талбайд байрлана.
- Амралт зугаалгын бүс газрыг 0.577 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 33.301 га талбайд байрлана.



Зураг №3.24. Мөрөн сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Хатгал тосгон

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 169.88 га газар, нөөц нь 21.27 га газар байна.
- Гэр орон сууцны бүс газар. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 253.64 га, нөөц нь 271.04 га талбай байна.
- Үйлдвэр аж ахуйн бүсийг 68.95 га талбайд төлөвлөв. Тус бүсэд байгуулах боломжтой үйлдвэрүүдэд
 - ✓ Сүү цагаан идээ боловсруулах үйлдвэр
 - ✓ Ахуйн үйлчилгээний цэг
 - ✓ Загас үржүүлэх, олборлох үйлдвэр
 - ✓ Гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүний цех
 - ✓ Уламжлалт зан заншил өв уламжлалыг харуулсан отогуудыг бий болгох
- Онгоцны буудал 61.13 га талбайд байрлана.
- Хогийн цэг 2.38 га талбайд байрлана.
- Амралт зугаалгын бүс 13.52 га талбайд байрлана.
- Оршуулгын газар 8.05 га талбайд байрлана.



Зураг №3.25. Хатгал тосгоны газар ашиглалтын бүсчлэл

Хүснэгт №3.20. Хөвсгөл аймгийн сумдын төвийн газар ашиглалтын одоогийн байдал, төлөвлөлт

№	Сумдын нэр	Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжийн бүс	Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжийн бүсийн ноёд газар	Гэр орон сууцны бүс	Гэр орон сууцны ноёд газар	Үйлдвэр аж ахуйн бүс	Эрчимжсэн МАА хөгжүүлэх бүс	Онгоцны буудал	Ойи зурвас ногоон байгууламж	Зуслангийн газар	Хогийн цог	Ногооны талбай	Амралт зугаалгын бүс	Авто тээврийн үйлчилгээний газар	Оршуулгын газар	Нийт талбай /га-ар/
		0	1	2	3	4	5	6	7	10	11	12	13	14	16	
1	Алаг-Эрдэнэ	20.54	14.61	69.43	191.8	3.77					10.05			49.36	3.04	362.6
2	Арбулаг	24.76	4.85	34.49	59.69	4.12	1.87				29.1				0.79	159.67
3	Баянзүрх	17.66	13.54	77.3	80.05	8.06				38.55	2.24				4.5	241.9
4	Бүрэнтогтох	16.13	6.4	54.98	63.44	2.72	9.58				14.21		2.38		21.27	191.11
5	Галт	24.47	2.47	129.4	52.94	2.59	12.63				10.22	0.38	3.79		0.67	239.56
6	Жаргалант	19.77	7.84	130.59	135.67	10.31			115.77		19.11		0.73		2.65	442.44
7	Их-Уул	27.16	24.05	136.58	288.8	12.28			8.6		45.28	15.16		99		656.91
8	Рашаант	22.31	31.15	209.79	64.45	5.57					10.86	10.96	3.49		1.08	359.66
9	Ренчинлхүмбэ	24.97	6.3	263.32	520.79	7.19					6.74	0.95	2.2		3.6	836.06
10	Тариалан	60.02	4.08	369.61	762.19	13.23	6.22				7.01		1.86	40.62	12.49	1277.33
11	Тосонцэнгэл	14.06	13.05	96.28	65.46	14.64	15.62				16.39		0.85		20.56	256.91
12	Төмөрбулаг	15.37	2.96	51	57.6	3.61	4.66				29.92	0.88	0.59		14.05	180.64
13	Түнэл	12.38	6.17	163.23	720.076	297.83	887.37				16.98		1.44		4.52	2109.996
14	Улаан-Уул	19	18.79	139.58	169.86	8.41					14.6					370.24
15	Ханх	103.79	18.74	173.37	293.13	105.73	5.24				2.63		37.9		6.19	746.72
16	Цагааннуур	30.13	22.55	168.55	307.48	11.96					4.34	0.89	0.72		15.22	561.84
17	Цагаан-Уул	24.74	26.808	360.43	601.09	13.46	17.85		24.41		55.57		3.46		18.25	1146.068
18	Цагаан-Үүр	14.28	0.71	206.17	422.01	23.44	16.02				5				2.13	689.76
19	Цэцэрлэг	13.78	1.59	88.88	50.61	15.94					26.17				1.51	198.48
20	Чандмань- Өндөр	9.24	1.92	241.6	416	12.63	11.74				15.26		131.48		0.83	840.7
21	Шинэ-Идэр	22.89	1.32	45.27	75.23	2.6	6.69		0.44				0.95		1.46	156.85
22	Эрдэнэбулган	27.66	4.33	166.09	201.08	57.17					3.19					459.52
23	Мөрөн	371.08	1393.02	698.31	436.63	484.76		87.45	595.02		57.42	15.588	0.577		33.301	4173.156
24	Хатгал	169.88	21.27	253.64	271.04	68.95		61.13			2.38		13.52		8.05	869.86
	Нийт	1106.07	1648.518	4327.89	6307.116	1190.97	995.49	148.58	744.24	38.55	404.67	44.808	205.937	188.98	176.161	17527.98

Хүснэгт №3.21. Хөвсгөл аймгийн сумдын тэг гортигийн төлөвлөлт

№	Сум	Одоо байгаа тэг гортиг /га/	Нэмэгдэх талбай /га/	Төлөвлөж буй тэг гортиг /га/
1	Алаг-Эрдэнэ	370.749	89.443	460.192
2	Арбулаг	242.636	70.755	313.391
3	Баянзүрх	517.039	53.403	570.442
4	Бүрэнтогтох	515.363	214.117	729.48
5	Галт	792.413	-	792.413
6	Жаргалант	1466.319	244.466	1710.785
7	Их-Уул	652.115	354.155	1006.27
8	Рашаант	1272.967	455.167	1728.134
9	Ренчинлхүмбэ	1253.038	751.735	2004.773
10	Тариалан	902.483	343.8176	1246.3006
11	Тосонцэнгэл	556.715	174.379	731.094
12	Төмөрбулаг	169.742	91.699	261.441
13	Түнэл	650.304	369.8568	1020.1608
14	Улаан-Уул	701.448	111.167	812.615
15	Ханх	1233.079	1022.944	2256.023
16	Цагааннуур	777.114	-	777.114
17	Цагаан-Уул	865.462	501.655	1367.117
18	Цагаан-Үүр	561.231	146.496	707.727
19	Цэцэрлэг	471.732	284.417	756.149
20	Чандмань-Өндөр	627.801	59.542	687.343
21	Шинэ-Идэр	399.935	106.168	506.103
22	Эрдэнэбулган	419.145	230.277	649.422
23	Мөрөн	10212.006	-	10212.006
24	Хатгал	1452.483	-	1452.483
НИЙТ		27083.319	5675.6594	32758.9784

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**4.1. Зам, тээврийн газар****4.1.1. Зам, тээврийн сүлжээний өнөөгийн байдал**

Хөвсгөл аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллаар 2013 онд нийт зам шугам сүлжээний газрын хэмжээ 7784,90 га талбай байна. 2013 оны байдлаар авто замын газар 3199,76 га, агаарын тээврийн газар 151,05 га, шугам сүлжээний газар 4432,29 га байна. Нийтдээ зам шугам сүлжээний газрын хэмжээ 2003 онтой харьцуулахад 44 %-иар буюу 3396.2 га талбайгаар өссөн байна.

Хүснэгт №4.1. Зам шугам сүлжээний газрын талбай

Дэд ангилал	2013 он
Авто замын газар бүгд	3199,76
Төмөр замын газар бүгд	-
Агаарын тээврийн газар	151,05
Шугам сүлжээний газар	4432,29
Усан тээврийн газар бүгд	1
Бүгд	7784.90

Хөвсгөл аймгийн хувьд авто замын газрын талбайн өөрчлөлтийг 2003-2013 онтой харьцуулахад 34,06 га-аар буурсан байна. Энэ нь энгийн шороон зам болон, сайжруулсан шороон замын хэмжээ буурсантай холбоотой юм.

Хүснэгт №4.2. Автозамын газар ашиглалтын байдал (га)

Д/д	Аймаг	Автозамын газар, бүгд	Үүнээс			
			Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын зориулалттай	Авто тээврийн барилга, байгууламж, зогсоолын талбай
1	Хөвсгөл	3199,76	642,9	2343,46	211,7	1,7

Хөвсгөл аймаг нь Монгол улсын төвийн хойт хэсэг оршдог бөгөөд уул нуруу, гол мөрөн нутгийн бусад хэсэгтэй харьцуулахад ихтэй бөгөөд зам барьж байгуулахад нилээд хүнд нөхцөлтэй юм. Түүнээс гадна зам барьж байгуулахад Сэлэнгэ, Дэлгэрмөрөн, Эг, Тэс, Үүрийн гол зэрэг олон тооны том жижиг олон гол горхитой тул зам тавихад тэр бүгд дээр найдвартай төмөр бетон гүүр байгуулах шаардлага гардаг.

Хөвсгөл аймгийн нутгаар улсын болон орон нутгийн чанартай 5547 км авто зам дамжин өнгөрч байгаагаас улсын чанартай зам 1065 км, орон нутгийн чанартай зам 1848 км, сумаас баг хүртлэх 2834 км ердийн хөрсөн зам байна.

Аймгийн төвөөс 50 км дотор алслагдсан 2 сумтай, 100-150 км-д алслагдсан 1 тосгон 13 сумтай, 150 км-с цааш алслагдсан 8 сумтай байгаа юм.

Хөвсгөл аймгийн улсын чанартай замын Мөрөн-Хатгалын А1101 чиглэлийн 89,9 км хатуу хучилттай зам ашиглалтанд орсон.

Мөрөн-Булганы 180 км /253.3/ хатуу хучилттай автозам 2014 онд ашиглалтанд бүрэн орж, Улаанбаатар хот, Булган. Эрдэнэт, Дархан хотуудтай хатуу хучилттай замаар холбогдоно. Энэ чиглэлийн замтай давхцаж байгаа Их-Уул, Тосонцэнгэл сумууд хатуу

хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдоно. Хатуу хучилттай зам Тариалан сумаас 9 км зайтай өнгөрнө. Мөн Мөрөн-Хатгалын хатуу хучилттай авто замаас Алаг-Эрдэнэ сумын төв 7 км зайтай байна.

Ханх-Мондын замын 20.63, Мөрөнгийн төвийн Хилэнтийн 180.0, Түнэл сумын Эгийн голын 162.5, Галт сумын Идэрийн голын 162.9, Жаргалант сумын Идэрийн голын 163.1, Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөр бетон, Шишгэд, Хогоргын голын 150 у/м хөвдөг гүүрүүд баригдан ашиглалтанд оржээ.

Тус аймагт авто замыг хариуцан өвөл зуны аль ч улиралд тээврийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлж, зорчигч тээвэрчдэд, авто замаар саадгүй үйлчлэх үүрэгтэй зам засвар арчлалтын компани ажиллаж байна.

Мөрөн-Булган, Мөрөн-Улиастай, Мөрөн-Тэрхийн Цагааннуур улсын чанартай авто замын хөдөлгөөний эрчим жилд дунджаар 4-5 хувиар өсөж байна.

Хүснэгт №4.3. Хот хоорондын авто замын одоогийн байдал

Замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэл, нэр	Замын төрөл	Хүчин чадал /км/
A0902	Мөрөн – Булган чиглэл	Хатуу хучилттай	180.0
A1101	Мөрөн – Хатгал*	Хатуу хучилттай	103.0
A1101	Хатгал – Ханх*	Ердийн хөрсөн	180.0
A1101	Ханх – Монд /Улсын хил/	Ердийн хөрсөн	23.0
A1101	Мөрөн – Улиастай *	Ердийн хөрсөн	226.0
A18	Мөрөн / Тунамал нуурын ар – Баруун туруун – Улаангом/	Ердийн хөрсөн	139.0
	Мөрөн-Тэрхийн Цагаан нуур	Ердийн хөрсөн	214.0
Дүн	Улсын чанартай замын нийт урт		1065.0
	Үүнээс хатуу хучилттай		283.0

*УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Мянганы замын босоо тэнхлэгийн авто зам Улсын чанартай замын 26.5 хувь буюу 283 км нь хатуу хучилттай зам байна.

Хүснэгт №4.4. Сумуудын авто замын одоогийн байдал

№	Авто замын чиглэл	Нийт зай /км/	Хучилтын одоогийн байдал
1	Мөрөн-Бүрэнтогтох	45	Ердийн хөрсөн
2	Бүрэн тогтох-Цагаан- Уул	88	Ердийн хөрсөн
3	Цагаан-Уул –Цэцэрлэг сум	80	Ердийн хөрсөн
4	Цэцэрлэг сумаас-Залаагийн дөрөлж	60	Ердийн хөрсөн
5	Цагаан-Уул сумаас- Халзан согоот	93	Ердийн хөрсөн
6	Мөрөн-Төмөрбулаг	65	Ердийн хөрсөн
7	Мөрөн –Шинэ-Идэр	123	Ердийн хөрсөн
8	Шинэ-Идэр-Жаргал	57	Ердийн хөрсөн
9	Галт	177	Ердийн хөрсөн
10	Мөрөн-Тосонцэнгэл	64	Хатуу хучилттай
11	Тосонцэнгэл- Их уул	48	Хатуу хучилттай
12	Их-Уул -Тариалан	51	Хатуу хучилттай
13	Тариалан-Намнангийн ар	35	Хатуу хучилттай
14	Тосонцэнгэл сумаас Рашаант	65	Ердийн хөрсөн
15	Тариалан-Эрдэнэбулган	80	Ердийн хөрсөн
16	Эрдэнэбулган-Цагаан үүр	72	Ердийн хөрсөн
17	Мөрөн-Түнэл	46	Ердийн хөрсөн
18	Түнэл-Чандмань-Өндөр	88	Ердийн хөрсөн
19	Чандмань-Өндөр-Цагаан-Үүр	52	Ердийн хөрсөн
20	Мөрөн-Алаг-Эрдэнэ	62	Ердийн хөрсөн
21	Алаг-Эрдэнэ-Хатгал	37	Ердийн хөрсөн

22	Хатгал-Ханх	180	Ердийн хөрсөн
23	Мөрөн-Арбулаг	69	Ердийн хөрсөн
24	Арбулаг-Баянзүрх	55	Ердийн хөрсөн
25	Мөрөн-Улаан уул	167	Ердийн хөрсөн
26	Улаан-Уулаас -Ренчинлхүмбэ	40	Ердийн хөрсөн
27	Ренчинлхүмбэ-Цагааннуур	22	Ердийн хөрсөн
	Хатуу хучилттай	163	
	Ердийн хөрсөн	1848 км	

Сумдын 8.8 хувь болох 163 км буюу улсын чанартай замтай давхцсан хэсэг нь хатуу хучилттай замтай байна.

Хөвсгөл аймгийн зам тээврийн одоогийн байдлын SWOT шинжилгээ :

Давуу талууд :

- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудтай хатуу хучилттай замаар холбогдсон
- Шинээр байгуулах замын чиглэл нь тодорхой бөгөөд зарим чиглэлийн замын зураг төсөл хийгдсэн.
- Баруун аймгийн болон босоо тэнхлэгийн чиглэлийн зам дайран өнгөрдөг
- Улсын чанартай замууд нь сумуудыг аймагтайгаа холбосон замтай давхцдаг
- Автомашин болон замын хөдөлгөөний эрчим жил бүр нэмэгдэж байгаа
- Улсын чанартай замаар хэд хэдэн аймгийн төвүүдтэй холбогддог

Сул талууд :

- Нийслэл хотоос зайтай оршдог
- Зам байгуулахад уул даваа, гол мөрөн зэрэг бартаа саад ихтэй
- Хатуу хучилттай зам байгуулахад зардал өндөр
- Ажил гүйцэтгэхэд улирлын чанартай байдаг
- Аймгийн төв нь сумуудтайгаа шороон замаар холбогдсон.

Боломж :

- Замын бэлэн суурь баазтай
- Байгалийн зам барилгын материалтай элбэгтэй
- Мэрэгжлийн байгууллага, боловсон хүчинтэй

Аюул занал :

- Зам нь байгаль орчин бохирдуулах, бэлчээр сүйтгэх
- Зэрлэг ан амьтанд сөрөг нөлөөтэй
- Барьсан зам нь үеэр ус болон бусад байгалийн гэнэтийн аюулд өртөх магадлалтай
- Барьж байгуулахад байгалийн шалгуур өндөр


4.1.2. Зам тээврийн газрын төлөвлөлт

Авто зам

Хөвсгөл аймгийн авто замын хэтийн хэрэгцээг төлөвлөхдөө “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгүүдийг барьж дуусгах, бүсийн болон аймгийн төвүүдийг нийсэлтэй хатуу хучилттай замаар, дараагийн шатанд өөр хооронд нь холбох” гэсний дагуу хэтийн төлөвлөлтийг хийлээ. Үүнд :

Босоо тэнхлэгийн Мөрөнгөөс ОХУ-ын хилийн боомт хүртэл хатуу хучилттай зам барьж дуусгах, дараа нь Монгол улсын аялал жуулчлалын гол маршрут Мөрөнг-Тэрхийн Цагаан нуурын чиглэлийн хатуу хучилттай замтай холбох ажлыг гүйцэтгэх, улмаар босоо

тэнхлэгийн нэг хэсэг болох Мөрөн-Улиастай чиглэлийн авто замыг барихаар төлөвлөлөө. Ингэснээр зөвхөн хот хоорондын зам хатуу хучилттай болоод зогсохгүй тухайн чиглэл давхцаж байгаа сумууд хатуу хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдоно. Мөн Хөвсгөл болон Завхан аймгийн нүүрсний хэрэгцээг хангадаг Могойн голын уурхайг хатуу хучилттай болгохоор төлөвлөв. Мөн Тосонцэнгэл – Рашаант-Хайрхан –Өлзийт чиглэлийн зам баригдснаар Мянганы замын хэвтээ тэнхлэгийн замтай холбогдож дээр дурьдсан зорилтууд хэрэгжинэ.



Зураг№4.1. Авто замын газрын төлөвлөлтийн зураг

Хүснэгт№4.5. Хатуу хучилттай авто замын 2015-2030 хэтийн төлөвлөлт

№	Одоогийн байгаа зам	Хэрэгцээ	Төлөвлөлт		
			2015- 2020	2021-2025	2026-2030
1	Мөрөн – Булган чиглэл	Нийслэл болон Дархан, Эрдэнэт хотуудтай хатуу хучилттай замаар 2014 онд холбогдсон байна.			

2	Мөрөн - Хатгал	Хатуу хучилттай замтай			
3	Хатгал – Ханх – Улсын хил*	ОХУ-БНХАУ-ыг холбох Монд-Ханх-Хатгал-Мөрөн-Улиастай-Алтай-Бургастайн олон улсын босоо тэнхлэгийн зам.			
4	Мөрөн – Улиастай *	ОХУ-БНХАУ-ыг холбох Монд-Ханх-Хатгал-Мөрөн-Улиастай-Алтай-Бургастайн босоо тэнхлэгийн зам, энэ замаар Могойн голын нүүрс Хөвсгөл, Завхан аймгууд руу тээвэрлэхээс гадна аймаг хоорондын аялал жуулчлалын хөгжүүлэхэд чухал үүрэгтэй			
5	Мөрөн-Тэрхийн Цагаан нуур	Аялал жуулчлалын гол зам Хөвсгөл нуурыг Тэрхийн цагаан нуурын аялал жуулчлалын бүстэй холбоно			
6	Мөрөн-Улиастайн замтай Могойн голын нүүрсний уурхайг хатуу хучилттай замаар холбох	Могойн голын нүүрсийг Хөвсгөл, Завхан аймгууд руу тээвэрлэх, энэ зам тавигдснаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.			
7	Тосонцэнгэл – Рашаант-Хайрхан – Өлзийт**	Хөвсгөл аймгийг Монгол улсын хэвтээ тэнхлэгийн замтай холоно.			

*Монгол улсын УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Мянганы замын болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийн зам.

**Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан концессийн гэрээгээр хэрэгжүүлэх төсөл.

Хүснэгт №4.6. 2015-2030 онд шинээр баригдах хатуу хучилттай авто замуудын зай, хөрөнгө оруулалт

№	Замын нэр	Хучилтын төрөл	Нийт зай, км	Хөрөнгө оруулалт тэрб.төг
	2015-2020 он			
1	Хатгал-Ханхын А1101 чиглэл	Хатуу хучилттай	180.0	126.0
2	Ханх- Мондын А1101 чиглэл /Улсын хил/	Хатуу хучилттай	23.0	13.8
3	Мөрөн сумын доторх зам	Хатуу хучилттай	10.0	4.3
4	Хатгал тосгоны доторх зам	Хатуу хучилттай	5.0	2.1
5	Мөрөн-Хилэнтийн гүүр	Хатуу хучилттай	5.0	2.1
6	Тосонцэнгэл-Рашаант-Хайрхан-Өлзийт чиглэл* /концесс/	Хатуу хучилттай	96	60.0
			319.0	208.3
	2021-2025 он			
7	Мөрөн-Тэрхийн цагаан нуур	Хатуу хучилттай	204.0	105.0
8	Мөрөн сумын доторх зам	Хатуу хучилттай	10.0	4.2
			214.0	149.2
	2026-2030 он			
9	Мөрөн- Согоотын давааны А1102 чиглэл	Хатуу хучилттай	226.0	113.0
10	Мөрөн- Согоотын давааны замаас – Могойн голын уурхай	Хатуу хучилттай	30.0	15,0
			256.0	128.0
	Бүгд		789.0	485.5

*Засгийн газрын 2013 оны 317 тогтоол Төрийн өмчийн концессийн жагсаалт батлах тухай тогтоол

Хүснэгт №4.7. Замын зурвас газрын тооцоо

№	Автозамын чиглэл	Замын нэр	Замын урт /км/	Замын зурвас газрын талбай /га/
1	A1101	Хатгал-Ханх	180.0	360.0
2	A1101	Ханх-Улсын хил	23.0	46.0
3		Мөрөн сумын доторх зам	10.0	10.0
4		Хатгал тосгоны доторх зам	5.0	5.0
5		Мөрөн-Хилэнтийн гүүр	5.0	10.0
6		Тосонцэнгэл-Рашаант-Хайрхан-Өлзийт	96.0	192.0
7		Мөрөн-Тэрхийн Цагааннуур	204.0	408.0
8		Мөрөн сумын доторх зам	10.0	10.0
9	A1102	Мөрөн- Согоотын даваа	226.0	452.0
10		Мөрөн- Согоотын замаас - Могойн голын уурхай	30.0	60.0
			789	1553.0

Хатуу хучилттай замын зурвас газрыг тооцоходоо замын өргөнийг үер усны хамгаалалтын далангийн хамт 20 м тооцож хийлээ.

Цаашид Сэлэнгэ мөрний Сацын булангийн 253.3, Идэр Чулуутын голын 120.0, Мөрөнгийн голын 120.0, Улаан-Уулын Багтагийн голын 100.0, Хөгийн голын 70.0, Баянзүрх сумын Бэлтэсийн голын 78.0 зэрэг у/м төмөр бетон гүүрийг барих шаардлагатай байгаа юм.

Мөрөн сумын төвд 2014 онд 8 тэрбум орчим төгрөгийн санхүүжилтээр 6.6 км хатуу хучилттай зам баригдаж байна.

Эхний үе шат буюу 2015-2020 онд A1101 чиглэлийн Хатгал-Ханхын 180 км, Ханх улсын хил хүртлэх 23 км буюу 203 км автозамыг хатуу хучилттай болгох ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Энэ зам баригдснаар Ханх сум хатуу хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдоно. Нөгөөтэйгүүр Ханх-Мондын чиглэлээр ОХУ-тай хатуу хучилттай замаар хилийн гарцтай болж, ачаа, зорчигч тээвэр явагдах боломжтой болж байна. Ингэснээр Хөвсгөл нуурын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Байгаль нуурт ирсэн жуулчид Хөвсгөл нуурт ирж амрах, Мөрөн орж улмаар Монгол улсын төв хэсгээр аялахад хялбар болно.

Тосонцэнгэл-Рашаант-Хайрхан-Өлзийт чиглэлд концессоор хатуу хучилттай авто зам барих төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж концесс зарлагдаад байна. Энэ төсөл хэрэгжснээр Хөвсгөл аймгийг Монгол улсын хэвтээ тэнхлэгийн замтай холбогдоно. Тосонцэнгэл- Рашаант-Хайрхан-Өлзийт гэсэн маршрут гарч байгаа бөгөөд энэ нь мянганы замын хэвтээ тэнхлэгийн замтай нийлэх юм. Энэ зам баригдснаар Рашаант, Хайрхан зэрэг сумуудын тариаг хаягдалгүй Мөрөнгийн гурилын үйлдвэрт зөөх нөхцөл бүрдэнэ.

Хоёрдугаар үе шат буюу 2021-2025 онд Мөрөн-Цэцэрлэг 204 км замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөж байна. Мөрөн-Цэцэрлэг 204 км замыг барьж ашиглалтанд оруулснаар улсын хэмжээний аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд Хөвсгөл, Тэрхийн Цагаануурыг холбосон аялал жуулчлалын маршрут бий болно. Хөвсгөл нуураар аяласан жуулчид Архангай аймгийн Хорго, Тэрхийн Цагааннуур, Чулуут

гол зэрэг газруудаар аялах бололцоотой болно. Дээрх зам нь Монгол улсын аялал жуулчлалын гол зам болж хөгжинө.

Мөн энэ зам баригдснаар Шинэ-Идэр, Жаргалант сумын төвүүд хатуу хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдох ба Төмөрбулаг сумын төв 40 км, Галт сумын төв баригдах хатуу хучилттай замаас 35 км тус тус зайтай байхаар төлөвлөгдөж байна.

Гуравдугаар үе шат буюу 2025-2030 онд А1102 чиглэлийн Мөрөн –Улиастай чиглэлийн зам ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна. Ингэснээр Ханх-Мөрөн-Улиастай-Алтай-Бургастай гэсэн Монгол улсын нутгийн төв хэсгээр дайрсан ОХУ-Монгол-БНХАУ-ыг холбосон босоо тэнхлэгийн замтай болно. Мөн тус зам баригдснаар Могойн голын нүүрсийг Мөрөн, Тосонцэнгэл, Улиастай руу зөөхөд хялбар болгохоос гадна Хөвсгөл, Завхан аймгууд аялал жуулчлалыг аймаг дамжуулан хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалахад нэн чухал ач холбогдолтой байх болно. Мөрөн-Улиастай чиглэлийн зам баригдснаар Бүрэнтогтох, Цагаан уул сумууд хатуу хучилттай замаар холбогдох боломжоор хангагдах бөгөөд Цэцэрлэг сумын төвөөс 68 км, зайтай хатуу хучилттай зам өнгөрөнө. Хатуу хучилттай зам дайрах Согоот баг Могойн голын уурхайн хооронд 30 км замыг хатуу хучилттай болгоно. Энэ зам баригдснаар Завхан аймгийн Тэлмэн суманд баригдах дулааны цахилгаан станц болон Хөвсгөл, Завхан аймгууд хэрэгцээт нүүрсээ хатуу хучилттай замаар тээвэрлэдэг болж байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.

Харин Улаангом чиглэлийн 139 км хатуу хучилттай зам буюу Тунамал нуурын араас цааш тавих шаардлага бараг харагдахгүй байна. Энэ замаар тээх ачаа, зорчигчдын урсгал бага байхаар байна. Яагаад гэвэл хатуу хучилттай зам Мөрөнгөөс шууд Улаангом чиглэлийн хатуу хучилттай замтай холбогдож байгаа тул ачаа, зорчигчдын урсгал түүгээр явах нь ойлгомжтой байна. Тиймээс тус замыг 2030 оноос цааш хатуу хучилттай болгох нь шаардлагатай гэж үзэв.

2030 онд тус аймгийн 22 сумаас 7 сумын төв / Тосонцэнгэл, Их-Уул, Ханх, Бүрэнтогтох, Цагаан-уул, Шинэ-Идэр, Жаргалант болон Хатгал тосгон/ нь хатуу хучилттай замаар аймгийн төвтэйгээ холбогдсон байхаас гадна Алаг-Эрдэнэ, Тариалан, Цэцэрлэг, Төмөрбулаг, Галт, зэрэг сумын төвүүд төлөвлөгдөж байгаа хатуу хучилттай замаас ойролцоогоор 7-68 км зайтай байхаар байна.

Хүснэгт №4.8. Сумуудын авто зам 2030 оны байдлаар

№	Авто замын чиглэл	Нийт зай /км/	Хучилтын одоогийн байдал	2030 онд байх хучилтын төрөл
1	Мөрөн-Бүрэнтогтох	45	Ердий хөрсөн	Хатуу хучилттай
2	Бүрэн тогтох-Цагаан- Уул	88	Ердийн хөрсөн	Хатуу хучилттай
3	Цагаан-Уул –Цэцэрлэг сум	80	Ердийн хөрсөн	68 км хөрсөн
4	Цэцэрлэг сумаас-Залаагийн дөрөлж	60	Ердийн хөрсөн	
5	Цагаан-Уул сумаас- Халзан согоот	93	Ердийн хөрсөн	Хатуу хучилттай
6	Мөрөн-Төмөрбулаг	65	Ердийн хөрсөн	40 км хөрсөн
7	Мөрөн –Шинэ-Идэр	123	Ердийн хөрсөн	Хатуу хучилттай
8	Шинэ-Идэр-Жаргал	57	Ердийн хөрсөн	Хатуу хучилттай
9	Галт	177	Ердийн хөрсөн	35 км хөрсөн
10	Мөрөн-Тосонцэнгэл	64	Хатуу хучилттай	Хатуу хучилттай
11	Тосонцэнгэл- Их уул	48	Хатуу хучилттай	Хатуу хучилттай
12	Их-Уул -Тариалан	51	Хатуу хучилттай	Хатуу хучилттай

13	Тариалан-Намнангийн ар	35	Хатуу хучилттай	Хатуу хучилттай
14	Тосонцэнгэл сумаас Рашаант	65	Ердийн хөрсөн	Хатуу хучилттай
15	Тариалан-Эрдэнэбулган	80	Ердийн хөрсөн	
16	Эрдэнэбулган-Цагаан үүр	72	Ердийн хөрсөн	
17	Мөрөн-Түнэл	46	Ердийн хөрсөн	
18	Түнэл-Чандмань-Өндөр	88	Ердийн хөрсөн	
19	Чандмань-Өндөр-Цагаан-Үүр	52	Ердийн хөрсөн	
20	Мөрөн-Алаг-Эрдэнэ	62	Ердийн хөрсөн	7 км хөрсөн
21	Алаг-Эрдэнэ-Хатгал	37	Ердийн хөрсөн	
22	Хатгал-Ханх	180	Ердийн хөрсөн	Хатуу хучилттай
23	Мөрөн-Арбулаг	69	Ердийн хөрсөн	
24	Арбулаг-Баянзүрх	55	Ердийн хөрсөн	
25	Мөрөн-Улаан уул	167	Ердийн хөрсөн	
26	Улаан-Уулаас -Ренчинлхүмбэ	40	Ердийн хөрсөн	
27	Ренчинлхүмбэ-Цагааннуур	22	Ердийн хөрсөн	
	Үүнээс хатуу хучилттай	849		
	Ердийн хөрсөн	1172		

2030 он гэхэд орон нутгийн нийт 2021 км замын 849 км буюу 42.0 хувь нь хатуу хучилттай болж 1172 км нь шороон зам хэвээр байна.

Хүснэгт №4.9. 2015-2030 оны хооронд засаж сайжруулах орон нутгийн замууд

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ /км/	төрөл	Хэрэгжүүлэх шалтгаан	Хөрөнгийн хэмжээ, /сая төг/, эх үүсвэр	2015-2020	2021-2025	2026-2030
1	Мөрөн-Хатгалын замаас Алаг-Эрдэнэ рүү зам тавих	9.6	Хатуу хучилттай	Аялал жуулчлалыг хөгжүүлэх	500.0, Улсын төсөв			
2	Төмөрбулаг Гахайн давааг засах	13.4	Сайжруулсан шороон зам	Ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах	10.0 Орон нутгийн төсөв			
3	Ханх сум руу тавих хатуу хучилттай замыг Булнайн рашаанаар дайруулах /Чандмань-Өндөр/	42.4	Сайжруулсан шороон зам	Аялал жуулчлалыг хөгжүүлэх Чандмань	40.0 Улсын төсөв			
4	Дархинтын эхний замын бартааг засах /Чандмань-Өндөр/	26,4	Сайжруулсан шороон зам	Ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах	15.0 Орон нутгийн төсөв			
5	Өрх, Гархи орчмын замын бартааг засах /Чандмань-Өндөр/	25,8	сайжруулах	Ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах	15.0 Орон нутгийн төсөв			
6	Хужиртын давааны замыг засах /Цэцэрлэг сум/	5.3	сайжруулах	МАА, отор нүүдлийн зам	5.0 Орон нутгийн төсөв			
7	Харганын давааны замыг засах	14.7	сайжруулах	МАА, отор нүүдлийн зам	8.0 Орон нутгийн төсөв			

	/Цэцэрлэг сум/							
8	Алтан хөлийн давааны замыг засах /Цэцэрлэг сум/	6.2	сайжруулах	МАА, отор нүүдлийн зам	5.5 Орон нутгийн төсөв			
9	Эрдэнэбулган Тариалангийн замыг засах	76	Сайжруулсан шороон зам	Сум хоорондын зам	70.0 Орон нутгийн төсөв			
10	Эрдэнэбулган-Чандмань-Өндрийн замыг засах	88.4	Сайжруулсан шороон зам	Сум хоорондын зам	70.0 Орон нутгийн төсөв			
11	Эрдэнэбулган Цагаан-Үүрийн замыг засах	64.7	Сайжруулсан шороон зам	Сум хоорондын зам	60.0 Орон нутгийн төсөв			
12	Эгийн голын урдуурх замыг засах /Эрдэнэбулган сум/	27.4	сайжруулах	Отор нүүдэл, хадлан бэлчээр, ойн арчилгаа хийх	20.0 Орон нутгийн төсөв			
13	Үүрийн голын дагуу замын бартааг засах	62.1	сайжруулах	Шинэ бэлчээр ашиглах	50.0 Орон нутгийн төсөв			
14	Хэвэн голын бартааг засах	18.2	сайжруулах	Шинэ бэлчээр ашиглах	15.0 Орон нутгийн төсөв			
15	Ажигийн бэлчирийн замын бартааг засах	40.2	сайжруулах	Шинэ бэлчээр ашиглах	35.0 Орон нутгийн төсөв			
16	Цагаан бэлчэрийн нуур орчмын замын бартааг засах	20.1	сайжруулах	Отор нүүдэл, хадлан, ойн арчилгаа	20.0 орон нутгийн төсөв			
17	Армагийн эхийн замыг засах	45.4	сайжруулах	Отор нүүдэл, хадлан, ойн арчилгаа	35.0 орон нутгийн төсөв			
18	Чандмань-Өндөр Цагаан-үүрийн замыг засах	16.4	сайжруулах	Сум хоорондын зам	16.0 орон нутгийн төсөв			
19	Баян голын бартааг засах	18.3	сайжруулах	Бэлчээр ашиглалтыг сайжруулах	15.0 орон нутгийн төсөв			
20	Цагаан-Үүр Даяндээрхийн замыг засах	14.2	Сайжруулсан шороон зам	Аялал жуулчлалыг хөгжүүлэх	15.0 орон нутгийн төсөв			
21	Нарийн Дархинтын замыг засах	16.6	Сайжруулах	Бэлчээр ашиглалтыг сайжруулах	15.0 орон нутгийн төсөв			
22	Бэрхийн замын бартааг засах	5.3	Сайжруулах	Бэлчээр ашиглалтыг сайжруулах	5.0 орон нутгийн төсөв			
23	Гулзгай, Бадарын эхний замыг засах	22.8		Бэлчээр ашиглалтыг сайжруулах	20.0 орон нутгийн төсөв			

24	Жанхай-Тойлогт-Жиглэгийн даваа-Рэнчинлхүмбэ-Дархадын хотгор	150	Сайжруулах		40.0 орон нутгийн төсөв			
						724.5	160.0	195.0

Энэ хугацаанд орон нутгийн 1079.5 сая төгрөгөөр орон нутгийн замыг сайжруулна.

Хүснэгт №4.10. 2015-2030 оны хооронд орон нутагт барьж байгуулах гүүрүүд

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ /км/	төрөл	Хэрэгжүүлэх шалтгаан	Хөрөнгийн хэмжээ, /сая төг/, эх үүсвэр	2015-2020	2021-2025	2026-2030
1	Сэлэнгэ мөрөний гүүр Их-Уул сум	141 у/м	Төмөр бетон	Голын урд нутагладаг иргэдийн нийгмийн үйлчилгээг хүргэх	2200.0 Улсын төсөв			
2	Сэлэнгэ мөрөний гүүр Их-Уул сум	183 у/м	Төмөр бетон	Голын урд нутагладаг иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх	3500.0 Улсын төсөв			
3	Эгийн голын гүүр Түнэл сум	78 у/м	Төмөр бетон	Эгийн голын хойт хэсгээр нутагладаг иргэдийн нийгмийн үйлчилгээ хүргэх	1100.0 Улсын төсөв			
4	Эг-үүрийн бэлчир /Үүрийн гол Эрдэнэбулган /	153 у/м	Төмөр бетон	Цагаан-Үүр сумтай холбогдох, Аялал жуулчлал хөгжүүлэх, МАА-д үйлчлэх	2600.0 Улсын төсөв			
5	Сэлэнгэ мөрөний Сацын булангийн т/б гүүр /Рашаант сум/	253.3 у/м	Төмөр бетон	иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх	5500.0 Улсын төсөв			
6	Идэр чулуутын гүүр	120 у/м	Төмөр бетон	Рашаант сумыг аймгийн төвтэй холбох	2400.0 улсын төсөв			
7	Мөрөнгийн голын гүүр	120 у/м	Төмөр бетон	иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх	2400.0 улсын төсөв			
8	Улаан-Уул сумын Багтагийн голын гүүр	100 у/м	Төмөр бетон	иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх	2100.0 улсын төсөв			
9	Хөгийн голын гүүр	70 у/м	Төмөр бетон	иргэдэд нийгмийн үйлчилгээг	1000.0 улсын төсөв			

				хүргэх				
10	Баянзүрх сумын Бэлтэс голын гүүр	78 у/м	Төмөр бетон	иргэдэд нийгмийн үйлчилгээг хүргэх	1100.0 Улсын төсөв			
					23900.0			
				2015-2020	9200.0			
				2021-2025	9100.0			
				2026-2030	5600.0			

2015-2030 онд 23900.0 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дээрх гүүрүүдийг барьж байгуулна.

2015-2030 оны хооронд 789 км хатуу хучилттай авто замыг баригдаж нийт хатуу хучилттай замын урт 1072 км болж 2014 оныхоос 2030 онд 3.8 дахин нэмэгдсэн байна.

2030 он гэхэд Мөрөн нь баруун босоо тэнхлэгийн хатуу хучилттай зам болон Цэцэрлэг, Улиастай, Булган болон тус улсын бусад аймгийн төвүүдтэй хатуу хучилттай замаар бүрэн холбогдсон байна. Нөгөөтэйгүүр тус аймгийн Могойн голын уурхай хатуу хучилттай замтай болно. Ингэснээр ачаа тээвэр, зорчигчдын урсгал түргэн шуурхай болж цаг хугацаа хэмнэхээс гадна ердийн хөрсөн замтай байх үед замын тоос шороонд дарагдан, хөрс их хэмжээгээр эвдэрч, ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, байгаль-экологи их хэмжээгээр сүйтгэгдэж байсан байдал арилж байгаль экологид эерэг нөлөө үзүүлэх болно. Авто замд оруулсан хөрөнгө оруулалт экосистемийг сүйтгэсэн хохирлыг бууруулах зардалтай харьцуулахад 30 дахин бага юм. Мөн Бүрэнтогтох, Цагаан –Уул, Шинэ-Идэр, Жаргал, Тосонцэнгэл, Тариалан, Рашаант, Хатгал, Ханх зэрэг сумдын төв аймгийнхаа төвтэй хатуу хучилттай замтай болох ба зарим сумдын төв хатуу хучилттай замаас салаалан хүрдэг болж ердийн хөрсөн замаар явах хэмжээ эрс багасах болно.

Улсын чанартай хатуу хучилттай замын 2015-2030 оны өсөлт

Он	2015	2020	2025	2030
Хатуу хучилттай замын урт /км/	283	602	816	1072

Агаарын тээвэр

Мөрөн хотын нисэх буудал нь хатуу хучилттай нисэх буух зурвастай. Хуучин тус аймгийн бүх сумуудад бага оврын нисэх онгоц хүлээн авах буудалтай байсан ба одоо Хатгал тосгоны ердийн хөрсөн нисэх буух зурвастай буудал хаяхан ашиглагдаж байгаа ба бусад нь ашиглагдахгүй байна.

Хөвсгөл аймгийн нисэх буудлын одоогийн байдлын SWOT шинжилгээ :

Давуу талууд :

Мөрөн сумын нисэх буудал нь хатуу хучилттай нисэх буух зурвастай

Нисэх буух зурвасыг өргөтгөх боломжтой

Сул талууд :

Хатгалийн нисэх буудал нь нисэх буух зурвас нь шороон зурвастай

Олон улсын нислэг хүлээн авахгүй

Боломж :

Мэрэгжлийн байгууллага, боловсон хүчинтэй

Өргөтгөн олон улсын нислэг хүлээн авах

Аюул занал :

Өндөр уул нурууд зэрэг байгалийн онцлогтой

2015-2020 онд Мөрөн хотын нисэх буудлыг олон улсын нисэх онгоц хүлээн авах боломжтой болгохын тулд нисэх буудлыг өргөтгөн шинэчилнэ.

2015-2020 онд Мөрөнгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж олон улсын нисэх онгоц хүлээн авах боломжтой болгоно. 10 км хатуу хучилттай нисэх буух зурвасыг 4.260 тэрбум төгрөгөөр барьж байгуулна.

Төмөр зам

Хөвсгөл аймагт одоогийн байдлаар барьж ашигласан төмөр зам байхгүй.

Хөвсгөл аймгийн нутгаар төмөр зам байгуулах SWOT шинжилгээ :

Давуу талууд :

Баруун аймгуудын төмөр зам дамжин өнгөрөх гол зам болох боломжтой.

Сул талууд :

Төмөр зам ашиглаж байсан туршлагагүй

Боломж :

Аюул занал :

Бартаа саад ихтэй буюу байгалийн нөхцөл /уул даваа, гол мөрөн ихтэй/ хүнд

УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоол гарч төмөр замын хөгжлийн бодлогыг тодорхойлсон. Тус бодлогын “1.2.1.3.Төмөр замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээтэй болох” гэж заасан билээ. Тус бодлогын хавсралтанд Эрдэнэт-Булган-Мөрөн-Цагаанхайрхан-Улаангом гэсэн чиглэлээр төмөр зам алс хэтдээ тавихаар тусгасан.

Төмөр зам тавих асуудал нь тухайн бүс нутагт байгаа ачаа урсгал, зорчигч тээврээс ихээхэн хамааралтай юм. Иймд тухайн нутагт ашигт малтмалын ямар нэг төсөл хэрэгжсэн тохиолдолд хэрэгжихээр байгаа юм. Одоогоор хэдэн оноос хэрэгжүүлэх гэдгийг хэлэхэд нилээд бэрхшээлтэй байна. Иймээс баригдах хугацааг тааж тавиагүй бөгөөд дээрх чиглэлийн авто замын дагуу байгуулана гэж үзээд байгуулах замын урт, өртөөний тоо болон түүнд ашиглах шаардлагатай газрын хэмжээг тооцон гаргалаа. Шаардагдах хөрөнгийн тооцоог хийгээгүй болно. Хэрвээ 1 км төмөр зам тавихад ойролцоогоор 5 сая доллар гэж үзвэл 3 тэрбум гаруй доллар болно дээрээс нь өртөө зөрлөгүүд барих гээд өртөг нь асар их нэмэгдэх юм.

Хүснэгт №4.11. Хөвсгөл аймагт баригдах төмөр замын зурвас газрын тооцоо

Чиглэл	Нийт урт	Үүнээс өртөөний урт /км/	Замын зурвас газар /га/	Өртөөний Тоо /ш/	Өртөөний газар /га/
Булган-Хөвсгөлийн хил	162	10	1824	5	300

Хөвсгөлийн зүүн хилээс-Мөрөн	186	12	2088	6	360
Мөрөн-Баруун хил	261	14	2964	7	420
	609	36	6876	18	1080

Тайлбар : Өртөөний газрыг 2 км урт, 300 м өргөнөөр төмөр замын зурвас газрын өргөнийг 120 м төлөвлөв.

Дээрх тооцоогоор Хөвсгөл аймагт төмөр замд замын зурвас газарт 6876 га, өртөөнд 1080 га нийт 7956 га газар нэмж ашиглагдахаар байна.

Усан замын тээвэр

1900 оны эхээр Оросын худалдаачид Ханхын чиглэлээр худалдаа хийдэг байсан бөгөөд түүхий эд, ангийн үс, мал, мах тээвэрлэхэд ашиглах зорилгоор 1905 оноос Хөвсгөл нуурын байгалийн байдал, салхины зонхилох чиглэл үргэлжлэх хугацаа , давалгааны хэмжээ, зогсоол барих байршил, замын зураг, чиглэл зэрэгт судалгаа хийж, дүгнэлт гарган 40 тн-ы даацтай 75 морины хүчтэй, уурын хөдөлгүүрт онгоцыг барьж байгуулаад 1910 онд ашиглалтад оруулж байсан байна.

Манай улсын усан замын нийт урт 400 км, үүнээс Ханх-Хатгалын чиглэл 124 км-ийг эзлэнэ. Манай орны нөхцөлд усан замыг гол төлөв аялал жуулчлалын зориулалтаар ашиглах бодлого баримталж байгаа бөгөөд улсаас түүний хяналт зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд Хөвсгөлийн Хатгал тосгонд усан замын хяналт зохицуулалтын байрыг ашиглалтанд оруулсан.

Хүснэгт №4.12. Хөвсгөл усан замын тээвэрлэлтийг хүснэгтээр харуулбал

Үзүүлэлт	2003	2004	2010	2011
Тээвэрлэгдсэн ачаа /мян.тн/	11,0	8,0	0	0,1
Зорчигч эргэлт/хүний тоо/	800	410	950	2100

Хүснэгтээс харахад Усан замын тээврээр ачаа тээврийн үйлчилгээ зогсонги байдалд, зорчигч тээврийн үйлчилгээ нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байна. Энэ нь Хөвсгөл нуурын орчимд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж, жил бүр “Мөсний баяр”, “Цаатан фестиваль”, “Олон улсын тэшүүрийн марафон” зэрэг арга хэмжээг зохион байгуулсантай холбоотой. Бүрэн бус мэдээгээр нуурын орчимд 40 гаруй жуулчны бааз, отог, гэр буудал, амралт ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 105 дугаар тогтоолоор Хөвсгөл-Байгаль нуурын бүсэд аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр баталсан нь зорчигчдын болон жуулчдын тоо өсөх хандлага нэмэгдсэн байна.

Хөвсгөл аймгийн усан замын одоогийн байдлын SWOT шинжилгээ :

Давуу талууд :

Усан замын тээвэр ашиглаж байсан туршлагатай

Сул талууд :

Үйл ажиллагаа нь улирлын чанартай

Зөвхөн аялал жуулчлалын зориулалтаар ашиглагддаг

Боломж :

Мэрэгжлийн байгууллага, боловсон хүчинтэй

Аюул занал :

Тоног төхөөрөмж муутай

2015-2020 онд Ханх тосгонд усан замын хяналт зохицуулалтын байрыг ашиглалтанд оруулна.

4.2. Шугам сүлжээний газрын өнөөгийн байдал**4.2.1. Шугам, сүлжээний газрын өнөөгийн байдал**Цахилгааны шугам сүлжээ, үйлдвэрлэлийн байгууламж

Хөвсгөл аймаг нь төвийн бүсийн эрчим хүчний системд багтдаг ба 23 сум нь дотоодын төвлөрсөн цахилгаан хангамжийн системд өндөр хүчдэлийн ЦДАШ-д холбогдсон. Ханх сум ОХУ-ын хил орчмын эрчим хүчний системээс эрчим хүчээ авдаг байна.

Аймгийн хэмжээнд 2013 оны байдлаар эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай 3687.7 га байна.

Хүснэгт №4.13. Хөвсгөл аймгийн цахилгаан хангамжийн судалгаа 2013 оны байдлаар

№	Аймгийн нэр	Нийт сумдын тоо	Дотоодын төвлөрсөн цахилгаан хангамжийн системд өндөр хүчдэлийн ЦДАШ-р холбогдсон сумд	Нар салхины эрчим хүчний станцаар хангагдаж буй сумд	ОХУ, хил орчмын эрчим хүчний системд ЦДАШ-р холбогдсон сумд	Төвлөрсөн цахилгаан хангамжинд холбогдоогүй дан ганц Дизель станцаар хангагдаж буй сумд	Тайлбар
1	Хөвсгөл	24	23	-	1	-	23 сум ТЭХС-д холбогдсон. Ханх сум ОХУ-ын ЭХС-д 10 кВ-ын ЦДАШ-р холбогдсон.

Эх үүсвэр "УГЗБЕТ-нөөс"

Доорхи хүснэгтэд Хөвсгөл аймгийн 24 сумдын эрчим хүчний эх үүсвэр, ашиглалтанд орсон хугацаа, шугамын төрөл, шугамын урт, хүчин чадал, хөрөнгө оруулалт зэргийг тусгаж өгсөн болно.

Хүснэгт №4.14. Хөвсгөл аймгийн цахилгаан шугам сүлжээ

№	Сумдын нэрс	Эх үүсвэр	Ашиглалтанд орсон хугацаа	Хүчин чадал	Хөрөнгө оруулалт /сая ₮/
1	Тариалан	Хутаг-Өндөр сумаас 35кВ-ын 60км ЦДАШ	1997	35/10кВ-ын 1х2,5 МВА дэд станц	220
2	Эрдэнэбулган	Тариалан сумаас 15кВ-ын 76,4км ЦДАШ, Эрдэнэбулганы УЦС	2008	15/0,4кВ-ын 1*0,1, 1х0,16МВА дэд станц, Эрдэнэбулганы УЦС 200 кВт	960
3	Цагаан үүр	Чандмань-Өндөр сумаас 15кВ-ын ЦДАШ	2008	15/0,4кВ-ын 1х0,16, 1х0,1 МВА дэд станц	1268
4	Их уул	Тариалан сумаас 10кВ-ын 45,4км ЦДАШ	1997	10/0,4кВ-ын 1х0,25, 1х0,1МВА дэд станц	134.7
5	Рашаант	Цэцэрлэг хотоос сумаас 10кВ-ын 42,15км ЦДАШ	1998	10/0,4кВ-ын 1х0,16, 1х0,25 МВА дэд станц	109.6

6	Ханх	ОХУ-аас 10кВ-ын ЦДАШ	90-оноос өмнө баригдсан	10/0,4кВ-ын 1х0,16, 1х0,25 МВА дэд станц	
7	Чандмань-Өндөр	Хатгал сумаас 35кВ-ын 74,4км ЦДАШ	2008	35/10кВ-ын 1х0,63 МВА, 10/0,4кВ-ын 1х0,1, 1х0,16 МВА дэд станц	1268
8	Түнэл	Мөрөн хотоос 10кВ-ын 46,94км ЦДАШ	2005	10/0,4кВ-ын 1х0,63, 1х0,16 МВА дэд станц	239.76
9	Тосонцэнгэл	Булган аймгаас 110кВ-ын 0,5км ЦДАШ	2007	110/10кВ-ын 1х0,1 МВА дэд станц	93
10	Мөрөн	Булган аймгаас 110кВ-ын 291,85 км ЦДАШ	2004	110/35/6кВ-ын 1х0,63 МВА дэд станц	7852.2
11	Алаг-Эрдэнэ	Мөрөн сумаас 35кВ-ын 91,15км ЦДАШ	2008	35/15кВ-ын 1х0,16 МВА, 35/0,4кВ-ын 1х0,4 МВА дэд станц	1748
12	Төмөрбулаг	Тосонцэнгэл сумаас 10кВ-ын 57,9км ЦДАШ	2008	10/0,4кВ-ын 1х0,1, 1х0,16 МВА дэд станц	650
13	Рэнчинлхүмбэ	Улаан-Уул сумаас 15кВ-ын 67,62 км ЦДАШ	2009	15/0,4кВ-ын дэд станц 1х0,16МВА дэд станц	610
14	Галт	Жаргалант сумаас 10кВ-ын 59 км ЦДАШ, Нар салхин станц	2007	10/0,4кВ-ын дэд станц 1х0,1, 1х0,16 МВА, Нар салхин станц 3,3 кВт	620
15	Арбулаг	Мөрөн хотоос 35кВ-ын 64,7км ЦДАШ	2008	35/10кВ-ын 1х0,1МВА, 10/0,4кВ-ын 1х0,1, 1х0,16МВА дэд станц	1064.7
16	Бүрэнтогтох	Мөрөн хотоос 10кВ-ын 50,1 км ЦДАШ	2003	10/0,4кВ-ын 1х0,1,1х0,16 дэд станц	
17	Шинэ-Идэр	Жаргалант сумаас 10кВ-ын 49 км ЦДАШ	2005	10/0,4кВ-ын 1х0,1,1х0,16 МВА дэд станц	471.36
18	Жаргалант	Тариат сумаас 35кВ-ын 92,3 км ЦДАШ	2004	35/0,4кВ-ын 1х0,1 МВА дэд станц	650.03
19	Цагааннуур	Рэнчинлхүмбэ сумаас 15кВ-ын 41,87 км ЦДАШ	2009	15/0,4кВ-ын 1х0,16, 1х0,1МВА дэд станц	500
20	Улаан-Уул	Алаг-Эрдэнэ сумаас 35кВ-ын 118,12 км ЦДАШ	2009	35/0,4кВ-ын 1х0,1 МВА дэд станц	1500
21	Баянзүрх	Арбулаг сумаас 15кВ-ын 49,81км ЦДАШ	2008	15/0,4 кВ-ын 1х0,16, 1х0,1МВА дэд станц	750
22	Цагаан уул	Арбулаг сумаас 35кВ-ын 71,1км ЦДАШ	2008	35/10кВ-ын 1х0,63МВА дэд станц	2100
23	Цэцэрлэг	Могойн голоос 35кВ-ын 21 км ЦДАШ	2007	35/0,4кВ-ын 1х0,63МВА дэд станц	1800

Хөвсгөл аймгийн цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвас газрын хэмжээг гаргахдаа доорхи хүснэгтэнд буй зохих нормын дагуу гаргав. Шугамын төрлөөс хамаарч шугамаас хоёр тийш 10-30м хамгаалалтын зурвасыг авч талбайг гаргав.

Хүснэгт№4.15. Цахилгаан шугамын хамгаалалтын зурвас газрын норм

№	Шугам сүлжээ тоног төхөөрөмж	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгууламж	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан	Усан дор байрласан	Ой мод, цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
		Шугамын захын утаснаас хоёр тийш		Тал бүр тийш	Шугамаас хоёр тийш			Шугамын захын утаснаас 2 тийш
1	Цахилгааны дамжуулах шугам: а/ 1кв хүртэл	-	1-1.5 м	-	-	-	-	-
	б/1-20 хүртэл кв	10 м	2 м	10 м	-	-	-	2 м
	в/ 35 кв	15 м	4 м	15 м				3 м
	г/ 110 кв	20 м	5 м	20 м				3 м
	д/ 220 кв	25 м	6 м	25 м				4 м
	е/ 330-500 кв	30 м	10 м	30 м				5 м
2	Кабель шугам	-	-	-	-	1 м	100 м	-
3	Дулааны шугам а/ 500 мм хүртэл голчтой	-	-	5 м	3 м	5 м	-	-
	б/ 500 мм-ээс дээш голчтой	-	-	5 м	5 м	7 м	-	-

Хүснэгт№4.16. Хөвсгөл аймгийн эрчим хүчний шугам сүлжээ, хамгаалалтын зурвасын хэмжээ

№	Сумд	Шугамын төрөл /35кВт/	Урт /км/	Талбай /га/
1	Тариалан	35кВ	60	180
2	Эрдэнэбулган	15кВ	76.4	152.8
3	Цагаан үүр	15кВ	-	-
4	Их уул	10кВ	45.4	90.8
5	Рашаант	10кВ	42.1	84.2
6	Ханх	10кВ	-	-
7	Чандмань-Өндөр	35кВ	74.4	223.2
8	Түнэл	10кВ	46.94	93.88
9	Тосонцэнгэл	110кВ	0.5	2
10	Мөрөн	110кВ	291.85	1167.4
11	Алаг-Эрдэнэ	35кВ	91.15	273.45
12	Төмөрбулаг	10кВ	57.9	115.8
13	Рэнчинлхүмбэ	15кВ	67.62	135.24
14	Галт	10кВ	59	118
15	Арбулаг	35кВ	64.7	194.1
16	Бүрэнтогтох	10кВ	50.1	100.2
17	Шинэ-Идэр	10кВ	49	98
18	Жаргалант	35кВ	92.3	276.9
19	Цагааннуур	15кВ	41.87	83.74
20	Улаан-Уул	35кВ	118.12	354.36
21	Баянзүрх	15кВ	49.81	99.62
22	Цагаан уул	35кВ	71.1	213.3
23	Цэцэрлэг	35кВ	21	63

Эрчим хүчний шугам сүлжээний нийт урт 1471.26км, шугам сүлжээний хамгаалалтын зурвасын нийт хэмжээ 4119.9 га талбай байна.

Усан цахилгаан станц

Эрдэнэбулган 200 кВт хүчин чадалтай УСЦ:

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын нутагт сумын төвөөс 3 км зайтай газар Эгийн гол дээрх усан цахилгаан станцыг Дани улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2006 онд барьж ашиглалтанд оруулсан. УЦС-ын барилга байгууламж дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

- a. Ус дөхүүлэх суваг
- b. Ус хуваарилах болон загас өнгөрүүлэх барилга
- c. Деривацын суваг
- d. Турбины ус авах камер
- e. Турбин генератор
- f. Ус зайлуулах камер
- g. Ус зайлуулах суваг
- h. Станцын барилга

Усан цахилгаан станцын үйлдвэрлэсэн эрчим хүчийг 250КВт-ийн дэд өртөөгөөр 2.86 км зайд 10кВ-ын цахилгаан дамжуулах шугамаар сумын төврүү дамжуулдаг.

Дулаан хангамж

Мөрөн хотын нийт хүн амын 7,7% буюу 813 хүн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон орон сууцанд амьдарч байна. Мөрөн хот нь тусдаа шугам сүлжээтэй 6 төвлөрсөн халаалтын зуухтай. 1999-2006 онд зуухнуудыг бүрэн засварласан. Зуух нь автомат биш, үнс зайлуулах систем нь гар ажиллагаатай. MZ-1500 зуух нь хагас автомат ба энэхүү зуухны үнсний бункер нь гар ажиллагаатай харин асаагуур нь хяналтын самбараас хянагддаг.

Тус хотод хүн ам төвлөрч, барилга байгууламж ихэсч байгаа бөгөөд энэ байдал ирээдүйд ч үргэлжлэх хандлагатай байна. Тиймээс, төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээ байгуулж, 6 ш бага чадлын халаалтын зуухны газруудыг нэгтгэж 1 дулааны станцтай болох шаардлагатай байна. Харин хуучин зуухны газруудыг ДДТ болгон ашиглаж болох юм.

Хүснэгт №4.17. Мөрөн хотын дулаан хангамжийн хүчин чадал (2013 он)

Суурилагдсан хүчин чадал	ХХУ	Уур	Үйлдвэрлэсэн хүчин чадал	Нөөц хүчин чадал	Дулааны алпагдал	
					Гкал/ц	Үйлдвэрлэсний %
31.5	Б / Ү	г / ц	26.2	10.3	7.5	29%

Дулааны шугамын нийт урт 19,3 км. Шугам хоолой цоорч, мөн хэрэглэгчид радиатороос халуун ус авдагаас болж усны алдагдал нилээд их байна.

Холбоо мэдээлэлийн сүлжээ

Хөвсгөл аймгийн төв Мөрөн хот Улаанбаатар хоттой шилэн кабелиар холбогдсон бөгөөд нийт 24 сумын төвийн 20 сумын төв нь шилэн кабелиар аймгийнхаа төвтэй холбогдсон байна. Нийт шилэн кабелийн урт 1151.3 гаруй км байна.

Мөрөн сумын төвд радио өргөн нэвтрүүлэг дахин дамжуулах зориулалт бүхий радио станц ажиллаж байна

4.2.2. Шугам сүлжээний газрын төлөвлөлт


Цахилгаан эрчим хүчний сүлжээний төлөвлөлт

Тус аймагт шинээр барих эрчим хүчний эх үүсвэрийг Монгол орны цахилгааны хэрэглээний өсөлт, хэтийн төлөв, цаашдын хөгжил, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн талаар баримтлах хэтийн чиглэл, бодлого хэрэгжүүлэх арга замтай уялдуулан шийдэх нь оновчтой гэж үзэж байна.

Дулааны шугам сүлжээг бүдүүсгэвэл 2020 оны төвшинд хүлээгдэж буй дулааны хэрэглээг хангах боломжтой гэж үзэж байна. Одоо байгаа дулааны сүлжээний урт 8.9 хос км. Дулааны шугамыг 3 жилийн дотор хэсэгчлэн солих боломжтой байна. Орчин үеийн нийтлэг жишгээр бол Мөрөн хотын дулаан хангамжийн системийг 6 Гкал/ц-ийн 3 зуух, дулааны 10 км сүлжээтэйгээр солих шаардлагатай байна.

Дулааны шугамыг 2013 оноос эхлэн 3 жилийн дотор сольж, дараа нь гурван зуухаа 2016 оноос эхлэн 2 жил тутамд 1-ийг ашиглалтанд оруулахаар (1 км шинэ шугамын хамт) суурилуулах шаардлагатай байна.

ДХС-ийг сэргээснээр хэрэглэгчдийн дулаан хангамж сайжирч, усыг үр ашигтай хэрэглэдэг болохоос гадна нүүрсний хэрэглээ, тээвэрлэлтийн зардлыг бууруулж (үүнтэй уялдсан тоосжилт), орчинд сөрөг нөлөөтэй бодисын ялгарлыг бууруулна. Дулаан хангамжийн үйлчилгээ сайжирснаар хотын эдийн засагт нөлөөлж оршин суугчдаас томоохон хотуудад нүүн шилжигсдийн тоо цөөрнө. Нүүрсээ аймгийн төвөөс тус тус 30, 54, 217 км зайтай Могойн гол, Жилчигбулаг, Төмөртэйн нүүрсний уурхайнуудаас тээвэрлэдэг. Энэ үр шиг нь Мөрөн хотын ДХС-г сайжруулахад шийдвэрлэх хүчин зүйл болно.



Зураг №4.2 Шугам сүлжээний газрын төлөвлөлтийн зураг

Хүснэгт №4.18. Хөвсгөл аймагт дараахь усан цахилгаан станцуудыг барихаар төлөвлөж байна.

№	Сумдын нэр	Байршил	Төлөвлөж буй хүчин чадал	Зориулалт	Он
1	Улаан-Уул	Мунгаашын гол	200кВт	Ахуйн хэрэглээ	2015-2020
2	Тосонцэнгэл	Чаргайт гол	24мВт	Ахуйн хэрэглээ	2015-2020

Дулаан хангамжийн төлөвлөлт

Мөрөн хотын төвд 2014 онд ашиглалтанд орсон 33мВт-ын дулааны станцын хүчин чадал нь хүн амын өсөлт болон барилга байгууламж олноор баригдаж байгаатай холбогдуулан хүчин чадлыг 60мВт болгон нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Сумдаас авсан саналууд:

Хүснэгт №4.19. Дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх

№	Сумдын нэр	Байршил	Одоо байгаа хүчин чадал	Нэмэгдүүлэх хүчин чадал	Зориулалт	Он
1	Мөрөн	Хотын төвд	33мВт	60мВт	Ахуйн хэрэглээ	2021-2025

Хүснэгт №4.20. Дэд станц байгуулах

№	Сумдын нэр	Байршил	Зориулалт	Он	Шаардагдах арга хэмжээ
1	Төмөрбулаг	Сумын төвөөс зүүн чиглэлд	Дэд станц байгуулах. Газар өмчлөх бүрэн боломжтой	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
2	Тариалан	Сумын төвд	Бага оврын дулааны станц төлөвлөж байна.	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх

Хүснэгт №4.21. Эрчим хүч нэмэгдүүлэх

№	Сумдын нэр	Байршил	Нэмэгдүүлэх хүчин чадал	Зориулалт	Он	Шаардагдах арга хэмжээ
1	Рашаант	Сумын төвд	10кВт-ыг 35кВт болгон нэмэгдүүлэх	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
2	Тариалан	Тавантолгой багийн төвд	10кВт-ыг 35кВт болгон нэмэгдүүлэх	Газар өмчлөх бүрэн боломжтой	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх

Хүснэгт №4.22. Эрчим хүч, цахилгааны шугам татах

№	Сумдын нэр	Байршил	Зориулалт	Он	Шаардагдах арга хэмжээ
1	Жаргалант	Хөшиг мод руу	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
2	Тариалан	Багийн төвүүд рүү	Ахуйн хэрэглээ	2015-2030	Нарийвчилсан судалгаа хийх
		Баянхошуу багт өндөр хүчдэл тавих	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Сэлэнгэ багийн төвд	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Ард тархи багийн төвд	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
4	Цагаан-Үүр	Цагаан эрэг орчимд	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
6	Цагаан-Уул	Хөх толгой орчимд	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
7	Чандмань-Өндөр	Ёлгос багийн төв	Суурьшлийн бүс үүсэх	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
8	Ренчинлхүмбэ	1-р баг Хар устаас багийн төв Хөндийн ам	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		2-р багт Цагааннуур сумаас Хоолойн зах	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		4-р багт Сумын төвөөс Тасархайн хаш	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		1,2,4-р багийн төвүүдэд үйлчилгээний газрууд	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх

Холбоо, мэдээлэлийн сүлжээний төлөвлөлт

Тус аймгийн хувьд Цэцэрлэг, Цагааннуур, Ринчинлхүмбэ, Ханх сумууд шилэн кабелиар аймгийнхаа төвтэй холбогдоогүй байна. Эдгээр сумыг эхний ээлжинд тоон радио релей болон сансрын Vsat системээр холбоно. Дараагийн ээлжинд шилэн кабелиар холбоно. Хиймэл дагуул орсны дараа малчид интернет, болон хөдөлгөөнт холбооны хэрэгсэл ашиглах бололцоо бүрэн бүрдэнэ.

Хөвсгөл аймгийн холбооны одоогийн байдлын SWOT шинжилгээ :

Давуу талууд :

Нийслэл хоттой шилэн кабелиар холбогдсон

4 сумаас бусад нь аймгийнхаа төвтэй шилэн кабелиар холбогдсон

Мөрөн сумын төвд радио өргөн нэвтрүүлгийн станцтай

Аймгийн төв болон 18 сум нь интернетийн үйлчилгээтэй

Холбооны үйлчилгээ явуулдаг бэлэн суурь баазтай

Бүх сумуудын төвүүдэд нь хөдөлгөөнт холбооны сүлжээ орсон

Сул талууд :

Цэцэрлэг, Цагааннуур, Ринчинлхүмбэ, Ханх сумууд шилэн кабельд холбогдоогүй

Булган-Мөрөн хооронд шилэн кабель агаарын баганат шугамтай

Хөдөөгийн малчдад хөдөлгөөнт холбооны сүлжээгээр бүрэн хангагдаагүй

Боломж :

Мэргэжлийн байгууллага, боловсон хүчинтэй

Шилэн кабель орсон сумууд интернет болон бусад холбооны үйлчилгээ авах бүрэн боломжтой

Радио, телевизийг тоон технологид шилжих бололцоог хангасан

Аюул занал :

Холбооны агаарын шугамууд нь байгалийн эрсдэлд орох талтай

Холбооны шугам байгуулах, үйлчилгээ явуулахад байгалийн хүнд нөхцөлтэй

Өргөн уудам газар нутагт байнга нүүдэллэн амьдарч байгаа хөдөөгийн малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээгээр хангахад бэрхшээлтэй

2015-2020 онд Цэцэрлэг, Цагааннуур, Ринчинлхүмбэ, Ханх сумууд шилэн кабелиар холбоно. Ингэснээр бүх сум шилэн кабелиар холбогдож, радио телевиз, интернетийг чөлөөтэй ашигладаг болно. Холбоо мэдээллийн технологийг улсын хэмжээнд тоон технологид шилжүүлэхтэй холбогдуулан Мөрөнгийн радио нэвтрүүлгийн станцыг тоон технологид шилжүүлэхээс гадна телевизийн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэнэ. 2016 оноос цааш Монгол улс өөрийн хиймэл дагуулын системтэй болсноор алслагдсан малчдыг холбоо, телевизийн нэвтрүүлэг, мэдээллээр хангахад түүнийг ашиглах болно. Цаашдаа тухайн үеийн техникийн дэвшлийг нэвтрүүлэх, техникийн шинэчлэл хийгдэж байхаар төлөвлөж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**5.1. Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал****5.1.1. Хөвсгөл аймгийн ойн сангийн газрын өнөөгийн байдал**Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал

1.Ойн сангийн судлагдсан байдал. Хөвсгөл аймгийн ойн санд 1956-1957 онуудад хуучнаар З.Х.У-ын техник, хэрэгсэл, мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар анхны агаарын тоймчилсон судалгааг явуулж ойн сангийн нийт талбай, нөөц, таксацын үндсэн үзүүлэлтүүдийг тогтоосон байдаг.

Харин 1977 онд Алаг-Эрдэнэ суманд, 1983 онд Тариалан суманд, 1987 онд Цагаан-Үүр, Чандмань-Өндөр суманд ойн хэсэгчилсэн судалгаа явуулж, тухайн сумдын ойн нөөцийг тодорхойлж байжээ. Мөн түүнчлэн 2000-2003 онуудад Ойн хайгуул судалгааны төвийн ажилтнууд аймгийн хэмжээгээр ой зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хамгийн сүүлд 2012 онд Тариалан, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдад “ОХСТ” ХХК, Арбулаг, Баянзүрх, Улаан-Уул сумдад “Хөвчийн хойморь” ХХК, Ханх, Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Их-Уул, Тосонцэнгэл, Рашаант, Түнэл, Төмөрбулаг, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Жаргалант, Галт сумдад “Гранд форест” ХХК, Алаг-Эрдэнэ, Цагааннуур, Ренчинлхүмбэ сумдад “Нью Грийн Форест” ХХК тус тус ой зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.


2.Ойн сан. Ойн сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойгоос бүрдэнэ. Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сангийн газарт хамаарна.

Хөвсгөл аймаг ойн сан бүхий 22 сумтай, ойн сангийн нийт талбай аймгийн нийт нутагдэвсгэрийн 35.6хувийг эзэлнэ. Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайг нийт нутаг дэвсгэрт нь харьцуулж хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ойрхог чанар гэдэг. Хөвсгөл аймгийн ойгоор бүрхэгдсэн талбай /3203,8 мян.га/-г аймгийн нийт нутаг дэвсгэр /10 960,0 мян.га/-д харьцуулж гаргахад ойрхог чанар нь 29,2 хувь байна.

Хүснэгт №5.1. Сумдын байгалийн ойн талбай, нөөц

Д/д	Сумын нэр	ойн талбай, га	талбайн эзлэх хувь	ойн нөөц, м ³	нөөцийн эзлэх хувь
1	Алаг-Эрдэнэ	166915	5,4	24392210	5,7
2	Арбулаг	25191	0,8	3045310	0,7
3	Баянзүрх	145122	4,7	19692260	4,7
4	Бүрэн тогтох	64758	2,1	8635150	2,0
5	Галт	62275	2,0	8367560	2,0
6	Жаргалант	77596	2,5	10854180	2,6
7	Их-Уул	70554	2,3	9314250	2,2
8	Рашаант	52937	1,7	7346750	1,7
9	Ренчинлхүмбэ	224430	7,3	29116330	6,9
10	Тариалан	142905	4,6	17669230	4,2
11	Тосонцэнгэл	26859	0,9	3528280	0,8
12	Төмөрбулаг	46997	1,5	6230544	1,5
13	Түнэл	111892	3,6	15249390	3,6
14	Улаан-Уул	284784	9,2	35850670	8,5

15	Ханх	133087	4,3	19823640	4,7
16	Цагаан-Уул	60221	1,9	7682700	1,8
17	Цагаан-Үүр	419724	13,6	57086510	13,5
18	Цэцэрлэг	171327	5,6	23123800	5,5
19	Чандмань-Өндөр	287445	9,3	45769800	10,8
20	Шинэ-Идэр	43137	1,4	5943640	1,4
21	Эрдэнэбулган	308477	10,0	40406260	9,5
22	Цагааннуур	163448	5,3	24129210	5,7
Дүн		3090081	100,00	423257674	100,00



Зураг №5.1. Хөвсгөл аймгийн ойн сангийн талбай газрын төрлөөр ангилагдсан байдал

Ойн сангийн нийт талбайн 96.52 хувийг ойн талбай, 3.48 хувийг ойн бус талбай эзэлж байгаа бол ойн талбайн 84.88 хувь нь ойгоор бүрхэгдсэн, 15.12 хувь нь ойгоор бүрхэгдээгүй талбай байна.

Ойгоор бүрхэгдсэн талбайн 96.45 хувийг байгалийн ой, 3.548 хувийг бут сөөг, 0.002 хувийг нь таримал ой, ойгоор бүрхэгдээгүй талбайн 61.97 хувийг шатанги, 29.9 хувийг тармаг мод, 1.98 хувийг мод бэлтгэсэн, 1.20 хувийг байгалийн аясаар ойжиж байгаа, 5.38 хувийг хөнөөлт шавжид нэрвэгдсэн талбай, 0.08 хувийг ойжуулсан талбай тус тус эзэлж байна.

Тус аймгийн ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд бүрэлдэхүүний хувьд шилмүүст, навчит, зарим газарт шилмүүст болон навчит мод бүхий холимог ой ургах ба гол мөрний дагуу бут, сөөг тархан ургана.

Байгалийн ойн талбайг модны төрлөөр талбай, нөөцийг хүснэгт 5.1-д харуулав.

Ойн нөөц гэдэг нь 1 га ой дахь ургаа модны ишний нийт эзэлхүүнийг хэлнэ. Хөвсгөл аймгийн байгалийн ойн нийт нөөц 423.257.674 шоо.метр гэж тогтоогдов. Үүнийг модны төрөл тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт №5.2. Байгалийн ойн талбай

Шинэс	405873514
Нарс	368070
Хуш	12305000
Гацуур	459630
Хус	3907600
Улиас	139880
Улиангар	15240
Хайлаас	5180
Бургас	183560 шоо.метр байна.

5.1.2. Ойн сангийн өөрчлөлт

Монгол орны ойн экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгалийн ойг бууруулах өөрчлөлт оруулж байгаа гол хүчин зүйлс нь 1-рт байнга гардаг ойн түймэр, 2-рт хууль бусаар эмх замбараагүй, системгүй хийгддэг мод бэлтгэлийн ажил, 3-рт утаагүй түймэр хэмээгдэх ойн хортон шавжийн үржил, тархалт мөн бэлчээрийн малын нөлөө нөгөө талаар хүний сөрөг хүчин зүйлийн нөлөө байдаг.

Хөвсгөл аймгийн ойн санд гарсан өөрчлөлтийг гаргахдаа 2012 онд хийгдсэн ой зохион байгуулалтын судалгааны дүнг өмнөх 2000-2003 онуудад хийгдсэн ой зохион байгуулалтын судалгааны дүнтэй харьцуулан газрын төрлийн ангилал тус бүрээр, байгалийн ойн талбай, нөөцийн өөрчлөлтийг модны төрлөөр, байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлтийг модны төрөл тус бүрээр гаргав.

а. Ойн сангийн талбайн өөрчлөлт. Аймгийн ойн сангийн газрын төрлийн өөрчлөлтийг хүснэгт №5.3.-д харуулав

Хүснэгт №5.3. Ойн сангийн талбайн өөрчлөлт

Ойн сангийн талбайн төрөл	Газрын төрөл	2012 оны ой зохион байгуулалт	2003 оны ой зохион байгуулалт	Зөрүү
Ойгоор бүрхэгдсэн талбай	Байгалийн ой	3090081	3319747	-229666
	Бут сөөг	113695	133067	-19372
	Таримал ой	22	50	-28
	Дүн	3203798	3452864	-249066
Ойгоор бүрхэгдээгүй талбай	Шатсан	353523	150391	203132
	Тармаг	167694	170793	-3099
	Мод бэлтгэсэн	11278	9395	1883
	Ойжих	6874	49417	-42543
	Ойжуулсан	472	394	78
	ХШӨН	30670		30670
	Дүн	570511	380390	190121

Ойн талбайн дүн		3774309	3833254	-58945
Ойн бус талбай	Цагаан энгэр	132621	249301	-116680
	Хадлан		25832	-25832
	Намаг		36438	-36438
	МҮГ	9		9
	Нуур гол	6	1011	-1005
	Таг царам	3392	62543	-59151
	Элс		580	-580
	Түймрийн зурвас		6	-6
Ойн бус талбайн дүн		136028	375711	-239683
Нийт дүн		3910337	4208965	-298628

Тайлбар: ХШӨН-хөнөөлт шавж өвчинд нэрвэгдсэн

Ойн сангийнбайгалийн ой 229666 га-р, бут сөөг 19372 га-р, таримал ой 28 га-р хасагдаж ойгоор бүрхэгдсэн талбай нийтдээ 249066 га талбайгаар багассан үзүүлэлттэй байна.Ойгоор бүрхэгдээгүй талбайн ойн түймэрт нэрвэгдэж шатсан ой 203132 га, мод бэлтгэсэн талбай 1883 га, ойжуулсан 78 га, хөнөөлт шавжид нэрвэгдсэн талбай 30670 га-аар тус тус нэмэгдэж, тармаг мод 3099 га-р, байгалийн аясаар ойжиж байгаа талбай 42543 га-р багасаж нийтдээ 190121 га талбайгаар нэмэгдсэн байна.

Ойн сангийн талбайн өөрчлөлтийг бүхэлд нь авч үзэхэд ойн талбай 58945 га-аар, ойн бус талбай 239683 га-аар тус тус багассанаар нийтдээ 298628 га-аар хасагдсан үзүүлэлт гарлаа. Ойн сангийнойгоор бүрхэгдсэн талбай ихээхэн хэмжээгээр багасаж, ойгоор бүрхэгдээгүй талбайн хэмжээ нэмэгдсэн нь ойн түймэр, мод бэлтгэл, хөнөөлт шавжийн нөлөөлөлтэй холбоотой.

Ойн мэргэжлийн байгууллагуудын хийсэн ойжуулалтын ажлын үр дүнд ойжуулалт хийсэн талбай нэмэгдсэн хэдий ч тарьсны дараах арчилгаа муу, ган гачиг, мал амьтан оройн нахиаг нь идэж гэмтээх зэрэг шалтгаанаас болж өсөлт хөгжилт муу байгаа нь ажиглагдав.

Хүн, малын хүчин зүйлийн сөрөг нөлөө, байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр хээржих үйл явц явагдаж ойжих талбай багасаж гарсан байна.

Харин ойн сангийн нийт талбай 65174 га талбайгаар хасагдаж байгаа нь өмнөх /2000-2003 оны/ ой зохион байгуулалтын ажлын үедойн санд оруулан тооцсон хээрийн бүстэй залгаж байгаа томоохон хэмжээний цагаан энгэр, хадлан, бэлчээрийн талбайг хассан мөн аймгийн ойн сангийн хил хязгаарыг байгалийн үл хөдлөх тогтоц болох нуруу, жалга, ус хагалбараар тогтоосон байсныг энэ удаагийн ойзохион байгуулалтаар УИХ-аас баталсан засаг захиргааны хилийн шугамын дагуу болгосон зэргээс шалтгаалан багасч гарлаа.

б.Байгалийн ойн талбай, нөөцийн өөрчлөлт.Байгалийн ойн талбай, нөөцийн өөрчлөлтийг хүснэгт 5.4.-д харуулав.

Хүснэгт №5.4. Байгалийн ойн талбай, нөөцийн өөрчлөлт

Модны төрөл	талбай, га			нөөц, ш.м		
	2012	2000-2003	зөрүү	2012	2000-2003	зөрүү
Шинэс	2918012	3142057	-224045	405873514	458661838	-52788324
Нарс	2204	3420	-1216	368070	625080	-257010

Хуш	81642	99380	-17738	12305000	15792202	-3487202
Гацуур	3754	6277	-2523	459630	849540	-389910
Жодоо		36	-36		2520	-2520
Хус	71135	55776	15359	3907600	4967780	-1060180
Улиас	2441	2943	-502	139880	184270	-44390
Улиангар	198	800	-602	15240	68960	-53720
Хайлаас	127	754	-627	5180	16810	-11630
Бургас	10568	8304	2264	183560	179940	3620
Дүн	3090081	3319747	-229666	423257674	481348940	-58091266

Хүснэгтээс харахад байгалийн ойн талбай 229666 га-аар, нөөц 58091.2 мян.шоо.метрээр багассан байна. Байгалийн ойн талбай, нөөц ихээхэн хэмжээгээр багасаж гарсан нь доорх шалтгаанаас үүдэлтэй юм. Үүнд:

1-рт хүний зүй бус үйл ажиллагаанаас болж удаа дараа гарч байсан ойн түймрийн учруулсан хохирол их байна.

2-рт ойн ариун цэвэр муу байгаагаас ойн хөнөөлт шавжийн голомт арилахгүй, залуу дунд насны болон болц гүйцэж яваа ойд учруулсан хохирол их байна.

3-рт мод, модон материалын хэрэгцээ эрс нэмэгдэн, зах зээлд мод үнэтэй болсон нь хууль бусаар мод бэлтгэх сонирхолыг төрүүлж байгалийн ойд ихээхэн хохирол учруулж байна.


4-рт уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтын нөлөөгөөр гацуур болон навчит үүлдэрийн модод хатаж хуурайших явдал ажиглагдаж байна. Мөн байгалийн аясаараа сэргэн ургалт муу байгаагаас ойн сан тэлж ургах явц удаан, бага байна.

5-рт хүн, малын хүчин зүйлийн сөрөг нөлөө, байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр хээржих үйл явц явагдаж байна.

Дээрх хүчин зүйлсийн нөлөөгөөр байгалийн ой их хэмжээгээр хорогдож ойгоор бүрхэгдээгүй талбайн ангилалд шилжсэн байна. Хүснэгтээс харахад бургасан ойн талбай, нөөц өсч гарсан байна. Энэ нь өмнөх оны ой зохион байгуулалтаар ойн санд бүртгэгдээгүй голын дагуух бургасыг шинэ зохион байгуулалтаар ойн санд бүртгэж авсан явдал юм.

в. Ойн сангийн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт. Ойн сангийн таксацын дундаж үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс үзэхэд бүх дундаж өсөлт 249.1 мян.шоо.метрээр, байгалийн ойн 1 га-н нөөц 8 шоо.метрээр, 1 га-н өсөлт 0.01 шоо.метрээр тус тус багасаж, дундаж бонитет 0.01, дундаж өтгөрөл 0.05-аар, нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ойн таксацын гол гол үзүүлэлтүүд бүгд буурч гарсан нь түймэр, ойн хөнөөлт шавжийн тархалт, хууль бус мод бэлтгэлээс учирч буюу хор уршиг төдийгүй ойд хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээнүүд хийгдэхгүй байгаагаас шалтгаалж байна. Нөгөө талаар сүүлийн жилүүдэд тохиолдож байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс болж ойн ургах орчин ихээхэн өөрчлөгдөж байгаатай холбоотой.



Зураг №5.2. Ойн сангийн ангиллын зураг

5.2. Ойн сан бүхий газрын ашиглалт хамгаалалтын менежмент

Ойн сан бүхий газрын төлөвлөлтийг ойрын болон дунд хугацааны /2015-2020он/, Алс хэтийн /2020-2030он/ гэсэн 2 хугацаагаар төлөвлөсөн бөгөөд 2015-2020он хүртэлх хугацаанд ойн сангийн газрын ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх арга хэмжээг ойн зохион байгуулалт, ойн тооллогын материалд тулгуурлан сум тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 2020-2030 оны төлөвлөлтийг одоогийн ойн санд оруулж буй хөрөнгө оруулалт, ойн ангийн хүчин чадал зэргээс харгалзан ерөнхийлөн төлөвлөсөн болно.

5.2.1. Ойрын болон дунд хугацааны төлөвлөлт /2015-2020 он/Ойг хамгаалах арга хэмжээ

а/Ойг хамгаалах арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлага. Жил бүр Аймгийн Засаг даргын захирамжаар түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан ажиллаж иржээ. Гэвч сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 56 суманд 98 удаа ой хээрийн түймэр гарч, байгаль экологид 694.9 тэрбум төгрөгийн хохирол учруулжээ. Мөн аймгийн хэмжээнд ой хээрийн түймэрт нэрвэгдсэн 353523 га талбай байна.

Иймээс цаашид ойг түймэр, ойн хөнөөлт шавьж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын ажлын зэрэгцээ түймрийн шороон зурвас байгуулах, ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх арга хэмжээг 2015-2020 онд төлөвлөсөн болно. Энэ арга хэмжээг Хүснэгт №5.5-д харуулав.

Хүснэгт №5.5. Хөвсгөл аймгийн 2015-2020 онд байгуулах түймрийн шороон зурвас


№	Сумдын нэр	Түймэрт нэрвэгдсэн талбай га	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Алаг-Эрдэнэ	2305							
2	Арбулаг	-							
3	Баянзүрх	132							
4	Бүрэн тогтох	5153				10			10
5	Галт	25221		20		10		20	50
6	Жаргалант	24293		20	20	10	20	20	90
7	Их-Уул	919							
8	Рашаант	580							
9	Ренчинлхүмбэ	20980	20		20	10	20	20	90
10	Тариалан	9188							
11	Тосонцэнгэл	-							
12	Төмөрбулаг	19							
13	Түнэл	4169							
14	Улаан-Уул	3912							
15	Ханх	8692			10	10			20
16	Цагаан-Уул	9616		10					
17	Цагаан-Үүр	171902	20		10	20	20	20	90
18	Цэцэрлэг	1722							
19	Чандмань-Өндөр	25458	10			10	20		40
20	Шинэ-Идэр	3							
21	Эрдэнэбулган	32231		10	10		10	20	50
22	Цагааннуур	7028							
	Аймгийн дүн	353523	50	60	70	80	90	100	450

Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх шаардлага. Сүүлийн жилүүдэд ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгаа явуулах ажлыг 810.9 мянган га талбайд явуулж, түүнтэй тэмцэх ажлыг 105.8 мянган га талбайд тус тус зохион байгуулж, зохих үр дүнд хүрсэн хэдий ч одоо 2014 оны судалгаагаар аймгийн хэмжээгээр зайлшгүй тэмцэл явуулах шаардлагатай 102002 га ойн талбай байгаа юм. Иймээс 2015-2019 онд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөв. Харин 2019 онд ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгаа явуулсны үндсэн дээр цаашид явуулах ойн хөнөөлт

шавьж, өвчтэй тэмцэх арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй гэж үзэж байна. 2015-2019 онд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэл явуулах талбайг хүснэгт №5.6-д үзүүлэв.

Хүснэгт №5.6. Хөвсгөл аймгийн 2015-2020 онд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэл явуулах талбай

№	Сумдын нэр	Ойн хөнөөлт, шавьж, өвчинд нэрвэгдсэн талбай га /Тухайн сумын ой зохион байгуулалтаар тогтоогдсон/	Жил бүрийн судалгаагаар зайлшгүй тэмцэл явуулах шаардлагатай талбай га	Төлөвлөлтийн үеийн он						
				2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Алаг-Эрдэнэ	-								
2	Арбулаг	-								
3	Баянзүрх	-								
4	Бүрэн тогтох	24								
5	Галт	13417	13957			14000				14000
6	Жаргалант	887	8138				3200	5000		8200
7	Их-Уул	1622	5642		5700					5700
8	Рашаант	1232	33938	21000	12000		1000			34000
9	Ренчинлхүмбэ	-								
10	Тариалан	1110								
11	Тосонцэнгэл	4333	437			1000				1000
12	Төмөрбулаг	7416								
13	Түнэл	68	3216		3300					3300
14	Улаан-Уул	-								
15	Ханх	-								
16	Цагаан-Уул	-								
17	Цагаан-Үүр	40								
18	Цэцэрлэг	517	16300				17000			17000
19	Чандмань-Өндөр	-								
20	Шинэ-Идэр	4	15304					15100		15100
21	Эрдэнэбулган	-	5070			6000				6000
22	Цагааннуур	-								
	Аймгийн дүн	36670	102002	21000	21000	21000	21200	21100		104300




Зураг №5.3. Ойн хортон шавьж, өвчинтэй тэмцэх газруудын байршил

2.Ойн ашиглалтыг сайжруулах шаардлага. Өнгөрсөн 5 жилд тус аймгийн хэмжээгээр нийт 814.1 мянган шоометр мод арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн байна. 2015-2020 онд бэлтгэсэн модны ашиглалтыг сайжруулах, түлшинд өөр төрлийн бүтээгдэхүүн орлуулах зорилт тавьж, мод бэлтгэх модны хэмжээг өнгөрсөн оны түвшинд төлөвлөсөн болно. Тухайлбал ирэх 6 жилд 68437 га талбайгаас 2190000 шоометр модыг бэлтгэж ашиглахаар төлөвлөв. 2015-2020 онд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэж ашиглах нийт модны хэмжээг хүснэгт №5.7-д үзүүлэв.

Хүснэгт №5.7. Хөвсгөл аймгийн 2015-2020 онд хийх ойн цэвэрлэгээний огтлолт /сумдаар/

Д / д	Сумдын нэр	Ойн цэвэрлэгээ хийх шаардлагатай		5 жилд жилд бэлтгэсэн дундаж хэмжээ шоо.м	2013 онд бэлтгэсэн модны хэмжээ, шоо.м	2015		2016		2017		2018		2019		2020		Дүн	
		Талбай га	Гарах нооц шоом			Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом
1	Алаг-Эрдэнэ	20555	367740	3435.20	27187.5	860	27500	875	28000	875	28000	906	29000	906	29000	937	30000	5359	171500
2	Арбулаг	1425	64500	9758.6	6437.5	203	6500	219	7000	219	7000	234	7500	234	7500	250	8000	1359	43500
3	Баянзүрх	8057	343000	4355.4	9920	328	10500	360	11500	360	11500	375	12000	375	12000	390	12500	2188	91500
4	Бүрэн тогто	23643	408500	6756.0	14450	453	14500	469	15000	469	15000	484	15500	484	15500	500	16000	2859	91500
5	Галт	89077	1750240	7601.7	11737.5	360	11500	390	12500	390	12500	406	13000	406	13000	406	13000	2358	75500
6	Жаргалант	66616	2469480	9106.2	17987.5	578	18500	578	18500	578	18500	593	19000	593	19000	593	19000	3513	112500
7	Их-Уул	16033	247570	6243.0	11031.3	390	12500	390	12500	390	12500	406	13000	406	13000	421	13500	2403	77000
8	Рашаант	2382	46710	6373.2	12181.3	390	12500	406	13000	406	13000	421	13500	421	13500	437	14000	2481	79500
9	Ренчинлхүмбэ	69666	1169655	7295.3	15137.5	500	16000	515	16500	515	16500	531	17000	531	17000	531	17000	3123	100500
10	Тариалан	64817	1075500	7011.1	18400	578	18500	593	19000	593	19000	609	19500	609	19500	625	20000	3607	115500
11	Тосонцэнгэл	4057	211870	5179.6	12000	390	12500	406	13000	406	13000	421	13500	421	13500	437	14000	2481	67800
12	Төмөрбулаг	10088	344340	4101.2	17656.3	578	18500	578	18500	578	18500	578	18500	578	18500	593	19000	3483	111500
13	Түнэл	31656	697140	7828.7	26775.5	844	27000	844	27000	844	27000	859	27500	859	27500	859	27500	5109	163500
14	Улаан-Уул	5315	178440	4084.8	10262.5	328	10500	328	10500	328	10500	328	10500	328	10500	360	11500	2000	64000
15	Ханх	18666	496710	4536.4	9562.5	328	10500	328	10500	328	10500	328	10500	328	10500	360	11500	2000	64000
16	Цагаан-Уул	20801	631270	5885.4	10262.5	344	11000	360	11500	360	11500	375	12000	375	12000	375	12000	2189	70000
17	Цагаан-Үүр	226712	5890400	5488.2	24393.8	781	25000	799	25500	799	25500	821	26000	821	26000	828	26500	4849	154500
18	Цэцэрлэг	13971	176330	7335.6	11746.9	390	12500	406	13000	406	13000	421	13500	421	13500	437	14000	2481	79500
19	Чандмань-Өндөр	12828	141420	5583.6	27986.3	890	28500	906	29000	906	29000	922	29500	922	29500	937	30000	5483	175500
20	Шинэ-Идэр	7934	78180	6139.4	5826.9	203	6500	234	7500	234	7500	250	8000	250	8000	265	8500	1436	46000
21	Эрдэнэбулган	132663	2133789	7340.4	29692.8	937	30000	953	30500	953	30500	969	31000	969	31000	969	31000	5750	184000
22	Цагааннуур	15244	294460	3492.8	8937.5	281	9000	312	10000	312	10000	328	10500	328	10500	343	11000	1904	61000
	Аймгийн дүн	919221	24779843	162812	345967.4	10938	350000	11250	360000	11250	360000	11562	370000	11562	370000	11875	380000	68437	2190000



Зураг №5.4 Ойн арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх газруудын байршил

Ойг нөхөн сэргээлт, байгалын сэргэн ургалтад туслах арга хэмжээ

Ойг нөхөн сэргээх ажлыг нэмэгдүүлэх шаардлага. Тус аймгийн хэмжээнд өнгөрсөн 5 жилд нийт 1914 га талбайд ойжуулалт, 728.3 га талбайд байгалийн сэргэн ургалданд туслах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Гэтэл тус аймгийн хэмжээнд түймэрт нэрвэгдсэн, мод бэлтгэлийн ажил явуулсан 364801 га талбай байгаа юм. Иймээс ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг цаашид нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймээс ойжуулалтын болон байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. 2015-2020 онд ойжуулах болон байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын хэмжээг хүснэгт №5.8-5.9-д тус тус харуулав. харуулав

Хүснэгт №5.8. Хөвсгөл аймгийн 2015-2020 онд ойжуулах талбай

№	Сумдын нэр	Ойжуулах шаардлагатай талбай га			5 жилд ойжуулсан талбай га	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
		Түймэрт нэрвэгдсэн	Мод бэлтгэсэн	Нийт								
1	Алаг-Эрдэнэ	2305	2614	4919	245	50	50	50	60	70	80	360
2	Арбулаг	-	112	112	25							
3	Баянзүрх	132	-	132	-							
4	Бүрэн тогтох	5153	1277	6430	105	50	50	50	50	50	50	300
5	Галт	25221	729	25950	217							
6	Жаргалант	24293	313	24606	180	50	50	50	50	50	50	300
7	Их-Уул	919	257	1176	10					10	10	20
8	Рашаант	580	186	766	18							
9	Ренчинлхүмбэ	20980	41	21021	-							
10	Тариалан	9188	978	10166	158	50	50	20	20	20	20	180
11	Тосонцэнгэл	-	77	77	166			50	50	50	50	200
12	Төмөрбулаг	19	394	413	2							
13	Түнэл	4169	1442	5611	215	100	100	100	100	100	100	600
14	Улаан-Уул	3912	-	3912	-							
15	Ханх	8692	320	9012	-							
16	Цагаан-Уул	9616	867	10483	452	200	200	100	100	100	100	800
17	Цагаан-Үүр	171902	-	171902	-							
18	Цэцэрлэг	1722	685	2407	-							
19	Чандмань-Өндөр	25458	70	25528	36		10		50	40	40	100
20	Шинэ-Идэр	3	135	138	-							
21	Эрдэнэбулган	32231	781	33012	1			50	50	50	50	200
22	Цагааннуур	7028	-	7028	-							
	Аймгийн дүн	353523	11278	364801	1848	500	510	520	530	540	550	3150

Хүснэгт №5.9. Хөвсгөл аймгийн 2015-2020 онд байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээ

№	Сумдын нэр	Ойжуулах шаардлагатай талбай га			байгалийн сэргэн ургалтанд туслах	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
		Түймэрт нэрвэгдсэн	Мод бэлтгэсэн	Нийт								
1	Алаг-Эрдэнэ	2305	2614	4919	115	-	50	50	50	50	50	250
2	Арбулаг	-	112	112								
3	Баянзүрх	132	-	132								
4	Бүрэн тогтох	5153	1277	6430								
5	Галт	25221	729	25950	110	100	100	100	100	100	100	600
6	Жаргалант	24293	313	24606	108	100	100	100	100	100	100	600
7	Их-Уул	919	257	1176	100						50	50
8	Рашаант	580	186	766	80							
9	Ренчинлхүмбэ	20980	41	21021								
10	Тариалан	9188	978	10166	19	50	50	50	50	50	50	300
11	Тосонцэнгэл	-	77	77	19							
12	Төмөрбулаг	19	394	413	3							
13	Түнэл	4169	1442	5611	135			50	50	50	50	200
14	Улаан-Уул	3912	-	3912								
15	Ханх	8692	320	9012						50	50	100
16	Цагаан-Уул	9616	867	10483	30	100	100	100	100	100	100	600
17	Цагаан-Үүр	171902	-	171902								
18	Цэцэрлэг	1722	685	2407								
19	Чандмань-Өндөр	25458	70	25528	70	100	100	100	100	100	100	600
20	Шинэ-Идэр	3	135	138								
21	Эрдэнэбулган	32231	781	33012	8				50	50	50	150
22	Цагааннуур	7028	-	7028								
	Аймгийн дүн	353523	11278	364801	797	400	450	500	550	600	650	3450

5.2.2. Хэтийн төсөөлөл

Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний алс хэтийн 2021-2030 оны төсөөллийг гаргахыг оролдов. Хэтийн төсөөллийг аймгийн хэмжээнд баримжаалан хийсэн бөгөөд сумдаар төлөвлөх боломжгүй гэж үзэж байна. Ойг хамгаалах арга хэмжээний хувьд төв, орон нутгийн уламжлалтын зохион байгуулалтын ажлыг харуулах боломж хязшаарлагдмал юм. Мөн түүнчлэн ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтыг 2019 онд зогсоохоор ойрын зорилт болгон дэвшүүлсэн болно. Иймээс тухайн үеийн ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгаанд тулгуурлан 2021-2030 онд тэмцэх ажлыг төлөвлөх боломж бүрдэнэ. 2021-2030 онд байгуулах түймрийн зурвасны хэмжээг хүснэгт №5.10. -д харуулав.

Хүснэгт №5.10. Хөвсгөл аймгийн 2021-2030 онд байгуулах түймрийн шороон зурвас га

Д/д	Сумын нэр	2015-2020 оны дүн	2021-2025 он	2026-2030 он	Дүн
1	Алаг-Эрдэнэ		50	50	100
2	Арбулаг				-
3	Баянзүрх		50	50	100
4	Бүрэн тогтох	10			-
5	Галт	50			-
6	Жаргалант	90		50	50
7	Их-Уул			50	50
8	Рашаант			50	50
9	Ренчинлхүмбэ	90	100	100	200
10	Тариалан		50		50
11	Тосонцэнгэл				-
12	Төмөрбулаг				-
13	Түнэл		50		50
14	Улаан-Уул		100	100	200
15	Ханх	20		50	50
16	Цагаан-Уул				-
17	Цагаан-Үүр	90	100	100	200
18	Цэцэрлэг			50	50
19	Чандмань-Өндөр	40			
20	Шинэ-Идэр				-
21	Эрдэнэбулган	50		50	50
22	Цагааннуур			50	50
	Аймгийн дүн	450	500	750	1250

Хүснэгт №5.11. Хөвсгөл аймгийн 2021-2030 онд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх талбай

Д/д	Сумын нэр	2015-2019 онд тэмцэл явуулсан талбай		2021-2025 он	2026-2030 он	Дүн
		Нийт	Дундаж			
1	Алаг-Эрдэнэ					
2	Арбулаг					
3	Баянзүрх					
4	Бүрэн тогтох					
5	Галт	14000				
6	Жаргалант	8200				
7	Их-Уул	5700				
8	Рашаант	34000				
9	Ренчинлхүмбэ					
10	Тариалан					
11	Тосонцэнгэл	1000				
12	Төмөрбулаг					
13	Түнэл	3300				
14	Улаан-Уул					
15	Ханх					
16	Цагаан-Уул					
17	Цагаан-Үүр					
18	Цэцэрлэг	17000				
19	Чандмань-Өндөр					
20	Шинэ-Идэр	15100				
21	Эрдэнэбулган	6000				
22	Цагааннуур					
	Аймгийн дүн	104300	21.2	11660	12826	24486

Хүснэгт №5.12. Хөвсгөл аймгийн 2021-2030 онд хийх ойн цэвэрлэгээний хэмжээ


№	Сумдын нэр	2015-2020 онд бэлтгэсэн модны хэмжээ		2021-2025 он		2026-2030 он		2021-2030 оны дүн	
		Нийт	Дундаж	Талбай га	Нөөц шм	Талбай га	Нөөц шм	Талбай га	Нөөц шм
1	Алаг-Эрдэнэ	171500							
2	Арбулаг	43500							
3	Баянзүрх	91500							
4	Бүрэн тогтох	91500							
5	Галт	75500							
6	Жаргалант	112500							
7	Их-Уул	77000							
8	Рашаант	79500							
9	Ренчинлхүмбэ	100500							
10	Тариалан	115500							
11	Тосонцэнгэл	67800							
12	Төмөрбулаг	111500							
13	Түнэл	163500							
14	Улаан-Уул	64000							
15	Ханх	64000							
16	Цагаан-Уул	70000							
17	Цагаан-Үүр	154500							
18	Цэцэрлэг	79500							
19	Чандмань-Өндөр	175500							
20	Шинэ-Идэр	46000							
21	Эрдэнэбулган	184000							
22	Цагааннуур	61000							
	Аймгийн дүн	2190000	350000	55781	1785000	56896	1820700	112672	3605700

Хүснэгт №5.13. Хөвсгөл аймгийн 2021-2030 онд ойжуулах талбай га

Д/д	Сумын нэр	2020 онд ойжуулах талбай	2021-2025 он	2026-2030 он	Дүн
1	Алаг-Эрдэнэ	80			
2	Арбулаг				
3	Баянзүрх				
4	Бүрэн тогтох	50			
5	Галт				
6	Жаргалант	50			
7	Их-Уул	10			
8	Рашаант				
9	Ренчинлхүмбэ				
10	Тариалан	20			
11	Тосонцэнгэл	50			
12	Төмөрбулаг				
13	Түнэл	100			
14	Улаан-Уул				
15	Ханх				
16	Цагаан-Уул	100			
17	Цагаан-Үүр				
18	Цэцэрлэг				
19	Чандмань-Өндөр	40			
20	Шинэ-Идэр				
21	Эрдэнэбулган	50			
22	Цагааннуур				
	Аймгийн дүн	550	3025	3327	6352

Хүснэгт №5.14. Хөвсгөл аймгийн 2021-2030 онд байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээ

Д/д	Сумын нэр	2020 онд явуулах арга хэмжээ	2021-2025 он	2026-2030 он	Дүн
1	Алаг-Эрдэнэ	50			
2	Арбулаг				
3	Баянзүрх				
4	Бүрэн тогтох				
5	Галт	100			
6	Жаргалант	100			
7	Их-Уул	50			
8	Рашаант				
9	Ренчинлхүмбэ				
10	Тариалан	50			
11	Тосонцэнгэл				
12	Төмөрбулаг				
13	Түнэл	50			
14	Улаан-Уул				
15	Ханх	50			
16	Цагаан-Уул	100			
17	Цагаан-Үүр				
18	Цэцэрлэг				
19	Чандмань-Өндөр	50			
20	Шинэ-Идэр				
21	Эрдэнэбулган	50			
22	Цагааннуур				
	Аймгийн дүн	650	3575	3932	7507



Зураг №5.5. Ойн сэргэн ургалтанд туслах арга хэмжээнүүд

5.3. Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний ТӨЛӨВЛӨЛТ, ДҮГНЭЛТ

Дүгнэлт. Өнгөрсөн хугацаанд тус аймгийн хэмжээнд ойг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар багагүй арга хэмжээ авч хэрэгжүүлнээр зохих үр дүнд хүрчээ. Гэвч тус аймгийн хувьд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлын хэмжээг нэмэгдүүлэх, ойн экологийн ач холбогдлыг өндөржүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ойн сангийн өөрчлөлтөөс үзэхэд талбай, нөөц, таксацын дундаж үзүүлэлтүүд буурч гарсан нилээд тааламжгүй үр дүн харагдаж байна. Байгалийн ойн талбайн насны бүлгийн бүтцээс харахад болц гүйцсэн, хөгшин ойн нөөц дийлэнх хувийг эзэлж байгааньзалуу, дунд насны болон болц гүйцэж яваа ой байгалийн жамаар насны дээд бүлэгт шилжиж ой байгалийн аясаараа сэргэн ургах явц муу байгаагаас залуу ойгоор

нөхөн сэргэх үйл явц удаашралтай байгааг харуулж байна. Энэ нь нэг модноос гарах бүтээгдэхүүний чанар муудах, нөгөө талаар ойн байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад гүйцэтгэх үүрэг ач холбогдлыг бууруулахад хүргэнэ.

Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгалийн ойн үүрэг ач холбогдлыг бууруулж байгаа гол хүчин зүйлс нь хүний болгоомжгүй үйл ажиллагаанаас үүдэн удаа дараа гарч буй ойн түймэр, ойн хөнөөлт шавжийн хэт тархалт, эмх замбараагүй болон хууль бусаар мод бэлтгэж байгаа байдал, байгаль орчны хууль тогтоомжийн заалтыг зөрчин ойн санд явуулж буй элдэв төрлийн аж ахуйн үйл ажиллагаа, дэлхий нийтийг хамарсан цаг агаарын дулаарал зэрэг болж байгаа юм.

Ой зохион байгуулалтын судалгаагаар тогтоогдсон ойн аж ахуйн арга хэмжээний төслийг хэрэгжүүлэх, сум, аймгийн “Ойн менежментийн төлөвлөгөө” боловсруулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах явдал чухал юм.

1. Ойг хамгаалах арга хэмжээний төлөвлөлт.

Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг цаг хугацаанд нь явуулж, түүнд тусгагдсан ой хамгаалах арга хэмжээг хэрэгжүүснээр ойн экологийн ач холбогдол дээшилж, түүний таваарлаг чанар сайжирна. 2015-2020 онд ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах уламжлалт зохион байгуулалтын арга хэмжээг авахын зэрэгцээ түймрийн зурвасыг 60 га-д байгуулж, 18.5 мянган га талбайд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг гүйцэтгэнэ. Харин хэтийн төсөөллөөр түймрийн шороон зурвасыг 2021-2025 онд 75 га-д, 2026-2030 онд 80 га-д тус тус байгуулна.

2. Ойн ашиглалтын төлөвлөлт. Модон түүхий эдийн ашиглалтын түвшинг дээшлүүлэх, түлшний модыг өөр эх үүсвэрээр хангахад анхаарч, 2015-2020 онд нийт 190.6 мянган шоометр мод бэлтгэж, аймгийн хэрэглээний болон түлшний модны хэрэгцээг хангана. Харин 2021-2025 онд 192.5 мянган шоометр, 2025-2030 онд 200.5 мянган шоометр мод бэлтгэхээр төсөөлөж байна. Ингэснээр түймэрт нэрвэгдсэн болон мод бэлтгэсэн 18.2 мянган га талбайн ой цэвэрлэгдэж, энэ талбайд байгалийн сэргэн ургалт явагдах, ойг нөхөн сэргээх арга хэмжээ авах боломж хангагдах юм. Мөн дээрх талбайд түймэр гарах, ойн хөнөөлт шавьж, өвчин тархах магадлал эрс багасна. Ойн дагалт баялгийн ашиглалтыг сайжруулах замаар хүн амын хүнсний хангамж, өрхийн орлогыг нэмэгдэнэ.

3. Ойг нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах ажлын төлөвлөлт.

Мод үржүүлгийн газруудыг өргөтгөн бойжуулах тарьц суулгацын хэмжээг нэмэгдүүлэх замаар ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг нэмэгдүүлнэ. 2015-2020 онд ойжуулалтын ажлыг 1860 га-д, 2021-2025 онд 1900 га-д, 2025-2030 онд 1950 га-д тус тус хийхээр төлөвлөв. Мөн түүнчлэн байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээг 2015-2020 онд 620 га-д, 1900 онд 650 га-д, 2026-2030 онд 700 га-д тус тус авахаар тусгав.

4. Хүрэх үр дүн шалгуур үзүүлэлт.

Газар зохион байгуулалтын тусгагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд ойн тогтвортой менежмент нэвтэрч, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд чанарын ахиц гарч, экологийн ач холбогдол бүхий эрүүл ой бий болно. Ойн экосистем, биологийн олон янз байдлын

хадгалалт, хамгаалалт сайжирна. Модон түүхий эдийн ашиглалтын түвшин дээшилж, аймгийн мод, модон бүтээгдэхүүний хэрэгцээг хангана. Ойн дагалт баялгийн ашиглалтыг сайжруулах замаар хүн амын хүнсний хангамж, өрхийн орлогыг нэмэгдэнэ.

Хүснэгт № 5.15. 2015-2030 онд явуулах ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоо

№	Ойн аж ахуйн арга хэмжээ	Нэг бүрийн үнэ Мян.төг	2015-2020 он		2021-2025 он		2026-2030 он		Дүн	
			Хэмжээ	Зардал, сая төг	Хэмжээ	Зардал сая төг	Хэмжээ	Зардал сая төг	Хэмжээ	Зардал сая төг
1	Түймрийн шороон зурвас	230.0	450	105.5	500	115.0	750	172.5	1700	391.0
2	Ойн хөнөөлт өвчинтэй тэмцэх	48.0	104300	5006.4	11660	559.7	12826	615.6	128786	6181.7
3	Арчилгааны огтлолт хийх	20.0	68437	1368.7	55781	1115.6	56896	1137.9	181114	3622.2
4	Ойжуулалт	695.0	3150	2189.3	3025	2102.4	3327	2312.3	9502	6603.9
5	Байгалийн сэргэн ургалтанд туслах	200.0	3450	690.0	3575	715.0	3932	786.4	10957	2191.4
	Дүн									18990.2

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**6.1. Усны сан бүхий газрын өнөөгийн байдал**

Хөвсгөл аймгийн нутаг ус зүйн сүлжээгээр Хойд мөсөн далайн ай савд хамрагддаг. Хорьдол-Сарьдаг, Мөнх Сарьдаг, Булнай зэрэг уулс нь усны ай савын хагалбар болдог төдийгүй Дархадын хотгорыг хүрээлэн орших уул, нуруудаас эх авах булаг шанд, гол, горхи нь бүгд Шижээд голын савд усаа юүлэх учир Монгол улсдаа хамгийн их гадаргын усны нягтшилтай бүс нутаг юм. Энд 400 орчим гол горхи, булаг шанд эх авч 300 гаруй нуур тогтсоноор манай орны цэнгэг усны ундраа нөөц болж байна.

2003 онд хийсэн гадаргын усны тооллогоор Хөвсгөл аймгийн хэмжээнд 1163 гол горхи тоологдсоноос 70 ширгэсэн, 902 булаг шанднаас 193 ширгэсэн, 612 нуур цөөрөм тоологдсоноос 30 ширгэсэн бөгөөд 2007 оны усны тооллогоор 916 булаг шандаас 179 ширгэсэн, 782 гол горхи тоологдоноос 451 ширгэсэн, 593 нуур, цөөрөм 49 ширгэсэн, 2011 оны тооллогоор 1101 гол горхиноос 132 ширгэсэн, 932 булаг шанднаас 163 ширгэсэн, 580 нуур тойром 62 ширгэсэн байдаг. Харин 2013 оны гадаргын усны тооллогын дүнд 1212 гол горхи тоологдсоноос устай 1173, нуур тойромоос 578 бүгд устай, 929 булаг шанд тоологдсоноос 841 устай, Рашаан нийтдээ 61 устай тоологдсон байна.

Хүснэгт №6.1. Хөвсгөл аймгийн усан сангийн газар 2013 оны байдлаар

Ангилал	Талбайн хэмжээ
Мөрөн, гол	33298.3
Нуур, цөөрөм, тойром	51390.1
Цас мөсөн гол	194.5
Горхи, булаг шанд	1314.1

Хүснэгт №6.2. Хөвсгөл аймгийн гадаргын усны тооллого / 2013 он /

№	Сумдын нэр	Гол горхи		Нуур, тойром		Булаг шанд		Рашаан		Мөстөл мөсөн гол		Услалтын систем		Цэвэрлэх байгууламж		Усан цахилгаан станц
		Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	
1	Алаг-Эрдэнэ	29	29	3	3	53	53	1	1	-	-	-	-	-	-	-
2	Арбулаг	25	25	43	43	61	61	-	-	-	-	-	-	-	-	-
3	Баянзүрх	39	39	3	3	34	34	3	3	-	-	-	-	-	-	-
4	Бүрэнтогтох	42	42	8	8	84	84	3	3	-	-	-	-	-	-	-
5	Галт	45	45	-	-	29	29	5	5	-	-	-	-	-	-	-
6	Жаргалант	42	42	-	-	62	60	2	2	-	-	-	-	-	-	-
7	Их-Уул	18	13	-	-	36	22	2	2	-	-	-	-	-	-	-
8	Рашаант	9	8	28	28	35	12	5	5	-	-	1	-	-	-	-
9	Ренчинлхүмбэ	88	88	185	185	24	24	4	4	-	-	-	-	-	-	-
10	Тариалан	38	38	3	3	41	41	4	4	-	-	-	-	-	-	-
11	Тосонцэнгэл	24	12	3	3	42	42	-	-	-	-	1	-	-	-	-
12	Төмөрбулаг	22	14	-	-	93	46	2	2	-	-	-	-	-	-	-
13	Түнэл	42	42	4	4	42	42	2	2	-	-	-	-	-	-	-
14	Улаан-Уул	105	105	106	106	7	7	3	3	-	-	-	-	-	-	-
15	Ханх	44	44	11	11	10	10	2	2	1	-	-	-	-	-	-
16	Цагаан-Уул	38	37	25	26	45	45	-	-	-	-	-	-	-	-	-
17	Цагаан-Үүр	192	192	16	16	32	32	11	11	-	-	-	-	-	-	-
18	Цэцэрлэг	120	120	10	10	30	30	4	4	-	-	-	-	-	-	-

19	Чандмань-Өндөр	40	40	3	3	36	36	3	3	-	-	-	-	-	-
20	Шинэ-Идэр	21	9	3	3	53	51	-	-	-	-	-	-	-	-
21	Хатгал	2	2	2	2	14	14	-	-	-	-	-	-	-	-
22	Эрдэнэбулган	77	77	7	7	57	57	3	3	-	-	-	-	-	1
23	Цагааннуур	110	110	115	115	9	9	2	2	-	-	-	-	-	-
24	Мөрөн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
Бүгд		1212	1173	578	578	929	841	61	61	1	-	2	-	1	-

6.2. Усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалт

6.2.1. Ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн ус ашиглалт

Усан сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт нь байгалийн уст цэг, газрын доорхи усны орд тус бүрээр хийгдэх онцлогтой тул аймаг сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нарийн тусгах шаардлагатай.

Усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын талаар улсын хэмжээнд баримтлах нэгдсэн бодлогод:

- Усны сан бүхий газар, усны нөөц хоёрыг зохистой ашиглах хамгаалах зорилтыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх;
- Усны нөөц, түүний байгалийн тэнцэл, усны чанарыг хамгаалахад усны сан бүхий газрыг ялангуяа, усны эх газар, усны эрэг орчмын газар, усархаг намгархаг газрыг зохистой ашиглах, хамгаалах;
- Нуур, гол, горхины эргийн дагуу 50 м өргөнтэй, усархаг намгархаг газрын эргэн тойронд 100 м өргөнтэй эрэг орчмын бүс тогтоож зарлах;
- Усны эх авсан газарт 2-3 км өргөнтэй хамгаалалтын зурвас бүс тогтоож ашиглах, хамгаалах горимыг тогтоож өгөх;
- Хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэж буй аливаа уст цэгт 100 м-ээс доошгүй өргөнтэй эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох;
- Усны эх авсан газар, нуурын эргэн тойрны 5 км, гол, горхины эргийн дагуу 3 км доторхи газрын ой мод, бут сөөг, ургамлан нөмрөгийг хамгаалах горимыг уст цэг болгоноор тогтоож мөрдөх зэрэг асуудлууд орно.

6.2.2. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

Усны нөөцийн судалгаанд үндэслэн сум, орон нутгийн иргэдийн саналыг харгалзан хуучин ашиглагдаж байсан инженерийн болон энгийн хийцтэй услалтын системүүдийг сэргээн засварлах, үйлдвэр, үйлчилгээний байгууллага болон нийтийн орон сууцны иргэдийн хэрэгцээний цэвэр, хаягдал усны шугамыг тоолууржуулах

Хүн, мал бэлчээрийн усан хангамжийн бүрэн шаардлага хангахгүй болж эвдэрч гэмдсэн худаг бусад уст цэгийг хэрхэн шийдэх талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулж шийдвэрлэх.

Гол горхи нуур, тойрмын усны эрэг болон гүн хэсгийн хооронд байнгын хөдөлгөөнтэй солилцоо зурвас хэсэг байдаг. Гол горхи, нуур тойрмын эрэг хөвөө дагуу хэсэг зурвас газар нь экологийн хувьд онцгой ач холбогдолтой бүс байдаг. Ийм бүсийн зурвас орчмыг усны бүс гэх бөгөөд усны болон хуурай газрын биологийн төрөл зүйлийн хувьд харьцангуй баян хэсэг бөгөөд хамгаалалтын бүсийг доорхи байдлаар тогтоов

Хүснэгт №6.3. Гол горхины эргийн хамгаалалтын бүсийн хэмжээ

№	Сумдын нэр	Гол горхины нийт талбай /га-аар/	Гол горхигны эх газрыг хамгаалах талбай	
			Хувиар /%/	/ га-аар /
1	Алаг-Эрдэнэ	2145	6.4	3405.4
2	Арбулаг	686	2.1	1089.1
3	Баянзүрх	9141	27.5	14512.4
4	Бүрэнтогтох	2216	6.7	3518.2
5	Галт	1308	3.9	2076.6
6	Жаргалант	688	2.1	1092.3
7	Их-Уул	1127	3.4	1789.2
8	Рашаант	1024	3.1	1625.7
9	Ренчинлхүмбэ	300	0.9	476.3
10	Тариалан	811	2.4	1287.6
11	Тосонцэнгэл	350	1.1	555.7
12	Төмөрбулаг	288	0.9	457.2
13	Түнэл	957	2.9	1519.4
14	Улаан-Уул	1300	3.9	2063.9
15	Ханх	-	-	-
16	Цагаан-Уул	950	2.9	1508.2
17	Цагаан-Үүр	3983	12.0	6323.5
18	Цэцэрлэг	2600	7.8	4127.8
19	Чандмань-Өндөр	673.3	2.0	1068.9
20	Шинэ-Идэр	771	2.3	1224.1
21	Хатгал	-	-	-
22	Мөрөн	-	-	-
23	Эрдэнэбулган	1000	3.0	1587.6
24	Цагааннуур	980	2.9	1555.9
ДҮН		33298.3	100.0	52865.0

Хүснэгт №6.4. Нуур цөөрөм бүхий газрын хамгаалах зурвасын хэмжээ

№	Сумдын нэр	Нуур цөөрөм бүхий газрын нийт талбай /га-аар/	Нуур цөөрөм бүхий газрын хамгаалах талбай	
			Хувиар /%/	/ га-аар /
1	Алаг-Эрдэнэ	1189	2.3	923.3
2	Арбулаг	-	-	-
3	Баянзүрх	130	0.3	100.9
4	Бүрэнтогтох	15200	29.6	11803.3
5	Галт	10	0.0	7.8
6	Жаргалант	-	-	-
7	Их-Уул	-	-	-
8	Рашаант	-	-	-
9	Ренчинлхүмбэ	12437	24.2	9657.7
10	Тариалан	-	-	-
11	Тосонцэнгэл	-	-	-
12	Төмөрбулаг	-	-	-
13	Түнэл	560	1.1	434.9
14	Улаан-Уул	7076	13.8	5494.8
15	Ханх	-	-	-
16	Цагаан-Уул	3040	5.9	2360.7
17	Цагаан-Үүр	-	-	-
18	Цэцэрлэг	960	1.9	745.5
19	Чандмань-Өндөр	3.1	0.0	2.4
20	Шинэ-Идэр	-	-	-
21	Хатгал	-	-	-
22	Мөрөн	-	-	-
23	Эрдэнэбулган	-	-	-
24	Цагааннуур	10785	21.0	8374.9
ДҮН		51390.1	100.0	39906.1

Хүснэгт №6.5. Булаг, рашаан бүхий газрын хамгаалах зурвасын хэмжээ

№	Сумдын нэр	Худаг, булаг, рашаан бүхий газрын нийт талбай /га-аар /	Худаг, булаг, рашаан бүхий газрыг хамгаалах талбай	
			Хувиар /%/	/ га-аар /
1	Алаг-Эрдэнэ	-	-	-
2	Арбулаг	-	-	-
3	Баянзүрх	-	-	-
4	Бүрэнтогтох	7	0.5	133.1
5	Галт	20.5	1.6	389.8
6	Жаргалант	-	-	-
7	Их-Уул	-	-	-
8	Рашаант	-	-	-
9	Ренчинлхүмбэ	-	-	-
10	Тариалан	-	-	-
11	Тосонцэнгэл	-	-	-
12	Төмөрбулаг	-	-	-
13	Түнэл	-	-	-
14	Улаан-Уул	-	-	-
15	Ханх	-	-	-
16	Цагаан-Уул	-	-	-
17	Цагаан-Үүр	-	-	-
18	Цэцэрлэг	406	30.9	7719.3
19	Чандмань-Өндөр	45.6	3.5	867.0
20	Шинэ-Идэр	-	-	-
21	Хатгал	-	-	-
22	Мөрөн	-	-	-
23	Эрдэнэбулган	835	63.5	15875.9
24	Цагааннуур	-	-	-
ДҮН		1314.1	100.0	24985.0

6.3. Усан сан бүхий газрын хамгаалал, нөхөн сэргээх

Усны ай сав, усан хагалбарын доторх газар нутгаас угаагдсан туугдас нь биогехимийн элементүүд усны хөвөө газарт тогтох ба зарим хэсэг уст цэгүүдэд орж улмаар усны болон усны хөвөө газрын биологийн төрөл зүйлсийн хүнс тэжээл, амьдрах орчинг баяжуулж, ус сэлгэх явцад найрлага төрөл тоо хэмжээ нь зохицуулагдаж байдаг. Усны хөвөө газар нь зэрлэг ан амьтан, мал сүрэг усанд орох сэрүүцэх үедээ түр саатан тогтох нутаг болдог. Тэрчлэн бэлчээрийн мал аж ахуйн нөхцөл дулааны улирлын нутгийн гол цөм нь болдог онцлогтой. Усны хөвөө газрын ашиглалтын хэлбэр, ашиглалтын горим, ялангуяа ургамалжилт нь нуур тойром, гол горхины усны урсгал болон ус сэлгэх чадавх усны чанар найрлагад нөлөөлдөг бол усны урсгал, ус сэлгэх чадавх хэлбэр маяг нь усны хөвөө газрын биологийн төрөл зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ ялангуяа ургамлын бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийн хэв шинж бүрэлдэхүүн чанар зэрэгт нөлөөлдөг.

Усалгааны эх үүсвэрт гадаргуугийн усыг өргөн ашиглаж байна. Гадаргын ус нутаг дэвсгэртээ харилцан адилгүй тархах тул зарим усны эх үүсвэрийн нөөц нь усалгаанд хүрэлцэхгүй тохиолдол нилээд тохиолдоно. Иймд усан сан, цөөрөм байгуулж, усыг хуримтлуулан ашиглах нь усны нөөцийг нэмэгдүүлэн усалгааны хэрэгцээг найдвартай хангах үндэс нь болно.

Манай орны голуудын урсацын ихэнх нь хур борооны уснаас бүрддэг учраас зуны үерийн ус болон хаврын шар усны үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглахад голлон анхаарвал зохино.

- Жижиг гол горхийн урсацад тохируулга хийж хэрэглээний усыг хуримтлуулах
- Хуучин ашиглаж байсан усан сан, цөөрмийг сэргээх
- Хаврын шар ус, зуны борооны ус хуримтлуулах сан, цөөрөм байгуулах
- Баян бүрдүүдийг сэргээх
- Гол, горхийн хөндийн мод, бут, сөөг, хөрс, ургамлын бүрхэвчийг хамгаалах, нөхөн сэргээх
- Усалгаанд ашигласан илүүдэл усыг эргүүлэн ашиглах
- Усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах зэрэг болно.

Ус ашиглагч байгууллага нь тухайн усны эх үүсвэрт өөрийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөлд нарийвчилсан үнэлгээ хийлгэж, экологийн урсацын хэмжээг тогтоох, хэрвээ авч ашиглах усны хэмжээ хүрэлцэхгүй, экологийн урсацын зарим хэсгийг бага хугацаанд ашиглахад хүрвэл ус хуримтлуулж, нөөцөлж ашиглах хувилбарыг сонгож, ялангуяа хуурай улиралд дутагдал усыг нөхөх эзлэхүүн бүхий усан сан, цөөрөм байгуулах замаар голын экологийн нөхцлийг хангах шаардлагатай байна.

Усны эх үүсвэрээс усыг эмх замбараагүй, их хэмжээгээр авч ашигласнаар усны түвшин буурах, горим нь алдагдах, улмаар нөөц нь хомсдох, бүр ширгэж алга болох зэрэг нөлөөллүүд гарах магадлалтай. Мөн тухайн орон нутгийн гол, горхи, нуурын загас, шувуу, усны амьтан ургамлын төрөл зүйл хорогдоход хүрдэг. Иймд усыг авахдаа орчны экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр батлагдсан хэм хэмжээг /урсацын 5-10%/ баримтлах шаардлагатай.

6.3. Усан сан бүхий газрын хамгаалалт, ашиглалтын төлөвлөлтийн үе шатууд, хамгаалах арга хэмжээ

Хүснэгт №6.6. Монгол улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн арга хэмжээний төлөвлөгөөнд 2013 онд Хөвсгөл аймагт дараах төлөвлөгөө тусгагдсан

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
Хүн амыг баталгаат, эрүүл аюулгүй усаар хангах үндсэн зорилтын хүрээнд:						
1	Унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлэх	Аймгийн төвүүд, томоохон суурин газруудад ус хангамжийн одоо байгаа болон шинэ эх эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.	БОНХЯ, СГЗ, аймаг, нийслэлийн ЗДТГ	БХБЯ ҮХААЯ ЭМЯ МХЕГ ОБЕГ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв
2	Усны нөөцийн эрэл хайгуул хийж, нөөцийг баталгаажуулах	Аймгийн төвд ус хангамжийн эх үүсвэрийг шинэчилж, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулж дотоодын хяналтыг тогтмолжуулна.	БОНХЯ	ЭЗХЯ, СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв

3	Бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулах, шинэчлэх, өргөтгөх	Аймгийн төвүүдэд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэнэ.	БХБЯ	БОНХЯ, ЭЗХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
4	Бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	Аймгийн төв болон томоохон суурин газруудын ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэнэ.	БХБЯ	ЭЗХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад
Хөдөө аж ахуйн салбарыг хэрэгцээт усаар хангах зорилтын хүрээнд:						
1	Усалгаатай тариалан, хадлангийн талбайн усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийх	Услалтын систем шинээр байгуулах, сэргээн засварлах газрын хайгуул, судалгаа хийнэ.	БОНХЯ	ҮХААЯ, СЯ,	аймаг,	нийслэлийн
2	Услалтын системийн толгойн барилга, гол сувгууд болон услалтын системийг шинээр байгуулах, шинэчлэх	Шинээр байгуулах услалтын системийн талбайг 2015 оныг эцэст 1400 га, 2021 оны түвшинд 10600 га-аар, сэргээн засварлах услалтын системийн талбайг 2015 оны эцэст 7100 га, 2021 оны түвшинд 22500 га-аар тус тус нэмэгдүүлнэ.	ҮХААЯ	СЯ, аймаг,	нийслэлийн	ЗДТГ, СГЗ
3	Усалгаатай тариалангийн агротехнологийг сайжруулах, усыг хэмнэлттэй зарцуулах технологи нэвтрүүлэх	Усалгаатай тариалангийн агротехнологийг сайжруулж, дуслын болон бороожуулах усалгааны шинэ технологиуд нэвтрүүлнэ. Монгол орны нөхцөлд тохирсон, ган зудад тэсвэртэй шилмэл сортын ургамлуудын тариалалтыг нэмэгдүүлнэ. Усалгааг хөрс хамгаалах технологитой хослуулан ашиглахыг дэмжинэ.	ҮХААЯ	Аймаг,	нийслэлийн	ЗДТГ, СГЗ
Үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний салбарыг хэрэгцээт усаар хангах үндсэн зорилтын хүрээнд:						
1	Үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжийг тусгайлан байгуулах	Аймгийн төвүүд, томоохон сум суурин газруудад үйл ажиллагаа явуулж буй томоохон үйлдвэрүүдэд бага оврын урьдчилан цэвэрлэх байгууламж нэвтрүүлнэ.	БХБЯ, ҮХААЯ	БОНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад
2	Үйлдвэрийн цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглах	Үйлдвэрлэлд цэвэршүүлсэн бохир ус дахин ашиглах судалгаа хийнэ	ҮХААЯ	БОНХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Хувийн болон бусад
3	Усан цахилгаан станцын усны горимд байнгын хяналт тавих	Усан цахилгаан станцуудын усан сангийн үйл ажиллагаанаас голын усны горимд нөлөөлөх нөлөөлөлд хяналт тавина.	СГЗ	БОНХЯ, СЯ	2014-2021	Улсын төсөв
4	Одоо байгаа болон шинээр байгуулагдах дулааны цахилгаан станцын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх	Шинээр байгуулагдах ДЦС-уудын усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийж шинэ эх үүсвэрүүд байгуулна. Одоо байгаа ДЦС-уудын усны алдагдлыг бууруулан ус дахин ашиглалтыг нэмэгдүүлнэ.	ЭХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
5	Газрын гүний халуун усыг ашиглах боломжийг судлах	Газрын гүний халуун усыг ашиглах судалгаа хийж, тогтоогдсон газруудад гүний халуун усыг	ЭХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын

		ашиглана.				зээл тусламж
Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, усны нөөцийг хамгаалах үндсэн зорилтын хүрээнд:						
1	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах	Бохирдуулагч эх үүсвэрүүдийг тооллого судалгаа хийнэ.	БОНХЯ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв
2	Бохирдуулагч төлөх зарчмыг хэрэгжүүлэх	Ус бохирдуулсны төлбөрийн орлогын нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	БОНХЯ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв
3	Усны сан бүхий газруудын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, мөрдүүлэх	Усны сан бүхий газруудын хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлнэ.	БОНХЯ, СГЗ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв
4	Рамсарын Конвенцийн хэрэгжилтийг хангах, гэрээнд хамрагдах ус, намгархаг газрын тоог нэмэгдүүлэх	Ус, намгархаг газрыг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-
5	Экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, усыг байгальд хадгалах (үлдээх) нөхцлийг бүрдүүлэх	Гадаргын болон газрын доорхи усны нөөцийг бохирдол, хомсдлоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
6	Үерийн хамгаалалтын байгууламжийг засварлах, шинээр байгуулах	Аймгийн төвүүд, томоохон хот суурин газруудын үерийн хамгаалалтын далан, сувгийг сэргээн засварлана.	БХБЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв

6.3.2. Булаг хамгаалах

Сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлттэй холбоотой болон хүний үйл ажиллагаанаас болж олон булаг шанд ширгэж байгаа нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас гаргасан судалгаанаас харагдаж байна. Иймд булаг шандны эхийг хамгаалж мал амьтан орохоос сэргийлж хашаа барих, мод бут суулгах зэрэг арга хэмжээ авч булгийг нөхөн сэргээх шаардлагатай байгаа юм. Иймд Хөвсгөл аймгийн хэмжээнд байгаа устай нийт 841 булаг байгаагийн 34.0% -ийг нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр хамгаалахаар үе шаттайгаар тусгав.

Хүснэгт № 6.7. Булаг хамгаалах

№	Сумдын нэр	Нийт булаг	Булаг эх хамгаалах			Шаардагдах зардал /сая.төг/
			2015-2020	2021-2025	2026-2030	
1	Алаг-Эрдэнэ	53	4	5	5	70
2	Арбулаг	61	6	4	5	75
3	Баянзүрх	34	5	3	3	55
4	Бүрэнтогтох	84	5	6	6	85
5	Галт	29	2	4	3	45
6	Жаргалант	60	6	5	5	80
7	Их-Уул	66	4	3	4	55
8	Рашаант	12	2	3	3	40
9	Ренчинлхүмбэ	24	3	2	2	35
10	Тариалан	41	4	6	5	75
11	Тосонцэнгэл	42	5	3	4	60
12	Төмөрбулаг	46	2	5	5	60

13	Түнэл	42	3	6	6	75
14	Улаан-Уул	7	-	3	4	35
15	Ханх	10	3	4	5	60
16	Цагаан-Уул	45	5	5	5	75
17	Цагаан-Үүр	32	4	3	5	60
18	Цэцэрлэг	30	4	4	4	60
19	Чандмань-Өндөр	36	2	3	5	50
20	Шинэ-Идэр	51	6	5	5	80
21	Хатгал	14	4	5	5	70
22	Эрдэнэбулган	57	5	6	6	85
23	Цагааннуур	9	5	4	-	45
24	Мөрөн	-	-	-	-	-
Дүн		841	89	97	100	1430

Хүснэгт № 6.8. 1-р ээлжинд усжуулах шаардлагатай бэлчээрт шаардагдах хөрөнгийн тооцоо

№	Сумын нэр	Талбайн дугаар	Хугацаа	Шаардлагатай худгийн тоо	Нэгж худгийн зардал /сая.төг/					
1	Алаг-Эрдэнэ	1	2015-2020	5	100					
		2								
		3								
		4								
2	Баянзүрх	5		2015-2020	6	120				
		6								
3	Бүрэнтогтох	7			2	40				
4										
4	Эрдэнэбулган	8			2015-2020	1	20			
9										
5	Галт	10				8	160			
		11								
		12								
6	Их-Уул	13				2015-2020	2	40		
		14								
7	Рашаант	15	8				160			
		16								
		17								
		18								
		19								
		20								
8	Цагаан-Уул	21	2015-2020	9			180			
		22								
		23								
		24								
9	Цагаан-Үүр	25		2015-2020	4		80			
		26								
		27								
10	Цэцэрлэг	28			2015-2020	7	140			
		29								
11	Төмөрбулаг	30				2015-2020	5	100		
		31								
		32								
12	Түнэл	33					2015-2020	2	40	
		34								
13	Улаан-Уул	35	2015-2020					1	20	
		36								
14	Тосонцэнгэл	37						2015-2020	11	220
		38								
		39								
ДҮН									71	1420

Хүснэгт №6.9. Хөвсгөл аймгийн хамгаалалтанд авах шаардлагатай булгийн судалгаа

Д/д	Сумын нэр	Газар нутгийн нэр	Эзэмшигчид
1	Шинэ-Идэр	Цахиуртын аманд	Нутгийн иргэд
		Байшин толгойн урд	
		Цагаан хонхны урд	
		Номт гуугын хажууд	

Хүснэгт №6.10. Усан сан байгуулах

Д/д	Сумдын нэр	Байршил	Зориулалт	Он	Шаардагдах арга хэмжээ
1	Цэцэрлэг	Тэрэгт уулын ард талд	Бэлчээр усжуулалт	2015-2020	Зураг төсөл боловсруулах, нарийвчилсан судалгаа хийх, барьж байгуулах
		Бүрхээр орчим			
		Цагдуулт орчим			
		Нарийн ухаагийн сайр			
2	Тосонцэнгэл	Баянгол-дэрс	Газар тариалан	2015-2020	
3	Цагаан-Уул	Бэлчир	Бэлчээр усжуулалт		
		Бор хужир			
4	Шинэ-Идэр	Сумын төвийн баруун урд талд			

Хүснэгт №6.11. Төлөвлөж буй бохир ус цэвэрлэх байгууламжийн судалгаа

№	Сумдын нэр	Хүчин чадал м ³	Цэвэрлэгээний төрөл	Талбайн хэмжээ	Хугацаа
1	Хатгалд	75 м ³		0.7 га	2016
2	Цэцэрлэг	75 м ³	Биологи	1 га	2015
3	Тариалан			0.5 га	2016


ДОЛООДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**7.1. Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт**

Нэн ховор болон ховордсон ан амьтаныг хамгаалах, байгалийн өвөрмөц, унаган тогтоцыг хамгаалан, хадгалж хойч үедээ өвлүүлэн үлдээхэд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ ихээхэн үүрэг гүйцэтгэх бөгөөд монгол улсын хувьд нийт нутаг дэвгэрийн 30%-ийг улсын тусгай хамгаалалтад авах зорилт тавьсан байгаа билээ. Тус аймгийн хувьд улсын тусгай хэрэгцээний газрыг нэмэгдүүлэх чиглэлээр улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд доорхи газруудыг 2023 он хүртэлх хугацаанд хамгаалалтад авахаар төлөвлөсөн байна. /2003онд батлагдсан болон 2013оны нэмэлт тодотгол/

Хүснэгт №7.1. 2013-2023 онуудад улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай, ээлогийн чухал ач холбогдолтой газруудын жагсаалт /санал/

№	Газрын нэр	Үндэслэл, ангилал	Орон нутгийн саналд тусгагдсан эсэх	БОНХ-н яамны төлөвлө-гөөнд орсон эсэх
1	Бадарын нуруу-Цагаан уул	БНГ		БНГ 570мян.га
2	Их Түнэл уул	БНГ	-	
3	Эрчимийн нуруу	БЦГ	Аймгийн ТХ хамруулахаар санал өгсөн	
4	Жарантайн намаг-Булнай-Их элээт	БЦГ	УТХ-д оруулахаар санал өгсөн	
5	Их бараан уул	ДГ		
6	Дулаанхаан уул	БЦГ	УТХ-д оруулахаар санал өгсөн	
7	Тэрхэн цагаан нуур	БНГ		БНГ 200мян.га
8	Халхан Булнай нуруу	БНГ	УТХ-д оруулахаар санал өгсөн	БНГ 430мян.га
9	Ногооннуур, Гуна ямаат	БНГ		
10	Жар Хярууны нуруу	БНГ-ын өргөтгөл	Аймгийн тусгай хэрэгцээнд орсон	ДЦГ 240мян.га
11	Эг-Үүрийн бэлчир	ДЦГ	Аймгийн тусгай хэрэгцээнд орсон	

Харин хээрийн судалгааны явцад сумдаас ирсэн саналыг нэгтгэн үзэхэд улсын болон аймгийн, сумын тусгай хэрэгцээний газарт хамруулах нийт 36 байршилд санал өгсөн бөгөөд үүнээс 5 сумын 6-н байршилыг улсын тусгай хэрэгцээнд хамруулах, 8-н сум 14 байршил бүхий газрыг аймгийн тусгай хэрэгцээнд, 7-н сум 16 байршил бүхий газрын сумын тусгай хэрэгцээнд хамруулан хамгаалах шаардлагатай байна гэсэн санал өгчээ. Тус санал бүхий газруудад хамрах талбайн газрын нэгдмэл сангийн ангиллын бүтэцийг 7.3 хүснэгтээр харуулав.



Зураг №7.1. Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газарт хамруулах санал бүхий газруудын байршил

Хүснэгт№7.2. Улсын тусгай хамгаалалт болон, аймаг, сумын тусгай хэрэгцээний газарт шинээр хамруулан хамгаалахаар санал өгсөн нутгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, тусгай хамгаалалтад авах үндэслэл

Зураг дээрхи дугаар	Сум	Нэр	Газрын нэгдмэл сангийн ангилал											Дүн	
			Бэлчээр	Хадлан, хаддаг бэлчээр	Тариалангийн газар	Өвөлжөө хаваржааны газар	ХАА-н бусад ангиллын газар	Хот тосгон бусад суурины газар	Зам, шугам сүлжээний газар газар	Гол, мөрөн	Булаг шанд	Нуур цөөрөм тойром	Ойн сан бүхий газар		
Улсын тусгай хамгаалалтад авах санал															
2	Цэцэрлэг	Тэс голын эх бүрэлдэх сав газар, Булнайн нуруу	9976.6			10.8					14.7		54.3	19213.8	29270.2
4	Цагаан-Уул	Тэс голын эх бүрэлдэх сав газар, Элээт уул	33874.2			2.3				17.0	59.0		64.3	18379.9	52396.7
23	Галт	Гурван яргайтын эх	1879.7	168.9		7.0					32.5			758.9	2847.1
29	Тариалан	Дулаан хааны нуруу	2854.9		15.7	5.6	1.6				33.2			29093.6	32004.5
35	Шинэ-Идэр	Агуйн хясаа	171.1												171.1
36	Шинэ-Идэр	Тооройтын амны буган чулуу хөшөө	2.4												2.4
Дүн														116692.0	
Аймгийн тусгай хэрэгцээнд авах санал															
1	Цэцэрлэг	Шаварын гол	17285.5	447.6		19.3					37.3	0.0		50179.4	67969.1
5	Цагаан-Уул	Гандан нуур	1427.3										1010.0	2316.2	4753.6
8	Цагаан-Уул	Салтын нуурын орчим Занабазарын нутаг	697.7							2.9		0.0			700.6
10	Цагаан-Уул	Хавчиг, Агуйт	326.8			3.7					11.9			987.3	1329.8

11	Цагаан-Уул	Өвгөдийн бригад, Цагаан уул	4130.5			5.8			5.2		0.0		2081.4	6222.9
12	Их-Уул	Жинст уул, Рашаан булаг	692.8			0.0			0.9	1.7			2101.9	2797.4
16	Их-Уул	Индэрт, Устын хөндлөн	1276.7			9.4	0.8		5.4	5.7	0.0		3789.7	5087.7
20	Их-Уул	Их уул	80.0							0.1			258.0	338.2
22	Арбулаг	Цагаан чулуутын овоо	1204.6			3.1	0.6	69.8	5.3					1283.4
24	Бүрэнтогтох	Бүрэнхаан	3148.0			1.6	1.6	34.0	34.4				1437.0	4656.5
28	Түнэл	Эгийн гол, Дүнгэр овоо, Цагаан уул орчим	59185.9	242.9	486.1	204.0	3.8	9.8	107.1	700.1	0.1		56469.9	117409.7
30	Төмөрбулаг	Эрчимийн нуруу	4203.4	113.6		5.4			3.0	3.7			7956.4	12285.4
33	Төмөрбулаг	Олон голын бэлчир	2209.7			5.9		3.0	9.6	108.0	0.0		405.2	2741.3
34	Шинэ-Идэр	Зүүн нуур	828.3						1.7			1671.2		2501.2
Дүн													230076.7	
Сумын тусгай хэрэгцээнд авах санал														
3	Цэцэрлэг	Жугнайн нуур	10783.8	1183.9		8.8			1.3		0.0	3525.6	8150.8	23654.2
6	Цагаан-Уул	Сангийн далайн нуурын эрэг орчмын газар, Элхийн овоо	292.9			1.3						68.4	519.9	882.6
7	Цагаан-Уул	Мөсөн түрүүний булаг, Угалзатын голын эх	1820.9						6.0	4.5	0.0	6.6	5304.9	7143.0
9	Цагаан-Уул	Агарын гол, Агарын овоо	274.7			0.8				3.8			28.8	308.0
13	Их-Уул	Лундаа уул, Донзой	159.3			1.7					0.0		601.3	762.4

		рашаан												
14	Их-Уул	Цагаан дөрөлж, Зуун мод	55.8							2.7			2654.6	2713.0
15	Их-Уул	Царам	439.6			6.6			0.0	0.8	0.0		1473.8	1920.8
17	Их-Уул	Жавар	813.8			9.2	1.6			1.2			2074.1	2899.8
18	Их-Уул	Наран	373.5							0.6			1032.9	1407.0
19	Их-Уул	Сараалж	129.6			0.0				1.7			2098.4	2229.8
21	Арбулаг	Дэлгэр мөрөний дагуу	16796.8	321.3		12.5			20.7	137.8		3.2	5001.2	22293.4
25	Жаргалант	Залгааны өтөг	1154.0			2.3							117.2	1273.5
26	Жаргалант	Бэлчирийн булаг	37.3											37.3
27	Жаргалант	Сумын хил дагуу	13797.4			2.3			16.0	7.2			5950.3	19773.3
31	Төмөрбулаг	Бүгдээний гол	105.1							4.7				109.8
32	Төмөрбулаг	Даш дэрчин, Тээлийн нуруу	1284.0			5.3			0.8	2.7			5508.8	6801.5
Дүн													94209.3	
Нийт дүн													440978.1	

7.3. Тусгай хэрэгцээний бусад газар

Тус аймгийн хувьд одоогоор аймаг дундын отрын бүс нутаг болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай чөлөөт бүсийн газар, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай, гадаадын төлөөлөгч, дипломат консулын газар зэрэг тусгай хэрэгцээний газрын ангилалд хамаарах газар байхгүй бөгөөд шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 33,8га, улсын хилийн зурвас газар 1060495,5га, Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 418,23га тус тус эзлэж байна. Харин төлөвлөлтөөр 2 байршилд аймаг дундын отрын бүс байгуулахаар сумын саналыг харгалзан төлөвсөнө болно/*Тайлангийн 2-р бүлэг отрын бүс нутгийн төлөвлөлт*/.

НАЙМДУГААР БҮЛЭГ. АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ, АМРАЛТ ЗУГААЛГЫН БҮС НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

8.1. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, нөөцийн үнэлгээ

8.1.1. Салбарын өнөөгийн байдал

Хөвсгөл аймаг аялал жуулчлалаар бүс нутагтаа тэргүүэх зорилт тавин ажиллаж байгаа. 2005 оноос эхлэн аймгийн аялал жуулчлалын зөвлөгөөн, 2008 оноос Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын зөвлөгөөнийг Хатгал тосгонд хийж хэвшээд байна. Аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор өвлийн аялал жуулчлалын эх үндсийг тавьсан Мөсний баярыг 2000 оноос эхлэн тэмдэглэсэн бөгөөд Тэшүүрийн марафон, Морин болон нохой чарганы аялал зэрэг аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлөө нэмж, хүрээгээ өргөжүүлж байна. Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа жуулчны баазуудын бохирын асуудлыг Чех улсын олон улсын стандартад нийцсэн орчин үеийн шинэ технологийг нэвтрүүлэн шийдвэрлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах үүднээс Хатгал тосгонд цагдаагийн хэсэг байгуулж, жуулчны баазуудад зам тавих, эрчим хүч татах, хөдөлгөөнт холбоо суурилуулах жуулчдын үйлчилгээнд нутгийн иргэдийг олноор оролцуулах тэдэнд сургалт явуулж мэргэшүүлэх зэрэг ажлууд хийгдэж байна. 2006 онд Монгол улс, ОХУ-ын Ерөнхийлөгч нарын байгуулсан “Москвагийн тунхаглалд “Хөвсгөл-Байгаль нуурын орчимд аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тохиролцсон.

Хөвсгөл нуурын бүсийн одоогийн байдал, ОХУ-тай хил залгаа байрлал, дэд бүтцийн хөгжлийн хандлага зэрэг нь ОХУ-ын жуулчдыг татах, ОХУ-аар дамжуулан гуравдагч орны жуулчдыг Монголд аялуулах Монголын жуулчдыг Байгаль нуурын орчимд аялуулах таатай нөхцлийг бүрдүүлж байна.

2008 оноос Иркутск –Мөрөнгийн чиглэлд олон улсын жуулчдад зориулсан нислэг үйлдэхээр нисэх буудлын аэро дром хийгдээд байна. Аялагч жуулчдад зориулсан тусгай хөтөлбөр, отогийн үйлчилгээний журам боловсруулж Аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулан мөрдөж эхэлсний үр дүнд жуулчдын тоо эрс өсөж Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбар бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурь эзэлж байгаа билээ.

8.2. Аялал-рекреацийн бүс нутгийн төлөвлөлт

8.2.1. Аялал-рекреацийн чадавхын үнэлгээ, шинжилгээ

8.2.1.1. Нөхцөл байдлын шинжилгээ

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал болон аймгийн нутаг дэвсгэрт хийсэн судалгааны баримтанд тулгуурлан, SWOT шинжилгээний аргаар аялал жуулчлалыг хөгжүүлэх давуу болон сул тал, таатай боломж болон эрсдэлийг авч үзсэнийг танилцуулья.

Хүснэгт №8.1. Нөхцөл байдлын шинжилгээ

Давуу тал	Сул тал
❖ Монгол цэнгэг усны нөөц	❖ Дэд бүтэц, зам тээврийн сүлжээ

<p>Хөвсгөл нуур</p> <ul style="list-style-type: none"> ❖ Уламжлалт мал аж ахуй нүүдлийн соёл иргэншил ❖ Байгалийн бүс бүслүүр, экосистемийн олон иж бүрдлийг агуулсан “Дэлхийн өв” нутаг Өргөн уудам нутаг, онгон зэрлэг байгальтай. ❖ Дархад, Хотгойд, Урианхай, Буриад, Цаатан ястнууд амьдардаг олон ястны өлгий нутаг ❖ Түүх соёлын дурсгалт газар харьцангуй олон ❖ Хилийн боомттой хамгийн ойр оршино. ❖ Археологийн олдвор бүхий нөөц газруудтай. ❖ Ховор болон ховордсон ургамал амьтан ихтэй ❖ Улаан номонд орсон ургамал, амьтан ихтэй ❖ Хоёр хөрш орныг холбох боломж өндөр ❖ Монголын усан замын аялал зохион байгуулах гол нөөцтэй ❖ Жуулчдад зориулсан үйл явдлын аяллууд “Мөсний баяр” “Цаатан фестиваль”, Сарлаг фестиваль бусад арга хэмжээнүүд 	<p>муу</p> <ul style="list-style-type: none"> ❖ Экологийн хувьд эмзэг ❖ Аялал жуулчлалын улирал богино ❖ Үзмэр хоорондын зай хол ❖ Жуулчны бааз, шаардлага хангах үйлчилгээний иж бүрэн байгууламж, материаллаг бааз хангалтгүй. ❖ Жуулчны баазуудын нуурын эрэгт байрласан байдал ❖ Аялал жуулчлалын бүтээгдэхүүний тодорхой үнэлэмжгүй байдал ❖ Хууль бус агналт ❖ Сүүлийн үед хүчин чадал багатай дуу чимээ ихтэй бага оврын онгоцнууд олноор явж байгаа
<p>Боломж</p>	<p>Аюул</p>
<ul style="list-style-type: none"> ❖ Байгалийн үзэсгэлэнт байдал ховор амьтан ургамлын нөөцөд тулгуурлан экотуризмын аялал жуулчлалыг хөгжүүлэх ❖ Олон улсын хэмжээнд идэвхитэй болон тусгай сонирхолын аяллын хэлбэрүүд тухайлбал: явган болон морин аялал, малчин айлын ахуй амьдралын хэв маягтай танилцах, суралцах аялалд оролцогчдын тоо өсөн нэмэгдэж байгаа. ❖ Нүүдлийн мал ахуй болон өөрсдийн соёл ахуйтай холбоотой нутгийн иргэдэд түшиглэсэн 	<ul style="list-style-type: none"> ❖ Буруу менежмент, хэт ачааллаас хамгаалалттай бүс нутаг, байгалийн нөөц, үзмэрүүд өртөж, сүйдэх ❖ Эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай тул байгалийн гэнэтийн үзэгдэлд /цочир хүйтрэл, зуд, шороон шуурга/ өртөх магадлал өндөр ❖ Аялал жуулчлалын үзмэрүүдэд хадгалалт хамгаалалт дутагдан элэгдэж муудан ач холбогдол нь буурах ❖ Дотоодын жуулчдын эмх

<p>аялал жуулчлалыг хөгжүүлэх, тэднийг ажлын байр, орлогын эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх</p> <ul style="list-style-type: none"> ❖ Хил дамнасан болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, ханхын хилийн гарцыг тогтмол ажиллуулж “Цагаан нуур –гурван голын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд туватай хамтарч ажиллах ❖ Гадаргын олон хэлбэрт хэв шинжийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон зөв зохистой ашиглах ❖ Тусгай сонирхолын болон уулын спорт аяллыг хөгжүүлэх ❖ Усан аялал , судалгаа шинжилгээний аялал хөгжүүлэх ❖ Дэлхийд гайхагдах түүх соёлын үзмэртэй 	<p>замбараагүй, хяналтгүй байдал</p> <ul style="list-style-type: none"> ❖ Ойн түймэр, хулгайн ан, хууль бусаар мод бэлтгэх болон хог хаягдлын зохицуулалтгүй байдал зэрэг нь байгаль орчны доройтлыг бий болгох ❖ Гадаргын хэвгийн хэрчигдэл нь дэд бүтцийн хөгжилд сөргөөр нөлөөлөх ❖ Нуурын ус бохирдох амьтад дайжих, түлш шатахууны бохирдлоос идэш тэжээлд нь нөлөөлөх ❖ Хил дамнасан хууль бус наймаа, халдварт өвчин ❖ Нөөц хомсдох
--	---

Аялал жуулчлалын статистик дүн шинжилгээ

Сүүлийн жилүүдэд ирж байгаа жуулчны тоо 2010 онтой харьцуулахад гадаадынх 3,4, дотоодынх 4 дахин нэмэгдсэн. Дотоодын жуулчдын ихэнх нь автомашинаар ирж, зориулалтын газарт байрладаггүй. Одоогоор аялал жуулчлалын салбарт 350 хүн ажиллаж, жилдээ 20000 гаруй гадаад болон дотоодын жуулчин хүлээн авдаг.

8.2.1.2. Аялал жуулчлалын үйлчилгээний хангамжын үнэлгээ

Байрлуулах үйлчилгээ

Хөвсгөл аймагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа 40 гаруй жуулчны бааз, 22 отог, 24 гэр буудал, 7 амралтын газар, 22 зочид буудал нэг ээлжиндээ 2500 жуулчин хүлээн авах хүчин чадалтай.

Хүснэгт №8.2. Байрлуулах үйлчилгээ

№	Зочид буудлын нэр	Аж ахуй нэгжийн нэр	Байршил	Утас	Өрөөний тоо	Орны тоо
1	Гранд зочид буудал	Агар Эрдэнэс ХХК	Мөрөн сум	88080610, 99382500	14	21
2	Дөл зочид буудал	Хөвсгөл центр ХХК	Мөрөн сум 8-р баг	70382000, 99111467	12	20
3	Дэлгэр мөрөн дэн буудал	Амарбаян хоршоо	Мөрөн сум, 8-р баг	88385599	8	21
4	Өргөө дэн буудал	Хөвсгөл өргөө ХХК	Мөрөн сум 7-р баг	98119349	2	4
5	Турт дэн буудал	-	Мөрөн сум	95388888,	-	-

			7-р баг	88503533		
6	Татах хүч дэн буудал	Хөвсгөл Оргил ХХК	Мөрөн сум 8-р баг	70383988	5	5
7	Хийтийн гол дэн буудал	Хийтийн гол ХХК	Мөрөн сум 5-р баг	98641042	6	9
8	Хөвсгөл зочид буудал	-	Мөрөн сум 1-р баг	98219090	7	14
9	Хас дэн буудал	Хөвсгөл Хас ХХК	Мөрөн сум 8-р баг	-	5	8
10	Хорго дэн буудал	-	Мөрөн сум 8-р баг	99389919, 88203787	4	7
11	Хангарьд дэн буудал	-	Мөрөн сум 8-р баг	99382995, 95351367	6	8
12	Эдэлвайс дэн буудал	Монтрейвил ХХК	Мөрөн сум 8-р баг	70383916, 98380909, 99386096	14	30
13	Beat дэн буудал	Хөвсгөл оргил ХХК	Мөрөн сум	99138730, 94333132	6	12
14	Вайт хаус дэн буудал	Гэгээ ХХК	Мөрөн сум 8-р баг	99388588	13	20

Хүснэгт №8.3. Жуулчны бааз

№	Жуулчны баазын нэр	Аж ахуй нэгжийн нэр	Байршил	Утас	Цахим хаяг	Гэрийн тоо	Орны тоо
1	Ашихай жуулчны бааз	Тэс групп	Тариат сумын Доод модот булан	98380009, 99264484	info@ashihai.mn	15	57
2	Алагцар жуулчны бааз	Номин скай	Чанадмань-Өндөр сум Хар чулуутын ам	99090002	www.nominsky.co m	16	80
3	Байгаль- Үүд жуулчны бааз	Байгаль Үүд ХХК	Хатгал сум Жанхайн цагаан эрэг	99260919, 99388408, 98380004	naturedoor@majc net.mn	19	40
4	Галт халуун ус жуулчны бааз	Нэмэх трейд ХХК	Галт сум	91118082, 98180082	-	-	-
5	Дөл тур жуулчны бааз	Хөвсгөл центр ХХК	Доод модот булан	98209455, 99091203	otgoo@yahoo.com	20	60
6	Далай ван жуулчны бааз	Хөвсгөл геологи ХХК	Доод модот булан	70382449, 99382890	Dalaivan_ts@yaho o.com	18	58
7	Далай тур жуулчны бааз	Монтрейв ил ХХК	Хатгал тосгоны Жанхайн цагаан эрэг	98380909, 99993916	www.montravels.co m	21	60
8	Далай ээж жуулчны бааз	Батсарай ХХК	-	99000440, 313725, 317981	bgd@mongolnet.m n	-	-
9	Долоон уул жуулчны бааз	-	Ханх сум, Жаргалантын гол	88386633,8 8389130	doloonuul@yahoo.c om	10	20
10	Ирвэст хайрхан	Ирвэст хайрхан	Эрдэнэбулган сум Булагтайн ам	99119308, 99291098	-	9	41

	жуулчны бааз	ХХК					
11	Монгол далай жуулчны бааз	Тосгол ХХК	Хатгал тосгоны Хар толгой	99118011, 99153967	Mongoldalai.magic.net.mn	29	80
12	Мөнгөн эрэг жуулчны бааз	Мөнхсарь даг ХХК	Ханх сум	89148991594, 89041319360	hubsugul@mail.ru	16	50
13	Мөнх тур жуулчны бааз	Хүдрэнт ХХК	Хатгал тосгон, Цахир толгойн ар	314102, 99294142	-	15	20
14	Номин Хөвсгөл жуулчны бааз	Номин Хөвсгөл ХХК	Ар давхар	93079867, 99932648	Ardavhar_eco@yahoo.com	8	30
15	Жаргал жигүүр жуулчны бааз	Жигүүр ХХК	Жаргалант сум	99844895, 99821050, 98222950	jargaljiguur@yahoo.com	15	40
16	Жиглэг жуулчны бааз	Хөвсгөл лоож менежмент ХХК	Ренчинлхүмбэ сум, Тэнгис шишхэдийн голын бэлчир	99115929, 310852	www.boojum.com	6	20
17	Өгөөмөр тур жуулчны бааз	Лидер ХХК	Аймгийн төвөөс 14 км	99389999, 91004008, 91912822	Uyanga_kh@yahoo.com	25	92
18	Ласт фронтир жуулчны бааз	Саяан Радиан ХХК	Ханх, Хирвэстийн өвөр	99885812, 88089141	www.sayan-radian.mn	20	40
19	Сарьдаг инн жуулчны бааз	Хөвсгөл лоож менежмент ХХК	Ренчинлхүмбэ сум, Тэнгис шишхэдийн голын бэлчир	99115929, 310852	-	6	40
20	Сант жуулчны бааз	Голден алмонд ХХК	Хатгал тосгон Хүзүүвчийн шил	91997889, 99237494	khuvsgulsant@ymail.com	14	64
21	Фиш монгол жуулчны бааз	-	Баянзүрх Цагаан булан	98380018, 98982223	-	4	12
22	Замаат жуулчны бааз	Ноён гол ХХК	Ренчинлхүмбэ сум	99287635	-	10	20
23	Тайгын жуулчны бааз	Энх-Од ХХК	Хөгийн гол, Цахирын үзүүр	-	-	12	24
24	Тойлогт жуулчны бааз	Хөвсгөл трейвил	Хатгал тосгоны Тойлогтын үзүүр	99112273, 99092273, 99115771	Khovsgol_travel@mongol.net	23	67
25	Тойн голын жуулчны бааз	Монрос тур ХХК	Ханх сум Тойн гол	-	Lake_hovsgol@yahoo.com	-	-
26	Тэнгис жуулчны бааз	Инголзол оот ХХК	Ренчинлхүмбэ сум, Тэнгис шишхэдийн голын бэлчир	99363555,316455	-	3	15

27	Хөх сувд жуулчны бааз	Энхэт ХХК	Хатгал сум, Өвөр бунхантын ам	99117808, 99143225	www.bluepearltour.com	30	150
28	Хөвсгөл усан зам жуулчны бааз	Номин турс ХХК	Хатгал сум, Цахир толгой	99090182	www.hovsgoltravel.com	8	-
29	Хөвсгөл сор жуулчны бааз	Карпат ХХК	Хатгал сум, Жанхайн өвөр царам	99054601, 99050046	Khuvsgul_travel@yahoo.com	20	60
30	Харуул занги жуулчны бааз	ХЦ0119-р анги	Хатгал сум, Онголигийн цагаан эрэг	98163898, 99022424	info@haruulzangi.com	14	33
31	Хирвэстэг жуулчны бааз	Жим ганц нуур ХХК	Хатгал сум, Хирвэстэг	99759708	-	6	27
32	Хөвсгөл далай жуулчны бааз	Монгол нуур ХХК	Хатгал сум, Доод модот булан	98114408, 99114408	www.huvsguldalai.mn	15	60
33	Хатгал гэр жуулчны бааз	Эй жи Пи ХХК	Хатгал сум, Цахир толгойн зүүн суга	98100130, 99110130, 98000130	-	12	60
34	Хангарьд жуулчны бааз	Тэс групп	Хатгал сум, Доод модот булан	98380009, 99264484	www.ashihai.mn	19	58
35	Хөг жуулчны бааз	Инголзол оот ХХК	Ренчинлхүмбэ сум, Тэнгис шишхэдийн голын бэлчир	99363555	-	3	15
36	Энотэг жуулчны бааз	Ерлөг ХХК	Хатгал сум, Цахир толгойн зүүн суга	98386105, 99509975	-	18	60
37	Энхбулган жуулчны бааз	Мелоди тур ХХК	Эрдэнэбулган сум	99127630, 99116942	-	8	30
38	Эврика плюс жуулчны бааз	Шадарван ХХК	Бүрэнтогтох сум, Төмөртэйн ам	91387544, 88764453	-	11	40
39	Эртний далай жуулчны бааз	Нүүдэл трейд ХХК	Чандмань-Өндөр сум, Алагцарын голын ам	98021222, 91005838	info@nomadictrade.mn	-	-
40	Эм Эс Гэст хаус жуулчны бааз	Мөнх-Сарьдаг ХХК	Хатгал тосгоны төвд	99796030, 98380366	Lake_hovsgol@yahoo.com	7	16
41	Эко тур жуулчны бааз	Хотгойдын сан	Хатгал сум, Доод модот булан	99082552, 98389494	www.khuvgulecotor.mn	15	50
42	ЭгТур жуулчны бааз	Эгийн эх ХХК	Хатгал сум, Жанхайн өвөр царам	98986669, 99276669	www.egtur.mn	12	60

Хүснэгт №8.4. Зоогийн газар, ресторан

№	Зоогийн газар, ресторан нэр	Аж ахуй нэгжийн нэр	Байршил	Утас	Цахим хаяг	Нэг ээлжиндээ хүлээж авах хүчин чадлын тоо
1	Анд зоогийн газар	Батмөрөн брэнд ХХК	Мөрөн сум 8-р баг, 3-р хороо	70384477, 99384466	nbattur@yahoo.com	120 хүн
2	Жаргалан зоогийн газар	-	Мөрөн сум, 3-р хороо	98629652, 96389494	-	350 хүн
3	Хариад зоогийн газар	-	Мөрөн сум 8-р баг	99085288, 99386788	-	120 хүн
4	M andM pub, restaurant	-	Мөрөн сум, 8-р хороо	89051002, 88115547	Mgl_ngb@yahoo. Com	50 хүн

Хүснэгт №8.5. Рашаан сувилал

№	Рашаан сувилалын нэр	Аж ахуй нэгжийн нэр	Байршил	Утас	Цахим хаяг	Нэг ээлжиндээ хүлээж авах хүчин чадлын тоо
1	Булнайн рашаан сувилал	Хөвсгөл Булнай ХХК	Чандмань-Өндөр сум	91917098, 99760253	Huvsgul_bulnai2008@yahoo.com	25-40 хүн
2	Халуун ус рашаан сувилал	Нэмэх трейд ХХК	Галт сум	91118082, 98180082	-	200 хүн


8.2.1.3. Гадаргын аялал рекреацийн үнэлгээ

Хөвсгөл аймгийн аялал рекреацийн үнэлгээг хийхийн тулд ландшафтын нэгдсэн үнэлгээ (хотгор, гүдгэр, уур амьсгал, ургамал, амьтан, ус, гадаргын ус) болон түүх, соёлын үнэлгээг хийх хэрэгтэй.

Хөвсгөл аймгийн хотгор гүдгэрийн аялал рекреацийн үнэлгээ

Хөвсгөл аймгийн хотгор гүдгэр, тухайлбал гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу нь байгалийн бусад иж бүрдлийнхээ хамт тухайн нутагт рекреацийн үйл ажиллагааг явуулах боломжийг тодорхойлогч гол хүчин зүйл болдог. Улмаар аялал рекреацийн төрлийг нэмэгдүүлэх, эсвэл хязгаарлах нөлөө үзүүлдэг. Тухайлбал, эдгээр нь технологийн маш чухал хүчин зүйл бөгөөд рекреацийн төрөл бүрийн барилга байгууламж, амралт, сувилалын газрууд, жуулчны бааз, хүүхдийн зуслан зэрэг байгууламжийг байршуулахад нөлөөлөх тул уулын чулуулаг, түүний бүтэц, жуулчны тээврийн хэрэгслэлийн туулах чадвар, аюулгүй ажиллагааг хангах магадлал зэргийг сайн тооцох шаардлагатай юм. Энэ нь рекреацийн үйл ажиллаган дахь эрсдлийг багасгана. Хөвсгөл аймгийн хотгор гүдгэрийн үнэлгээг хийхдээ газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээг гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу гэсэн

гурван шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийсэн. Л.Баясгалангийн (2010) шалгуур, шатлалыг баримтласан.




Зураг №8.1. Хотгор, гүдгэрийн аялал, рекреацийн зураг

Судалгааны үр дүнд тус аймгийн нутагт гадаргын хувьд аялал рекреацийн сул, дунд, өндөр үнэлгээтэй ландшафтын хэв шинжүүдийг ялган тогтоосон болно. Сул үнэлгээтэй гарсан нутгуудад дэд бүтцийг хөгжүүлэх нэн шаардлагатай байна. Гадаргын хотгор гүдгэрийн хослолууд нь ландшафтын бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хамт тус газарт аялал-рекреацийн олон төрлийн үйлдлийг хийж болно. Улаан уул, Цэцэрлэг, Жаргалант, Шинэ-Идэр, Галт, Төмөрбулаг, Баянзүрх, Улаан уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Чандманьэрдэнэ, Цагаан үүр, Тариалан, Түнэл сумдын нутагуудад өндөр чадавхи илэрсэн тул байгалийн аялал жуулчлал болон, тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

8.2.1.4. Уур амьсгалын рекреацийн үнэлгээ

Хөвсгөл аймгийн уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон нар гийгүүлэх хугацаа, агаарын температурын хоногийн дундаж 10^0 ба түүнээс дээш байх өдөр, агаарын харьцангуй чийгийн дундаж, 13 цагт (1-р сар, 4-р сар, 7-р сар, 10-р сар), цасан бүрхүүлийн зузаан, тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацаа гэсэн 5 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийлээ.




Зураг №8.2. Уур амьсгалын аялал рекреацийн зураг

Бидний судалгаагаар Хөвсгөл аймагт аялал рекреацийн тохиромжтой хугацаа нь олон жилийн дунджаар 70-90 хоног байна. Уур амьсгалын хувьд өндөр, дунд, сул үнэлгээтэй нутгууд ялгарч байна. Өндөр чадавхитай Улаан уул, Ренчинлхүмбэ, Цагаан нуур, Ханх, Цагаан үүр сумдын нутгуудад аялал жуулчлалын төрлүүдийг аялал жуулчлалын нөөцөөсөө хамаараад хөгжүүлэх боломжтой. Өвөл, хаврын улиралд Цэцэрлэг, Цагаан уул, Шинэ-Идэр, Галт, Тосонцэнгэл, Их уул, Тариалан, Түнэл, Арбулаг, Баянзүрх зэрэг сумдуудад харьцангуй сэрүүвтэр, хүйтэн байдаг учраас аялал-рекреацийн төрөл хязгаарлагдмал байна. Энэ үед спорт тоглоомын шинжтэй, хүний биеэс дулаан ялгаруулах үйлдэлтэй аялал рекреацийн төрлийг илүү явуулах нь зохимжтой.

8.2.1.5. Гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээ

Гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээ

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр нь Хойд мөсөн далайн ай савд багтаж Монгол орны хамгийн гүн, цэнгэг устай Хөвсгөл нуур, түүний цутгал гол мөрөн ихтэй усзүйн сүлжээ сайн хөгжсөн. Хөвсгөл аймгийн гадаргын ус, рашааны рекреацийн нөөцийн үнэлгээг 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар Үндэсний атласаас “Голын сүлжээний нягтшил” 1:12000000 масштабтай газрын зургийг, “Рашаан”, “Гол мөрний нийлбэр урсац” 1:9000000 масштабтай газрын зургуудыг тулгуур материал болгон ашиглав.




Зураг №8.3. Гадаргын ус, рашааны аялал рекреацийн зураг

Гол мөрөн, нуур цөөрөм нь аялал рекреацийн гол нөөц болдог. Иймээс Хөвсгөл аймагт Хөвсгөл нуурын эрэг орчимд түшиглэн тусгай сонирхолын аялал жуулчлалын төрөл болох усан спорт аяллын шинэ төрлүүдийг хөгжүүлэх, өвлийн улиралд спорт аяллын бусад төрлүүдийг боломжтой. Улаан уул, Ренчинлхүмбэ, Цагаан нуур сумдын нутагт ус зүйн сүлжээнд түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

8.2.1.6. Хөвсгөл аймгийн ургамалжилтын аялал рекреацийн үнэлгээ

Хөвсгөл аймгийн ургамалжилтын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон “Ургамлын бүлгэмдлийн хэв шинж”, “Нутаг дэвсгэрийн ойрхог байдал”, “Ховор ургамал” гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийсэн.




Зураг №8.4. ургамалжилтын аялал рекреацийн зураг

Зургаас үзэхэд ургамалшил нь дундаж өндөр уулын нуга, өмнөд болон дунд тайга, ой, хээрийн ландшафтын хэв шинж бүхий нутгуудад өндөр, ойт хээр, хуурай хээр, нуга намгархаг хэв шинжүүдэд дунд, харин өндөр уулын ян сарьдагт сул үнэлгээтэй гарсан байна. Түүнчлэн Хөвсгөл нуурын эргэн тойронд 200 гаруй зүйлийн эмийн болон ашигт ургамал ургадаг. Монгол оронд нэн ховорт тохиолдох 17 зүйл ургамал, Монголын улаан номонд орсон 28 зүйл ургамал ургадаг. Хөвсгөл аймгийн Цагааннуур, Ренчинлхүмбэ, Чандмань өндөр, Эрдэнэбулган, Цэцэрлэг, Жаргалант, Ханх, Хатгал, Улаан уул, Алаг эрдэнэ сумдуудад дийлэнх хэсэг ургамалжилтын хувьд өндөр үнэлгээтэй гарсан ба эдгээр нутгуудад улсын тусгай хамгаалалтанд авсан газрууд ч орсон байна. Тиймээс байгалийн болон цэцэг ажиглах аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

8.2.1.7. Хөвсгөл аймгийн ховор амьтны рекреацийн үнэлгээ

Хөвсгөл аймгийн амьтны рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон “Загас”, “Шувууны газарзүйн мужлалт, ховор шувуу”, “Хөхтөний газарзүйн мужлалт, ховор хөхтөн” гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:10000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийсэн.




Зураг №8.5. Ховор амтны аялал рекреацийн зураг

Бидний судалгаагаар ховор амтны аялал рекреацийн үнэлгээгээр Цагаан нуур, Улаан уул, Ренчинлхүмбэ, Ханх, Хатгал, Чандмань өндөр, Цагаан үүр сумдуудын нутгууд өндөр, Баянзүрх, Алаг Эрдэнэ, Түнэл, Эрдэнэбулган, Тариалан, Ихуул, Рашаант сумдын нутгууд дунд, Цагаан уул, Цэцэрлэг, Арбулаг сумдын нутгуудад сул хэв шинж ялгарсан. Хөвсгөл нуурын усанд 9 зүйлийн загас амьдардаг бөгөөд агнуурын ач холбогдол бүхий 6 зүйлийн загас байна. Хөвсгөлийн ай савд Монгол улсын амтны аймгийн тухай хуулийн нэн ховор амьтан гэсэн жагсаалтанд орсон 2 зүйл, 2001 оны Засгийн газрын 164-р тогтоолоор баталсан ховор амтны жагсаалтанд орсон 10 зүйл байгаа ба Монгол улсын Улаан номонд орсон 12 зүйл шувуу бүртгэгдсэн байна Жишээ нь өндөр чадавхитай Улаан уул, Цагаан нуур, Ренчинлхүмбэ, Чандмань өндөр, Цагаан үүр нутгуудад нэн ховор амтны ул мөрөөр аялах аялал жуулчлал, Цагаан нуур, Улаан уул, Ренчинлхүмбэ, Ханх, Хатгал, Цагаан үүр сумдын нутгуудад шувуу ажиглах аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Сангийн далай нуур, Хөвсгөл нуур Эрхэл нууранд загасчлах аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх боломжтой.

8.2.1.8. Хөвсгөл аймгийн ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээ

Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээгээр ландшафтын болон аялал-рекреацийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг олж тогтоох, ашиглаж байгаа болон ашиглаж болохуйц газруудад учирч буй эрсдэл, энэ эрсдлийг бууруулах болон арилгах боломж, хүн ам

байнга оршин суудаг болон эзэмшигдээгүй нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудал, түүнтэй уялдан тухайн газарт аялал-рекреацийн нутаг дэвсгэрийн систем бүрэлдэх урьдчилсан нөхцлийг илрүүлэх нь зүйтэй. Тиймээс Хөвсгөл аймгий ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээг байгалийн иж бүрдүүлүүдийн үзүүлэлт бүрээр хийсэн үнэлгээнийхээ үр дүнг нэгтгэж, гаргав.




Зураг №8.6. Ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээний зураг

Эдгээрээс тус аймгийн уулын нуга, нуга намгархаг, умард хуурай хээр, бүхий 9 ландшафтын хэв шинж нь ландшафт рекреацийн сул чадавхитай, ар хажуугийн ойн тайгын дундад, ойн, тэгш гадаргатай хээр, торлог гэсэн 7 хэв шинж нь дунд чадавхитай байна. Харин ян сарьдаг бүхий ландшафт өндөр, дундад тайгын болон өмнөд тайгын хэв шинжүүд нэн өндөр чадавхитай гарсан болно. Хөвсгөл аймгийн Жаргалант, Цагаан нуур, Цагаан үүр сумдын нутгуудад аялал рекреацийн өндөр чадавхитай учраас байгалийн аялал жуулчлал, спорт аялал жуулчлал, тусгай сонирхолын аялал жуулчлал, адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

8.2.1.9. Байгалийн үзэсгэлэнт газар, түүх-соёлын дурсгалуудын аялал-рекреацийн үнэлгээ

Хөвсгөл аймгийн байгалийн үзэсгэлэнт газар болон түүх соёлын дурсгалуудын аялал рекреацийн үнэлгээг хийхийн тулд засаг, захиргааны нэгж болох тухайн сумын нутаг дэвсгэр

дэхь дурсгалуудын жагсаалтыг гаргаж, үр дүнгээр нь тоон утгыг тооцсон. Энэ тоон үзүүлэлтэнд үндэслэн Хөвсгөл аймгийн байгалийн үзэсгэлэнт газар түүх-соёлын чадавхийн аялал-рекреацийн үнэлгээг дөрвөн шатлал, шалгуур үзүүлэлтээр үнэлсэн.




Зураг №8.7. Түүх, соёлын аялал рекреацийн үнэлгээний зураг

Бидний судалгаагаар Хөвсгөл аймгийн байгалийн үзэсгэлэнт газар болон түүх-соёлын аялал-рекреацийн нэн өндөр үнэлгээтэй Галт, Түнэл сумд өндөр үнэлгээтэй Цэцэрлэг, Бүрэнтогтох, Улаан-Уул сумд өндөр үнэлгээтэй, бусад сумууд нь дунд, сул үнэлгээтэй гарсан байна. Тиймээс нэн өндөр, өндөр чадавхитай Галт, Түнэл, Бүрэнтогтох, Улаан-Уул сумдын нутгуудад түүх, соёл, угсаатны аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Ренчинлхүмбэ, Цагаан нуур, Улаан уул зэрэг сумдуудад угсаатны аялал жуулчлалыг, Цагаан уул, Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Галт, Төмөрбулаг, Баянзүрх, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Улаан уул, Чандмань өндөр, Арбулаг, Мөрөн сумдуудад соёлын аялал жуулчлалыг, Арбулаг суманд түүхийн аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх боломжтой.

8.2.1.10. Аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээ

Аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээг хийхдээ засаг, захиргааны хувиарыг баримтлав. Тэгэхдээ түүх, соёлын аялал-рекреацийн чадавхийн түвшинг


ландшафт-рекреацийн чадавхийн дундаж түвшинтэй харьцуулж тухайн цогцолборт нутаг дэвсгэрийн аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээг хийсэн. Хөвсгөл аймгийн ландшафт-рекреацийн чадавхийн дундаж түвшинг, тус нутагт ландшафтын ямар хэв шинж хамгийн их нутгийг хамарч байгаагаар буюу картограммын аргаар тодорхойлов. Хөвсгөл аймгийн аялал-рекреацийн чадавхийн интеграль үнэлгээний түвшинг тодорхойлохын тулд Л.Баясгалангийн “Өвөрхангай аймгийн аялал-рекреацийн чадавхийн рекреацийн иж бүрэн үнэлгээ” хийсэн аргазүйн дагуу шатлал боловсруулж ашиглав.



Зураг №8.8. Аялал рекреацийн үнэлгээний зураг

Хөвсгөл аймгийн засаг захиргааны нэгж сумаар авч үзвэл аялал рекреацийн өндөр чадавхитай нутгуудад Цэцэрлэг, Жаргалант, Галт, Улаан-уул, Цагаан нуур, Цагаан-үүр, Түнэл сумд, дунд чадавхитай нутгуудад Цагаан-Уул, Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Баянзүрх, Ренчинлүмбэ, Ханх, Чандмань-Өндөр, Алаг-Эрдэнэ, Эрдэнэ-Булган, Тариалан, Их-Уул сумуудын нутаг дэвсгэр, харин сул чадавхитай Төмөрбулаг, Арбулаг, Тосонцэнгэл, Рашаант гэсэн сумдын нутаг дэвсгэр гарсан байна. Нэг нэгэнтэйгээ зэрэгцэн оршиж буй нутаг дэвсгэрүүдийг үнэлгээний төстэй үзүүлэлтүүдээр нэг ерөнхий ареальд оруулж нэгтгэх замаар бүсчилсний үр дүнд аялал рекреацийн чадавхиараа өндөр, дунд, сул гэсэн гурван түвшний ялгаатай нутгууд илэрч байна. Аялал рекреацийн чадавхиараа өндөр Цэцэрлэг, Жаргалант, Галт, Улаан-уул, Цагаан нуур, Цагаан-үүр, Түнэл сумдуудад

байгалийн болон түүх, соёлын, тусгай сонирхолын аялал жуулчлалын олон төрлийг хөгжүүлэх боломжтой.



Зураг №8.9. Аялал рекреацийн нэгдсэн үнэлгээний зураг

8.2.2. Аялал-рекреацийн бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөлт**8.2.2.1. Хөвсгөл аймагт хөгжүүлэх боломжтой аялалын төрлүүд**

Аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн онцлог, суурь нөөцөд тулгуурлан цаашид дэмжин хөгжүүлэх аяллын төрлүүдийг тодорхойлж байна.

Хүснэгт №8.6. Хөвсгөл аймагт хөгжүүлэх боломжтой аялал жуулчлалын төрлүүд

№	Аялал жуулчлалын бүсүүд сумаар	Түүх соёлын дурсгал	Байгалийн үзэсгэлэнт газрууд болон ховор нэн ховор ургамал амьтан	Цаашид хөгжүүлэх боломжтой аялалын төрөл
1	Аялал рекреацийн өндөр чадавхтай нутгуудад Цэцэрлэг, Жаргалант, Галт, Улаан-уул, Цагаан нуур, Цагаан-үүр, Түнэл сумд	Морьгойн толгойн хадны зураг, Хүүхдийн овооны хадны зураг, Цагирын хадны зураг, Харганатын амны хадны зураг, Цахиуртын түрэг бичээс, долоон нуурын түрэг бичээс, Уран амны монгол булш, Бартын буган хөшөө бш, Галтын 3-р бригадын буган хөшөө 4ш, хөшөөтийн буган хөшөө 11ш, Аргайн голын түрэй, хөгийн өндөр модны булшнууд, Хураачийн амны буган хөшөө 2ш, Жаргалантын, Гожигийн боомтны хадны зураг, Хөгийн боомтны газар Бурхан нуурын хадны бичээс, Бугат бэлийн хадны зураг, Буянт эргийн хадны зураг, Хүнх цахир бага харганатын хадны зураг, Бичигт булгийн хадны зураг,	Гандан нуур, Улаан бэлчир, Үзүүр барзан, Хөнжлийн халуун рашаан, Тэнгис шишхэдийн сав газар, Даян дээрхийн агуй,	<p>Байгалийн аялал жуулчлал буюу эко аялал жуулчлал: Дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн үзэсгэлэнт нутаг харьцангуй богино зайнд байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинжийг сонирхох аяллыг зохион байгуулах боломжтой.</p> <p>Явган/морин аялал</p> <p>Нэн ховор амьтан түүний ул мөрөөр аялах аялал: Хорьдоль сарьдаг уулын зүүн хэсэг нь дархан цаазтай газарт багтах бөгөөд энд сибирь хандгай, ойн цаа буга, аргаль, явлаг сар, усны цагаан сүүлт, бүргэд зэрэг ховор амьтад, жигүүртэн шувууд оршдог.</p> <p>Түүх соёлын аялал: Тус бүсэд 16 ширхэг түүх, соёлын хосгүй буган хөшөөнүүд бий. Уран уулын булш мөн хадны зургууд олноор бий.</p> <p>Шувуу ажиглах аялал: Хөвсгөл нууранд усны шувуудын цуглааныг ажиглах аяллыг 5-6 саруудад зохион байгуулах боломжтой.</p> <p>Цэцэг ажиглах аялал жуулчлал</p> <p>Ан агнуурын аялал: Уулс орчмоос цагаан зээр, ойн булга, чандага, баавгай, үнэг, шилүүс, нохой зээх, бор гөрөөс, гахай зэрэг амьтныг тусгай зөвшөөрлөөр агнаж болно.</p> <p>Уулын аялал: Хорьдольсарьдагийн нуруу дархан цаазат газар, Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар, Улаан тайга байгалийн цогцолборт газруудад байгалийн үзэсгэлэнт газруудыг харах боломжтой.</p> <p>Усан аялал: Хөвсгөл нуураар завиар аялах боломжтой</p> <p>Цаатан амьдралтай танилцах болон угсаатны аялал: Дархад, Хотгойд, Урианхай, Буриад,</p>

				<p>Цаатан ястан малчин айлд зочлон нүүдэлчин ахуйтай танилцах, соёл зан заншил, нутгийн зан үйлд суралцах, хоол цай амтлах, “Нүүдэлчдийн хотхон” байгуулах зэрэг сонирхолтой идэвхитэй аяллыг нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой.</p> <p>Агуйн аялал жуулчлал: Даян дээрхийн агуй нь байгалийн өвөрмөц тогтоцтой, олон төрлийн рашаантай улсын тусгай хамгаалалтанд авсан газар учраас агуйн аялалыг хөгжүүлэх боломжтой.</p> <p>Эрүүлжүүлэх аялал жуулчлал: Булнайн рашаанд түшиглэн байгалийн сайханд эрүүлжүүлэх аялал жуулчлалыг дотоод гадаадын амрагч аялагчдадын дунд хөгжүүлэх боломжтой.</p> <p>Эрдэм шинжилгээ, судалгааны аялал</p> <p>Ардын язгуур урлагийн бэсрэг наадам, олон ястны хурим найрын ёслол, монгол гэр барих, буулгах, үйлдвэрлэх ажиллагаа, нүүдэлчдийн хотхон байгуулах, бий биелэгээний их наадам, овоо тахилгын бэсрэг, мөсний баяр эсгий хийх, мал хяргах уралдаан, цагаан идээ боловсруулах, арвайн гурил хийх үзүүлэх сургууль, морин пологийн тэмцээн, сарлагийн пологийн тэмцээн, сарлагаар нүүдэл хийх, Цаа бугаар нүүдэл хийх, Хөвсгөл нуурын элсэн дээрхи спортын тэмцээн, Хөвсгөл нууранд усан спорт аялал хөгжүүлэх, цаатан фестиваль, морь болон нохой чарганы уралдаан, Тэшүүрийн марафон зэрэг эвентүүдийг зохион байгуулах боломжтой.</p>
2	Аялал рекреацийн дунд чадавхитай нутгуудад Цагаан–Уул, Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Баянзүрх, Ренчинлүмбэ, Ханх,	Агаарын бригадын буган хөшөө, Бор хужирын голын буган хөшөө, өвгөд бригадын буган хөшөө, Зүүлийн огторын хүн чулуу, Өвөр булгийн хөх толгойн Орхон-Енисейн бичигт гэрэлт хөшөө, Тэсийн гэрэлт хөшөө, Тэсийн түрэг бичээс,	Сангийн далай нуур, Өрөмчийн булан, Арсайн хүрхрээ, Зуун нуур, Улаантайга БЦГ, Тэнгис шишхэдийн боргио, Ууширын	<p>Түүх соёлын аялал: Мөрөн хотын ойролцоо Дэлгэрмөрний хөндийд 14 ширхэг түүх, соёлын хосгүй буган хөшөөнүүд бий. Мөн Хөвсгөл аймагт нийтдээ хадны сүг зураг, бичээс, буган хөшөө 30 гаруй бий.</p> <p>Байгалийн аялал жуулчлал буюу эко аялал жуулчлал: Дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн үзэсгэлэнт нутаг харьцангуй богино зайд</p>

<p>Чандмань-Өндөр, Алаг-Эрдэнэ, Эрдэнэ-Булган, Тариалан, Их-Уул сумуудын нутаг дэвсгэр</p>	<p>Зүүн голын буган хөшөө 9ш, Хяраагийн эхний буган хөшөө, Дөрвөлжин амны буган хөшөө 3ш, Нүхтийн амны амны буган хөшөө, Хөнгийн сугийн буган хөшөө, Цохиотын амны буган хөшөө, Төв дахь хөшөөнүүд, Хушаатын амны буган хөшөө, Хөшөөгийн хадны зураг, Тайгад буган хөшөө, тогосын буган хөшөө, тэхийн үзүүрийн буган хөшөө, Долоодойн хиргисүүр, даянгийн хиргисүүр, Орос хадны бичээс, Хирвэстэс толгойн бичээс, Булжихын голын буган хөшөө, Бадрахын нурууны буган хөшөө, Дадгийн өвөлжөөний хүн чулуу, Шивээт улааны цогцолбор дурсгал хүн чулуу, Уран амны монгол булш, Уушгийн өврийн буган хөшөө 13ш, Дэлгэрмөрний хөндийн буган чулуу</p>	<p>хүрхээ, Борцын хясаа, Хорьдол сарьдаг нуруу, Булнайн халуун рашаан, Бортуун хясаа, Бух мөргөлдөх хад, Улаан хясаа, Намнан уул, Тархи гол, Хөвсгөл нуур, Хорьдол сарьдаг, Хөвсгөлийн уулс, Навчхүү, Улаан дөш уул</p>	<p>байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинжийг сонирхох аяллыг зохион байгуулах боломжтой.</p> <p>Явган болон морин аялал Эрүүлжүүлэх аялал жуулчлал: Булнайн рашаанд түшиглэн байгалийн сайханд эрүүлжүүлэх аялал жуулчлалыг дотоод гадаадын амрагч аялагчдадын дунд хөгжүүлэх боломжтой.</p> <p>Нэн ховор амьтан түүний ул мөрөөр аялах аялал: Хорьдоль сарьдаг уулын зүүн хэсэг нь дархан цаазтай газарт багтах бөгөөд энд сибирь хандгай, ойн цаа буга, аргаль, явлаг сар, усны цагаан сүүлт, бүргэд зэрэг ховор амьтад, жигүүртэн шувууд оршдог.</p> <p>Шувуу ажиглах аялал: Хөвсгөл нуур болон Сангийн далай нууранд усны шувуудын цуглааныг ажиглах аяллыг 5-6 саруудад зохион байгуулах боломжтой.</p> <p>Цэцэг ажиглах аялал жуулчлал Ан агнуурын аялал: Уулс орчмоос цагаан зээр, ойн булга, чандага, баавгай, үнэг, шилүүс, нохой зээх, бор гөрөөс, гахай зэрэг амьтныг тусгай зөвшөөрлөөр агнаж болно. Цагаан нуур, Тарган, Хармай зэрэг нуураас загас барих боломжтой.</p> <p>Уулын аялал: Хорьдольсарьдагийн нуруу дархан цаазат газар, Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар, Улаан тайга байгалийн цогцолборт газруудад байгалийн үзэсгэлэнт газруудыг харах боломжтой.</p> <p>Усан аялал: Хөвсгөл нуураар завиар аялах боломжтой</p> <p>Цаатан амьдралтай танилцах болон угсаатны аялал: Дархад, Хотгойд, Урианхай, Буриад, Цаатан ястан малчин айлд зочлон нүүдэлчин ахуйтай танилцах, соёл зан заншил, нутгийн зан үйлд суралцах, хоол цай амтлах, “Нүүдэлчдийн хотхон” байгуулах зэрэг сонирхолтой идэвхитэй аяллыг нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой.</p> <p>Ардын язгуур урлагийн бэсрэг наадам, олон ястны хурим найрын ёслол, монгол гэр барих, буулгах, үйлдвэрлэх ажиллагаа,</p>
--	--	---	---

				<p>нүүдэлчдийн хотхон байгуулах, бий биелэгээний их наадам, овоо тахилгын бэсрэг, мөсний баяр эсгий хийх, мал хяргах уралдаан, цагаан идээ боловсруулах, арвайн гурил хийх үзүүлэх сургууль, морин пологийн тэмцээн, сарлагийн пологийн тэмцээн, сарлагаар нүүдэл хийх, Цаа бугаар нүүдэл хийх, Хөвсгөл нуурын элсэн дээрхи спортын тэмцээн, Хөвсгөл нууранд усан спорт аялал хөгжүүлэх, цаатан фестиваль, морь болон нохой чарганы уралдаан, Тэшүүрийн марафон зэрэг эвентүүдийг зохион байгуулах боломжтой.</p>
3	<p>Аялал рекреацийн сул чадавхитай Төмөрбулаг, Арбулаг, Тосонцэнгэл, Рашаант</p>	<p>Бадрахын өврийн буган хөшөө, зуны голын буган хөшөө, Бадрахын өврийн буган хөшөө, Мөнх хааны Эрчүү хотын туурь, Мөнх хааны гэрэл хөшөө,</p>	<p>Олон голын бэлчир, Бүгдээний цутгалан</p>	<p>1. Түүх соёлын аялал: 3 буган чулуун хөшөө, Мөнх хааны эрчүү хотын туурь, Мөнх хааны гэрэлт хөшөө зэрэг түүх соёлын дурсгалууд байгаа учраас түүх, соёл археологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.</p> <p>2. Байгалийн аялал: Олон голын бэлчир, Бүгдээний цутгалан зэрэг байгалийн үзэсгэлэнт газар байгаа учраас түүнд түшиглэн байгалийн аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх боломжтой.</p> <p>3. Дээрхи 2 аялалын төрлийг хослуулан морин аялал болон тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.</p> <p>4. Ардын язгуур урлагийн бэсрэг наадам, монгол гэр барих, буулгах, үйлдвэрлэх ажиллагаа, нүүдэлчдийн хотхон байгуулах, бий биелэгээний их наадам, овоо тахилгын бэсрэг, мөсний баяр эсгий хийх, мал хяргах уралдаан, цагаан идээ боловсруулах, арвайн гурил хийх үзүүлэх сургууль, морин пологийн тэмцээн, сарлагийн пологийн тэмцээн, сарлагаар нүүдэл хийх зэрэг эвентүүдийг зохион байгуулах боломжтой.</p>

Санал болгож буй эдгээр аяллыг дагнасан хэлбэрээр хөгжүүлэхээс гадна хосолсон байдлаар хэрэгжүүлэх нь ач холбогдолтой юм. Мөн сумын наадам, даншиг, овоо тахилга, бэсрэг наадам зэрэг орон нутгийн тэмдэглэлт үйл явдлуудтай холбосон аяллын хөтөлбөр, тухайн бүсийн онцлогт тулгуурласан төрөл бүрийн эвент арга хэмжээг зохион байгуулах нь илүү үр дүнтэй. Морь, сарлаг, цаа буга хөлслөхөөс гадна орон нутгийн онцлогийг харуулсан гар урлалын бүтээгдэхүүн бэлэг дурсгалын зүйлсийг үйлдвэрлэхэд нутгийн иргэдийг татан оролцуулж, тэдний орлогыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр иргэд, малчдын нөхөрлөлд сургалт зохион байгуулан, эсгий урлал, нэхмэл, хатгамал, сийлбэр хийх, үндэсний хувцас дээл, малгай, хантааз оёх зэрэг өрхийн болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих боломж байна.

Боломжит аяллын төрөл, замнал

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын нийт нөөцүүдийг хэд хэдэн бүлэгт хуваан авч үзэж болох бөгөөд дараахи чиглэлийн аялалуудыг санал болгон зохион байгуулж байна.

Замнал 1.

Урд чиглэл: Мөрөн-Галын чиглэл. Мөрөн-урагшаа Цагаан-бургасны даваа30км-Бүгсэй голыг гаталж Шинэ-Идэр сум 93км-Идэр голыг гаталж Галт сум 52км-Идэр голыг өгсөж Их-Жаргалант сум 60км-Шинэ –Идэр сум 44км-Сангийн далай нуур 59км-Мөрөнгийн замд нийлэн Мөрөн 188км. Замын урт 500км, хугацаа 3-4 хоног.

Үзэх үзмэрүүд:

- Уушгийн өврийн буган хөшөө
- Алтайн улиасны рашаан
- Уран дөш уул
- Эрчүү хотын туурь
- Хөнжилийн халуун рашаан
- Өндөр Гонгорын музей
- Бартын хөшөө, хиргэсүүр
- Сангийн далай нуур

Замнал 2.

Баруун чиглэл: Мөрөн-Бүрэнтогтох 51км-Цагаан уул сум 48км-Цэцэрлэг сум 7км-эргээд Мөрөн хот 210 км. Нийт 420 км, 3-4 хоног.

Үзэх үзмэрүүд

- Дэлгэрмөрөн
- Эрчимийн нуруу
- Цагаан уул сумын Түрэггийн гэрэл хөшөө
- Бор хужирын голын хөшөө, хиргисүүр
- Цэцэрлэг сумын Могойн голын нүүрсний уурхай

Замнал3.

Хойд чиглэл: Мөрөн-Цагаан нуурын чиглэл. Мөрөнгөөс баруун тийш Арбулаг 71км-Баянзүрх-бэлтэс гол сум 56км-Улаан уул сум гунын гол 198 км-зүүн хойшоо Багтахын голыг уруудаж Рэнчинлхүмбэ сум 79км-баруун хойшоо Хөгийн голыг гарч Цагаан нуур 40км-буцаад ирсэн замаараа Мөрөн хот 252 км. Нийт 700км. Хугацаа 5-6 хоног.

Үзэх үзмэрүүд

- Мөнх хааны гэрэл хөшөө
- Уширийн хүрхрээ
- Хорьдольсарьдаг уул
- Дархадын хотгор
- Долоон нуур
- Цаатан амьдрал

Замнал 4.

Зүүн хойт чиглэл: Мөрөн-Ханх-Цагаан-Үүр сумын чиглэл. Мөрөн-хойшоо Алаг-Эрдэнэ сум 63 км- Хатгал/Хөвсгөл нуур/ 39км-Хатгалаас Ханхад 170 км /Даваа гол ус ихтэй хэцүү зам. Хатгалаас Ханхад усан ба агаарын онгоцоор очих нь илүү зохимжтой./-Хатгал, Сагсан даваа 18км-Алагцарын гол 11 км, Хээгцэр, Овоогол гол, Хөхөөгийн голуудыг гатлан Чандмань-Өндөр сум 50км-Ариг голыг уруудаж, Халхан, Дархинт, Баян голуудыг гаталж Цагаан-Үүр сум 51км-Цагаан-Үүр сумаас Мөрөн 241 км. Нийт 643 км. Хугацаа 5-6 хоног.

Үзэх үзмэрүүд

- Хөвсгөл нуур, түүний сав газар
- Нэг голын гурван аваргын хөшөө
- Даян дээрхийн агуй
- Цаатан амьдрал
- Улаан номонд орсон ургамал, амьтан
- Байгалийн үзэсгэлэнт газар

8.2.2.2. Маркетингийн төлөвлөлт

Аялал жуулчлал нь бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож, борлуулах үйл ажиллагаа явуулж байдгаараа үйлдвэрлэлийн шинжтэй. Байгууллага бүрт аялал жуулчлалын улиралд ирэх жуулчдын тоо, бүтцийг тогтоох, зах зээлийн сегментийг сонгох, хэрэглэгчдийн эрэлтийг тодорхойлох, үйлчилгээний чанарыг урьдчилан тогтоох зэрэг шаардлага урган гардаг. Аймгийн хувьд одооноос байгаль орчноо хамгаалах замаар “Хүрээлэн буй орчинд ээлтэй” –гээр аялал жуулчлалыг хөгжүүлэх нь аялал жуулчлалын хөгжлийн алсыг харсан загвар стратеги болж байна.

Хөвсгөл аймгийн өнөөгийн нөхцөл байдал, аялал жуулчлалын бүсүүдийн онцлог, нөөц боломжууд, хөгжүүлэхийг зорьж буй бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогуудтай уялдан зорилтот зах зээлийг дараахь байдлаар хэсэгчлэн тэдгээрийн онцлогт тулгуурлан маркетингийн ялгаварт стратегиудыг баримтлана.

Зорилтот зах зээлийн хэсэг - дотоодын жуулчид

Дотоодын аялагчид өөрийн орны үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газруудтай танилцах, амарч зугаалах зэрэг төрөл бүрийн аялалд оролцох хүсэл сонирхолтой байдаг. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд дотоод зах зээл рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Сүүлийн жилүүдэд дотоодын аялагч амагчдын тоо эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан, тэдгээрт зориулсан нэгдсэн арга хэмжээг зохион явуулах нь илүү үр дүнтэй. Хөвсгөл нуур, Сангийн далай нуур,

Хөнжлийн халуун рашаан, Булнайн рашаан сувилал зэрэг нь дотоодын аялагчдын гол түшиц газар юм.

Хөвсгөл нуур нь Төв-Азийн хамгийн гүн нуур бөгөөд түүний усны нөөц 380 шоо км. Усны нөөцөөрөө Азид хоёрт, дэлхийд арван дөрөвт орох бөгөөд цэнгэг усны 1%-ийг агуулж байдаг. Улсын тусгай хамгаалалтанд авсан монголын хамгийн гүн нуур. Хөвсгөл нуурт усанд сэлэх тогтоосон цэгт өдрийн амрагчид ихээр очиж амардаг. Хүмүүсийн үйл ажиллагаанд багавтар өртөгдсөн ч хог хаягдал нэмэгдэх болсон байна.

Иймд Баруун бүс болон Улаанбаатар, хөдөө орон нутаг дахь дотоодын аялагчдад зөв амралтын талаар мэдээлэл түгээх, сурталчилах, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах нь дотоодын аялагчдын тогтвортой үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байна. Цаашдаа рашаан сувиллын газрын ажиллах хоногийн тоог нэмэгдүүлж, материаллаг нөхцөл, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Зорилтот зах зээлийн хэсэг - гадаадын жуулчид

Бие даан үүргэвчтэй аялагчид тур операторуудын санал болгосон үйлчилгээнд хамрагдалгүй ямар нэг хатуу төлөвлөсөн аяллын хөтөлбөргүйгээр аялалд оролцдог учраас тэднээс аль болох зайлсхийх хэрэгтэй.

Харин албан ёсны гэрээтэй багц аялагчдыг татахын тулд жуулчны мэдээллийн төв болон эко гэрт Улаанбаатар хотоос ирэх очих нислэгийн хуваарь, аймаг орон нутаг дахь байрлуулах болон хоол ундааны үйлчилгээний газруудын байршил, үйлчилгээний онцлог, холбоо барих утас, хаяг, Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, хоноглох, отоглох газрын байрлал, хаанаас морь, тэмээ, машин хөлслөн авч болох, нүүдэлчин айл малчдын нөхөрлөлийн байршил, үйлчилгээний төрөл үнийн санал, аялал жуулчлалын бүсүүдэд аялахад баримтлах зарчим зэрэг мэдээллийг түгээх шаардлагатай. Эко гэр, жуулчны бааз, малчдын нөхөрлөлүүдээр дамжуулан судалгаа санал авч цаашид ямар төрлийн мэдээлэл үйлчилгээ хэрэгтэйг тодорхойлон үйл ажиллагаандаа тусгах нь чухал. Аймгийн вэб хуудас, мэдээллийн төв, товхимол, тараах материал зэрэг мэдээллийн сувгийг ашиглах боломжтой. Аймгийн жуулчны мэдээллийн төвийг Улаанбаатар хот дахь аялал жуулчлалын мэдээллийн “Гийчин” төвийн үйл ажиллагаатай уялдуулах хэрэгтэй.

Тур оператороор үйлчлүүлж Монгол улсад ирж буй жуулчдын дийлэнх хувийг багц аяллын жуулчид эзэлдэг нь судалгаагаар тогтоогдсон. Тус аймагт аялсан олон улсын жуулчдын зах зээлийн хувьд Япон, Германчууд эзлэж байсан бол сүүлийн 2 жил Америк, Англи, Орос жуулчид ихэнх хувийг эзэлж байна. Ирж буй жуулчдын ихэнхи хувь буюу 70-80% нь байгалийн аялал жуулчлал экотуризмыг сонирхдог. Европоос ирж буй жуулчдын дийлэнх нь байгалийн сайханд амрах, аялах, явган аялах, тусгай сонирхолын аялал болох уулын аялагч, спорт аялагч, анчин жуулчин, шувуу сонирхогч зэрэг аяллуудыг сонирхон ирж байхад Азийн жуулчид тэр дундаа Япончууд чулуун давсны орд Шүдэн уулыг үзэх, чацаргана тарих арга технологитой танилцах, цаашид хамтран ажиллах зорилготой ирж байсан нь судалгаагаар тогтоогдсон. Иймд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тур операторуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, нутгийн иргэдэд түшиглэсэн хэлбэрээр зохион байгуулах стратегийг баримтлах нь зүйтэй юм. Дэлхийн өв болсон байгалийн үзэсгэлэн бүхий, ховор нэн ховор амьтдын өлгий нутгаар идэвхитэй эко аяллыг нутгийн иргэдэд түшиглэн тур операторуудын хамтын дэмжлэгтэйгээр бий болгож, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх стратеги барьж ажиллах боломжтой. Цаашдаа улсын чанартай үзэсгэлэн яармаг, уулзалт ярилцлагад тогтмол оролцон аяллын тухай мэдээлэл өгч ажиллах арга нь үр дүнтэй юм.

Жуулчны үйлчилгээг сайжруулах, орон нутгийн иргэдийг идэвхижүүлж чадавхижуулахад тур операторууд, аялал жуулчлалын төрийн бус байгууллага, гадаадын төсөл хөтөлбөрүүд, сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр орон нутаг дахь жуулчны үйлчилгээг хүргэгчдийг бэлтгэх, сургах, чадваржуулах улмаар үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хөвсгөл аймгийн хувьд аялал жуулчлалын маркетингийн үйл ажиллагаа нь *дотоодын жуулчдад* хүрээлэн буй орчинд эерэг, зохион байгуулалттай амралт, идэвхитэй аяллыг таниулахад чиглэгдэх бол *Гадаадын жуулчдад* Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийн талаарх мэдээлэл түгээх, аялал жуулчлалын бүсийн ялгавартай бодлого баримтлах, сурталчилахад чиглэгдэнэ.

Маркетингийн стратеги:

Аялал жуулчлалын зорих газрууд нь өөрчлөгдөн байгаа эрэлт хэрэгцээ, шаардлагуудыг соргогоор мэдэрч, маркетингийн үйл ажиллагаагаа шинэчилж байх хэрэгтэй байдаг. Аяллын явц, бүтээгдэхүүн, тээвэр, байршуулах зэрэг үйлчилгээний багцуудыг санал болгох зэрэг нь хэдийгээр салангид үйл ажиллагаа мэт боловч бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетингийн хувьд цогц асуудал болно.

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын бүсүүд өөр өөрийн гэсэн онцлогт тулгуурласан ялгавартай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох нь зүйтэй.

Стратеги:

1. Бусад бүс нутгуудаас ялгарах имиджийг тодорхойлох
2. Аялал жуулчлалын өөрийн нэрийн бүтээгдэхүүн шинээр гаргах, үйлдвэрлэх
3. Бүсийн онцлогт нийцүүлэн, янз бүрийн эвентүүдийг зохион байгуулах
4. Мэдээллээр хангах, түгээх
5. Тээврийн хэрэгсэл, байршуулах газрын стандартыг мөрдөх
6. Аялал жуулчлалынын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтарсан маркетингийн идэвхижүүлэлт хийх
7. Нэг жуулчнаас олох ашиг орлогыг нэмэгдүүлэх /үнийг нэмэх бус бүтээгдэхүүний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх замаар ашиг орлогыг өсгөх/
8. Хууль эрх зүйн орчныг сайжруулах
9. Байгаль хамгаалал: Үүнд:
 - Байгаль орчны хувьд эмзэг, ховордсон зүйлийг тодорхойлж, газрын зурагт байрлуулах
 - Аялал жуулчлалд зориулж байгаль орчныг хамгаалах хөтөлбөр гаргах

- Мэдээллийн самбар, хог хаягдлын менежментийг бий болгох
- Аялал жуулчлалынын үйл ажиллагаа явуулж буй компани, хувь хүн, сонирхогч талуудад мэдээлэл түгээх, байгаль орчныг хамгаалах талаар чадавхижуулах
- Байгаль орчинд ээлтэй бизнесийг сертификатжуулах, Жишээ нь: Ногоон hotel, ногоон гэрүүд, ногоон хот айл, цэцэгсийн мөр, мөөгний зам, Рашааны зам... г.м.
- Байгаль хамгаалах ерөнхий компанит үйл ажиллагааг өргөжүүлэх, Жишээ нь: байгаль орчныг хамгаалах талаар календарь гаргах, байгаль орчныг хамгаалах жижиг төсөл боловсруулах

10. Судалгаа: Үүнд:

- Байгалийн нөөцийн суурь судалгаа
- Эдийн засгийн тоо баримт
- Зах зээлийн судалгаа хийж, дүгнэлт санал боловсруулах
- Мэдээллийн сан байгуулах
- Мэдээллээ түгээх

Чанартай үйлчилгээ үзүүлж, стандартыг мөрдөх замаар дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээг бий болгох стратеги:

- Жуулчны аюулгүй байдал, даатгал
- Ур чадварыг нэмэгдүүлэх
- Үйлчилгээний чанар
- Хувь хүний хандлага
- Цэвэр орчин
- Харилцаа холбоо авч чадах байдал /интернет, гар утас г.м/
- Жуулчин юу хүсэж байгааг мэдэх
- Чанартай бүтээгдэхүүн санал болгох

Тогтвортой байдал: Ирээдүйд тогтвортой хөгжүүлэх, хэрэглэхийн тулд нөөцөө хамгаалах, хадгалах, тогтвортой амьжиргааг дэмжих стратеги:

- Бүс нутгийн хэмжээний аялал жуулчлалын дагаж мөрдөх зөвлөмж журам боловсруулах
- Ховор ан амьтдын өлгий нутгийн бүсэд дагаж мөрдөх аялал жуулчлалын эко стандартыг боловсруулах
- Жуулчдын хувьд ёс зүйтэй байх /хариуцлагатай/ нөхцлийг бүрдүүлэх
- Иргэдийн боловсрол /Аялал жуулчлал, байгаль экологи, соёлын өвийн үнэ цэнэ/
- Төрийн болон хувийн олон нийтийн байгууллага, ард иргэдийн үүрэг, олон нийтийн оролцоог хангах

Аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн онцлогт нийцүүлэн бусдаас ялгагдах бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгохдоо дараах стратегийг баримтална.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаа:

- Зах зээлийн судалгаа хийх /гадаад, дотоод/
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Бүтээгдэхүүнийхээ талаар мэдээлэл түгээх сурталчилах:

1. Уриа, лого имидж бүрдүүлэх

2. Танилцуулга, брошур гаргах
3. Үзэсгэлэн яармагт оролцох
- Сувинер бий болгох /орон нутгийн онцлог төрхийг илэрхийлсэн тухайлбал: модон бал, балны тавиурыг давсаар хийх, ирвэсийн зураг бүхий эсгий, ирвэсийн зурагтай цамц, богино өмд, малгай хийх, эсгий шаахай, гэр, ан амьтдын дүрсийг давсаар урлах... г.м /

Аймгийн жуулчны мэдээллийн төвийг байгуулах нь :

1. Аймгийн аялалын үйл ажиллагааг сурталчилах
2. Аймгийн иргэд болон гадаад, дотоодын аялагчдыг мэдээллээр хангах
3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах
4. Жуулчны статистик тоо баримттай болох
5. Байгаль хамгаалах талаар мэдлэг түгээх, сурталчилах
6. Бие даан аялагчдад үйлчилгээ, бүтээгдэхүүнийг санал болгох, танилцуулах, мэдээлэл түгээх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

Аймгийн аялал жуулчлалын веб хуудсыг Хөвсгөл аймгийн болон Соёл, спорт аялал жуулчлалын яам, Монголын аялал жуулчлалын холбоо, Монголын аялал жуулчлалын салбарын гол веб сайтад холбох шаардлагатай юм.

Аймгийн аялал жуулчлалын имидж буюу “**лого**”-г бий болгох нь ихээхэн чухал. Имидж нь аймгийн аялал жуулчлалын өвөрмөц онцлогийг тодорхойлж бусдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээний давуу талыг харуулна.

Имиджийг бүрдүүлэхдээ:

- Уламжлалт дүр төрхийг сэргээх
- Соёлын өвийг хадгалах
- Шинэ дүр төрхийг олж нээх гэсэн 3 хүчин зүйлийг нягт уялдуулах шаардлагатай.

Хөвсгөл аймгийн үндсэн имидж :

1. Дэлхийн өвд бүртгэгдсэн нутаг дэвсгэр
2. Дэлхийн хамгийн хойд захын элс
3. Дэлхийд ховордсон ирвэсийн өлгий нутаг
4. Монголын 9 гайхамшгийн нэг - Хөвсгөл нуурын экзотик, давтагдашгүй төрх байдал
5. Түүх соёлын дурсгал
6. Бий биелгээ, ардын ёс заншил
7. Жамц давс, арвайн гурил
8. Чацаргана
9. Тэсгим хүйтнийг мэдрэх ... г.м нэгэнт бүрдсэн давтагдашгүй онцлог, имидж дээр тулгуурлан, шинэ өнгө аясыг мэдрүүлсэн маркетингийн идэвхижүүлэлтийг бий болгох бололцоотой.

Хөвсгөл аймгийн хувьд дараах эвент арга хэмжээг зохион байгуулах боломжтой:

- Ардын язгуур урлагийн бэсрэг наадам
- Олон ястны хурим найрын ёслол
- Монгол гэр барих, буулгах, үйлдвэрлэх ажиллагаа

- Нүүдэлчдийн хотхон байгуулах
- Бий биелэгээний их наадам
- Овоо тахилгын бэсрэг наадам
- Уран бугуйлчдын бүс, улсын уралдаан
- Бух ноолдаан
- Хөвсгөл нуурын ханш нээх баяр
- Чацаргана хураалтын баяр
- Цасны баяр
- Эсгий хийх, мал хяргах уралдаан
- Цагаан идээ боловсруулах, арвайн гурил хийх үзүүлэх сургууль
- Морин пологийн тэмцээн
- Сарлагийн пологийн тэмцээн
- Сарлагаар нүүдэл хийх
- Тэмээн нүүдэл
- Хөвсгөл, Хяргас нуурын элсэн дээрхи спортын тэмцээн
- Хөвсгөл нууранд усан спорт аялал хөгжүүлэх

8.2.2.3. Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн цаашдын хандлага

Хүснэгт №8.7. Хөвсгөл аймгийн аялал рекреацийн өнөөгийн байдал, шинээр төлөвлөж буй газрууд

№	Сумын нэр	Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй газрууд	Шинээр төлөвлөж буй газрууд
1	Цэцэрлэг	-	-
2	Цагаан-Уул	-	-
3	Бүрэнтогтох	Эврика плюс жуулчны бааз (1га)	-
4	Шинэ-Идэр	-	3 га
5	Жаргалант	Жаргал жигүүр жуулчны бааз (1га)	-
6	Галт	Галт халуун ус жуулчны бааз(1га)	-
7	Төмөрбулаг	-	2 га
8	Баянзүрх	Фиш Монгол жуулчны бааз (1га)	-
9	Улаан-Уул	-	-
10	Ренчинлхүмбэ	Жиглэг жуулчны бааз(1га), Сарьдаг инн(1га), Замаат(1га), Тэнгис(1га), Хөг (1га) жуулчны баазууд	-
11	Цагаан нуур	-	-
12	Ханх	Долоон уул(2га), Мөнгөн эрэг(3га), Ласт фронтер(3га), Тойнгол(2га) жуулчны баазууд	-
13	Цагаан-Үүр	-	-
14	Чандмань-Өндөр	Алагцар(1га), Эртний далай(1га) жуулчны баазууд	-
15	Алаг-Эрдэнэ	-	-
16	Арбулаг	-	-
17	Тосонцэнгэл	-	2 га
18	Түнэл	-	-
19	Эрдэнэбулган	Ирвэст хайрхан(1га), Энхбулган(1га), жуулчны баазууд	-
20	Тариалан	Ашихай жуулчны бааз(1га)	-
21	Их-Уул	-	-
22	Рашаант	-	1 га
23	Хатгал	Байгаль үүд(2га), Далай ван(2га), Далай тур(2га), Монгол далай(3га), Мөнхтур(3га), Сант(2га), Тойлогт(3га), Хөх сувд(2га), Хөвсгөл усан зам(2га), Хөвсгөл сор(3га), Харуул занги(3га), Хирвэстэг(2га), Хөвсгөл далай(3га), Хатгал гэр(2га), Энотэ(2га), Эм эс гэст(3га), Эко тур(2га), Эгтур(2га) жуулчны баазууд	-
24	Мөрөн	-	-

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага

2020 он хүртэлх жуулчдын тоог урьд жилүүдийн өсөлтийн хувь хэмжээ болон хүлээн авах зорилгод тулгуурлан 2 хувилбараар тооцоолон гаргалаа.


Үүнд:

Хувилбар А: 2005 оноос хойшхи жуулчдын тооны өсөлт аажим байгаа учраас 2013-2016 оны өсөлтийг аажимаар нэмэгдэнэ гэж үзэж тооцоолоход 2020 он гэхэд 73,389 мян орчим жуулчид хүрэлцэн ирэх прогноз гарч байна.

Хүснэгт №8.8. Жуулчны тоо: Хувилбар А

Жуулчны тоо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Нийт жуулчны тоо А	37,037.4	39,259.0	42,400.0	46,640.0	52,237.0	58,505.0	65,526.0	73,389.	414,996.6
Өсөлтийн таамаглал	4.0%	6.0%	8.0%	10.0%	12.0%	12.0%	12.0%	12.0%	72.0%

2013 онд 2500 ор бүхий үйлчилгээний байгууллага байгаа бөгөөд 2020 онд түүнээс 2 дахин илүү хүчин адал бүхий байгууламж шаардлагатай болно. График 2-т үзүүлэв.



Зураг №8.10. Аялал, жуулчлалын салбарт нийт ажиллагсдын тоо

Хүснэгт №8.9. Жуулчны тоо: Хувилбар Б

Жуулчны тоо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Нийт жуулчны тоо А	37,393.5	41,880.7	54,444.9	74,829.9	83,809.5	93,866.7	105,130.7	117,746.3	609,102.2
Өсөлтийн таамаглал	5.0%	12%	30%	37.4%	12%	12%	12%	12%	127.4%

2013 оныхоос 3,1 дахин илүү хүчин чадал бүхий үйлчилгээний байгууламж шаардлагатай болно.



Зураг №8.11. Нийт жуулчны тоо

8.3. Хөвсгөл аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөлт

Үндэслэл. Хөвсгөл аймаг нь түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууддаа түшиглэн дотоод, гадаадын жуулчдын сонирхолыг татдаг, аялал жуулчлал хөгжүүлэх маш тохиромжтой нутаг юм. Хөвсгөл аймагт байгаль экологид халгүй, нутгийн иргэдийн нийгэм соёлын харьцааг хүндэтгэсэн тогтвортой аялал жуулчлал шашин, соёл, спортын болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх боломжтой.

Богино хугацааны төлөвлөлт/2014-2016 он/

Зорилго: Хөвсгөл аймагийн бүтэц зохион байгуулалт, маркетингийг сайжруулах

- Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын маркетингийг сайжруулж, сургалт, мэдээлийн төв, орон нутгийг судлах музейн үйл ажиллагааг тогтмолжуулж, сурталчилгааг өргөн хүрээтэй хийх
- Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжлийг сайжруулах
- Түүх соёлын үнэт зүйлсийг хадгалах, хамгаалах аялал жуулчлалын маршрутанд оруулах
- Хөвсгөл нуурын орчимд аялал жуулчлалын цогцолбор /аяллын чиглэл, замын тэмдэгжүүлэлт, амралтын түр буудал, үйлчилгээний цэгүүд/ байгуулах үндэс суурийг тавих
- Аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтыг дэмжих
- Дотоодын аялал жуулчлалд зориулсан аялал маршрут хөтөлбөрийг бий болгох
- Аймгийн засаг даргын эрх мэдлийн хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх зориулалтаар зарцуулж байх” Аялал жуулчлалын сан”-г байгуулах
- Жуулчны баазын үйлчилгээний стандартыг сайжруулах, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг олшруулах
- Аялал жуулчлалын ариун цэврийн үйлчилгээний байгууламжийг сайжруулах, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох
- Хөвсгөл нуурын усыг бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах
- Хөвсгөл нуурын нуурын зүүн тал Чандмань –Өндөр, Цагаан үүр, Эрдэнэбулган сумдад зэрлэг амьтны менежментийг хөгжүүлэх замаар сафари, трофейн аяллыг хөгжүүлэх

- Орон нутгийн иргэдийн гар урлалын хоршоо бүлэг нөхөрлөлийг дэмжиж бүтээгдэхүүнээ борлуулах цэг нэгжүүдийг бий болгох
- Аймаг сумын соёл урлагийн төвүүд болон хамтлаг, чөлөөт уран бүтээлчид хамтарсан жуулчдад зориулсан богино хэмжээний тоглолтын хөтөлбөр гарган ажиллах

Дунд хугацааны төлөвлөлт /2017-2021 он/

Зорилго: Хөвсгөл аймагт аялал жуулчлалын салбарт оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах замаар бүсийн аялал жуулчлалын сүлжээ байгуулж, стандартын шаардлагыг өндөржүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд холбоно.

- Хөвсгөл аймагт аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, Хар хорин, Тариат, Хөвсгөл нуур, Булган зэрэг аялал жуулчлалын бичил бүсүүдийг хамруулан цогцолбороор хөгжүүлэхийг дэмжих
- Хөвсгөл аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудыг аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр байгаль орчинд хоргүйгээр зохистой ашиглах, үйлчилгээний чанарыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх
- Аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ холбогдуулан авто замын сүлжээ, цахилгаан эрчим хүч, мэдээлэл холбооны сүлжээ бий болгох, өндөр зэрэглэлтэй зочид буудлын тоог нэмэгдүүлэх
- Аялал жуулчлал эрхлэж байгаа аж ахуй нэгж, иргэдийн татварын орлогыг тухайн тухайн орон нутагт оруулах, татвар төлөлтөнд тавих хяналтыг сайжруулахын тулд татвар төлөлтийн сүлжээнд оруулах
- Аялал рекреацийн өндөр чадавхитай нутгуудад Цэцэрлэг, Жаргалант, Галт, Улаан–уул, Цагаан нуур, Цагаан–үүр, Түнэл сумдуудад ерөнхий болон тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Хангайн бүсийн аялал жуулчлалын түшиц бүс нутаг болгон хөгжүүлэх
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Аялал жуулчлалын чиглэлээр гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих
- Хөвсгөл –Байгаль нуурын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Аялал жуулчлалын эвент арга хэмжээг тогтсон цаг хугацаанд зохион байгуулж 1 жилийн өмнөөс зарлах, интернет вэб сайтад байрлуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах
- Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар газар олгох асуудлыг төлөвлөлтийн үндсэн дээр боловсронгуй болгох, аймаг орон нутгийн оролцоог нэмэглүүлэх
- Гадаад орнуудтай харилцах, аймаг орон нутгаа сурталчлах, төлөөлөгчийн газрыг Улаанбаатар хотод ажиллуулах

Урт хугацааны төлөвлөлт /2022-2030 он /

Зорилго: Эко аялал жуулчлалын төрлийг хөгжүүлж, бүсийн эдийн засагт эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, менежментийг олон улсын стандартын

түвшинд хүргэж сайжруулна. Улмаар олон улсын аялал жуулчлалын эко бүс болгон хөгжүүлнэ.

- Аялал жуулчлалын маршрутын дагуух үзмэрийг сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх
- Аялал жуулчлалын үндсэн туслах маршрутын замыг сайжруулах
- Жуулчдын сонирхолыг татах боломжийг нэмэгдүүлэх үүднээс аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, сурвалжлан олох
- Байгалийн болон тусгай сонирхолын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх
- Халуун, хүйтэн рашаануудад түшиглэн эмчилгээ сувилалын төвүүдийг байгуулах
- Ногоон аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах
- Хөвсгөл аймгийг тусгай сонирхолын аялал жуулчлалын бүс болгох
- Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Олон улсын аялал жуулчлалын эко бүс болгох
- Олон улсын онгоцны буудалтай болох

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

9.1. Уул уурхайн газрын ашиглалтын өнөөгийн байдал, нөөцийн үнэлгээ

Хөвсгөл аймаг нь байгалийн өвөрмөц тогтоц бүхий Хөвсгөл нуур болон хамгийн их ойн болон усан сан бүхий аймаг юм. Тус аймгийн нутаг дэвсгэрт хамгийн цөөн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт 2014 оны 10-р сарын 28-ны байдлаар хайгуулын 33, ашиглалтын 16 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч үзвэл нүүрсний 5, алтны 1, барилгын материалын 7, фосфоритын 2, холимог металлын хүдрийн 1 тусгай зөвшөөрөл тус тус хүчин төгөлдөр байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээ 184.5 орчим мянган Га байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 6.7 орчим мянган Га байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар явуулсан геологийн судалгаа, эрэл үнэлгээ, хайгуулын ажлын үр дүнгээр 35 нэр төрлийн ашигт малтмалын 300 гаруй орд, илрэл тогтоогдсон байна.

Мөн Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар зэрэг газрын тосны уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсны үндсэн дээр явуулах боломжтой.

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт УИХ-аас тогтоосон стратегийн ач холбогдол бүхий 15 ордоос 1 нь буюу Бүрэнтогтох сумын нутагт орших Бүрэнхааны фосфоритын орд оршдог. Мөн тус аймгийн Цэцэрлэг сумын нутагт орших Могойн голын нүүрсний орд нь тус аймгийн нутагт нөөц нь тогтоогдсон сайн чанарын нүүрсний орд юм.


9.1.1. Хөвсгөл аймгийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн судалгаа

Хөвсгөл аймгийн хэмжээнд нийт ашиглалтын 16 тусгай зөвшөөрийг 12 аж ахуйн нэгж эзэмшиж байна. Үүнээс 8 ашиглалтын тусгай зөвшөөрөл “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуульд хамрагдсан байна. 2013 оны 5 дугаар сарын байдлаар 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулахаар 2014 оны уулын ажлын төлөвлөгөөг ирүүлээд байна.

Хүснэгт №9.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын төрөл

Д/д	Ашигт малтмалын төрөл	Тусгай зөвшөөрлийн тоо	Аж ахуйн нэгжийн тоо
1	Алт	1	1
2	Барилгын материал	7	5
3	Нүүрс	5	4
4	Фосфорит	2	2
5	Хүдэр	1	1
	Нийт	16	12

Дээрхи хүснэгтийн үзүүлэлтээс үзвэл Хөвсгөл аймагт одоогийн байдлаар нөөц нь тогтоогдсон 16 орд газар байгаагаас 5 нь нүүрсний орд газар, 1 нь алтны орд газар, 1 нь хүдэрийн орд, 2 нь фосфорит, 7 нь Барилгын материалын орд газар байна.



Зураг №9.1. Хөвсгөл аймгийн ашигт малтмал хайгуул, ашиглалтын лиценз бүхий талбай

Хүснэгт №9.2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хэмжээг аж ахуй нэгж

Д/д	Аж ахуй нэгж	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Талбай, га
1	Могойн гол	2	174.9
2	Мон-Ажнай	1	23.3
3	Олонгол трейд	3	295.2
4	Өргөн цагаан нуур	1	47.5
5	Сухайхэн цо	1	33.9
6	Топруон хэнцэ	2	80.12
7	Төв азийн гантиг	1	75.9
8	Хорих 443-р анги	1	82.81
9	Хөвсгөл зам	1	26.4
10	Хургатай хайрхан	1	5758.7
11	Эрдэс мөрөн	1	25.87
12	Эрэл	1	35.7

Хүснэгт №9.3. Гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ аймгаар

Д/д	Аймаг	Тоо	Талбайн хэмжээ /га/
1	Хөвсгөл	6	5943,5

Хүснэгт №9.4. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуульд хамрагдсан тусгай зөвшөөрлийн жагсаалт

№	ТЗ дугаар	Талбайн нэр	Эзэмшигч	Ашигт малтмал	Давхцалтай бүс
1	1356	Нүүрстэй	Хорих 443-р анги	Нүүрс	ОС, УС
2	1361	Жилчиг булаг	Мон-Ажнай	Нүүрс	ОС, УС
3	5364	Бэлчир	Эрэл	Алт	ОС, УС
4	9919	Сүхийн ам	Эрдэс мөрөн	Бар/м	УС
5	12229	Тэнгэс гол	Өргөнцагаан нуур	Бар/м	УБЭ
6	17098	Овоот	Хургатайхайрхан	Нүүрс	УС
7	13218	Хүрэмт	Олонгол трейд	Бар/м	УС
8	17076		Атлантиктрейд	Бар/м	

Хүснэгт №9.5. Хөвсгөл аймгийн барилгын материалын эрдэс түүхий эдийн орд газрууд

Д/д	Орд, ил уурхайн нэр байршил	Түүхий эдийн зориулалт	Холбогдох шийдвэр	Нөөцийн судалгаа			
				А	В	С1	С
1	Улаанхужирт Мөрөн сум	Тоосгоны шавар	ГУУЯ, ШУТЗ1981	245	158	793	290
2	Сүхийн ам Мөрөн сум	Шохойн чулуу	ГУУЯ, ШУТЗ1962	108	-	190	-
3	Нугын тохой Мөрөн сум	Элс, хайрга	ГУУЯ, ШУТЗ 1982	115	293	538	1121
4	Айзам Хатгал сум	Элс, хайрга	ГУУЯ, ШУТЗ 1969	140	368	367	260
5	Хөх толгой Мөрөн сум	Барилгын чулуу, базальт	ГУУЯ, ШУТЗ 1984	-	251	161	113
6	Эрхэмийн орд Арбулаг сум	Барилгын чулуу, боржин	ГУУЯ, ШУТЗ 1984	-	-	1486	-
7	Ширэвгэр уул Мөрөн хотоос 35 км	Барилгын чулуу, боржин	ГУУЯ, ШУТЗ 1986	Ашиглалт явагдаагүй илэрц хэлбэрээр байгаа			
8	Их дөш Цэцэрлэг сум	Хүрмэн чулуу	ГУУЯ, ШУТЗ 1983	-	222	505	887
9	Хүрмэт Арбулаг сум	Хүрмэн чулуу	ГУУЯ, ШУТЗ 1987		321	330	678
10	Хөшөөт Цагаан-Уулсум	Хүрмэн чулуу	ГУУЯ, ШУТЗ 1992	Ашиглалт явагдаагүй			
11	Цагаан чулуут Алаг-Эрдэнэ сум	Цагаанцайвар, цагаан саарал гантиг	ГУУЯ, ШУТЗ 1992	-	2300	-	-

Дээрх орд газрын судлагдсан байдлаас үзэхэд Хөвсгөл аймагт барилгын төрөл бүрийн төмөрбетон эдлэхүүн, зам талбайн өнгөт, хээтэй хавтан хашлага, тоосгоны үйлдвэрээс гадна шохой, шохойн түүхий эд бүхий сликат хөнгөн бетон, Хүрмэн бетон ханын төрөл бүрийн гулдмай, байгалийн өнгөт чулуу боловсруулах үйлдвэрлэл тухайлбал цагаан гантиг, саарал боржин өнгөлгөөний материал үйлдвэрлэх бүрэн боломжтой.

Хүснэгт№9.6. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн жагсаалт /2014-05-01-ний байдлаар/

№	Аймаг, хот	Сум, дүүрэг	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	ААН-ийн төрөл	Барьцаалагч	Ашигт малтмал	Олгосон огноо	Дуусах огноо
1	Хөвсгөл	Цэцэрлэг	MV-000384	Могойн гол	Могойн гол	89.73	Хамтарсан ХК		Нүүрс	1995.06.28	2025.06.28
2	Хөвсгөл	Бүрэнтогтох	MV-001356	Хорих 443-р анги	Нүүрстэй	82.81	УУГ		Нүүрс	1998.09.25	2028.09.25
3	Хөвсгөл	Бүрэнтогтох	MV-001361	Мон-Ажнай	Жилчиг булаг	23.29	ХХК		Нүүрс	1998.09.29	2028.09.29
4	Хөвсгөл	Ренчинлхүмбэ	MV-005364	Эрэл	Бэлчир	35.69	ХХК		Алт	2003.01.31	2033.01.31
5	Хөвсгөл	Мөрөн	MV-009919	Эрдэс мөрөн	Сүхийн ам	25.87	ХХК		Бар/м	2005.06.03	2035.06.03
6	Хөвсгөл	Түнэл	MV-011823	Топруон хэнцэ	Бүрэнхаан-9	26.68	ХХК		Фосфорит	2001.05.03	2031.05.03
7	Хөвсгөл	Бүрэнтогтох	MV-011824	Топруон хэнцэ	Бүрэнхаан-хх	53.44	ХХК		Хүдэр	2001.09.24	2031.09.24
8	Хөвсгөл	Цагааннуур	MV-012229	Өргөнцагаан нуур	Тэнгэс гол	47.5	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК		Бар/м	2006.11.22	2036.11.22
9	Хөвсгөл	Бүрэнтогтох	MV-012909	Хөвсгөл зам	Нугын тохой	26.4	ХХК		Бар/м	2007.10.31	2037.10.31
10	Хөвсгөл	Арбулаг	MV-013218	Олонгол трейд	Хүрэмт	30.65	ХХК		Бар/м	2008.01.30	2038.01.30
11	Хөвсгөл	Түнэл	MV-013813	Олонгол трейд	Улаан хужирг	77.47	ХХК		Бар/м	2008.06.17	2038.06.17
12	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	MV-017076	Төв азийн гантиг	Цагаан чулуут	75.89	ХХК		Бар/м	2012.07.17	2042.07.17
13	Хөвсгөл	Цэцэрлэг	MV-017098	Хургатайхайрхан	Овоот	5758.7	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК		Нүүрс	2012.08.10	2042.08.10

14	Хөвсгөл	Цэцэрлэг	MV-017243	Могойн гол	Могойн гол	85.21	Хамтарсан ХК		Нүүрс	2013.01.15	2043.01.15
15	Хөвсгөл	Бүрэнтогтох	MV-017398	Сутайхэн цо	Бүрэнхаан-8	33.98	ХХК		Фосфорит	2001.12.25	2031.12.25
16	Хөвсгөл	Мөрөн, Түнэл	MV-017517	Олонгол трейд	Хужиртын булаг	187.13	ХХК		Бар/м	2014.04.18	2044.04.18
17	Хөвсгөл	Улаан-Уул	XV-007557	Алтандорнод монгол	Үхэрт гол	10387.51	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2004.05.24	2013.05.24
18	Хөвсгөл	Улаан-Уул	XV-007558	Алтандорнод монгол	Бэлчир уул	58499.08	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2004.05.24	2013.05.24
19	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ, Ренчинлхүмбэ	XV-008628	Эхмөрөн	Дөшийн гол	170.81	ХХК			2004.10.25	2013.10.25
20	Хөвсгөл	Улаан-Уул	XV-008629	Эхмөрөн	Бэлтгэсийн гол	2039.96	ХХК			2004.10.25	2013.10.25
21	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	XV-008630	Эхмөрөн	Өвөр мараат гол	1027.17	ХХК			2004.10.25	2013.10.25
22	Хөвсгөл	Арбулаг	XV-008822	Монголцамхаг	Замын толгой	278.56	ХХК	Анодбанк		2004.11.25	2013.11.25
23	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ, Ренчинлхүмбэ	XV-010529	Өнгөтшүр	Хатгал	2147.23	ХХК			2005.09.29	2014.09.29
24	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	XV-011330	Топлаки	Бага тээг	2374.89	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2006.02.09	2015.02.09
25	Хөвсгөл	Цагаан-Үүр	XV-012766	Миллениумдисловери	Армаг гол	3592.07	ХХК			2007.10.04	2016.10.04
26	Хөвсгөл	Бүрэнтогтох	XV-012816	Чилчиггол	Чилчигийн гол	250.14	ХХК			2007.10.15	2016.10.15

27	Хөвсгөл	Цэцэрлэг	XV-013055	Блюскай майнинг	Баянзүрх	37994.6	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2007.12.19	2010.12.19
28	Хөвсгөл	Бүрэнтогтох	XV-013580	Блэкрот	Төмөртийн ам	1080.16	ХХК			2008.04.21	2017.04.21
29	Хөвсгөл	Цэцэрлэг	XV-013636	Хургатайхайрхан	Овоот	880.03	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.05.01	2017.05.01
30	Хөвсгөл	Цагаан-Үүр	XV-013715	И энд Жи Ар	Уйлган гол	27011.87	ХХК			2008.05.19	2015.05.19
31	Хөвсгөл	Түнэл	XV-013827	Юнайтедминералс	Бумбат уул	6661.92	ХХК			2005.12.20	2014.12.20
32	Хөвсгөл	Түнэл	XV-013928	Хаанталст	Улаан хужиртын бэл	136.35	ХХК			2008.07.25	2014.07.25
33	Хөвсгөл	Галт	XV-013934	Дасмондрилл	Бумбатын өндөр уул	5796.93	ХХК			2008.07.28	2014.07.28
34	Хөвсгөл	Бүрэнтогтох	XV-013958	Блэкрот	Мөрөн	1628.52	ХХК			2008.07.31	2014.07.31
35	Хөвсгөл	Арбулаг	XV-014024	Эм Жи Ти Жи	Зүүн хүрэн чулуут	809.45	ХХК			2008.08.18	2014.08.18
36	Хөвсгөл	Арбулаг, Бүрэнтогтох	XV-014026	Эм Жи Ти Жи	Буянт	2478.88	ХХК			2008.08.18	2014.08.18
37	Хөвсгөл	Арбулаг	XV-014027	Эм Жи Ти Жи	Нуурын	2379.01	ХХК			2008.08.18	2014.08.18
38	Хөвсгөл	Цэцэрлэг	XV-014194	Могойн гол глобал ресурс	Бүрхээр-2	2691.87	ХХК			2008.09.23	2014.09.23
39	Хөвсгөл	Бүрэнтогтох	XV-014303	Мон-Ажнай	Сайр	99.43	ХХК			2008.10.17	2014.10.17

40	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	XV-014315	И Эй Эм тэшиг	Их уул	3031.05	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.10.17	2014.10.17
41	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	XV-014426	Звездаметрика	Нэргүй	4510.99	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.11.19	2014.11.19
42	Хөвсгөл	Цагаан-Уул, Цэцэрлэг	XV-014510	Хургатайхайрхан	Хуримт-1	21750.25	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.12.04	2014.12.04
43	Хөвсгөл	Цагаан-Уул	XV-014637	Хургатайхайрхан	Хуримт-1	12200.41	гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2009.03.16	2015.03.16
44	Хөвсгөл	Арбулаг	XV-014639	Мегамайнз монголия	Сонгинот	666.51	ХХК	ХААН банк		2009.03.16	2015.03.16
45	Хөвсгөл	Түнэл	XV-014972	Мон-Ажнай	Улаан толгой	423.43	ХХК			2009.07.01	2015.07.01
46	Хөвсгөл	Бүрэнтогтох	XV-015006	Эй Эс Ти Эс	Хавчиг	1894.31	ХХК			2009.07.20	2015.07.20
47	Хөвсгөл	Бүрэнтогтох	XV-015384	Эй Эс Ти Эс	Нурамт	1715.12	ХХК			2009.12.28	2015.12.28
48	Хөвсгөл	Цагаан-Уул	XV-016751	Монгол корпораци ресурс	Цагаан уул	2360.11	ХХК			2005.11.24	2014.11.24
49	Хөвсгөл	Цэцэрлэг	XV-017003	Овоот коал майнинг	Овоот	2703.86	ХХК			2008.05.01	2017.05.01
50	Хөвсгөл	Түнэл	XV-017177	Шим-Аминаа	Чулуут	223	ХХК			2008.10.22	2016.08.03

9.1.2. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг авч үзвэл 2014 онд 2, 2015 онд 10, 2016 онд 4, 2017 онд 17 тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаар байна. Энэ оны 7-р сарын 1-нд батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг дахин 3 жилээр сунгагдах боломжтой. Хайгуулын тусгай зөвшөөрлийг 2010 оны 6-р сараас хойш олгоогүй тул хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжих боломж 4 жил бүрдэхгүй байхаар байна. Дээрх тусгай зөвшөөрлүүдээс 3 тусгай зөвшөөрөл эзэмшигч ашиглалтын өмнөх гэрээ байгуулсан тул шууд ашиглалтын тусгай зөвшөөрөл авна. Мөн хайгуулын ажлын үр дүнгээс хамаарч 4-5 хайгуулын тусгай зөвшөөрөл ашиглалтын тусгай зөвшөөрөл болох боломжтой байна.

Хүснэгт №9.7. Хөвсгөл аймгийн хайгуулын тусгай зөвшөөрлийн судалгаа

№	Сум	Тусгай зөвшөөрөл	Аж ахуйн нэгжээр	Эзлэх талбайн хэмжээ (га)
1	Алаг-эрдэнэ	5	4	13262,14
2	Арбулаг	5	3	6612,41
3	Бүрэнтогтох	6	4	6667,68
4	Галт	1	1	5796,93
5	Түнэл	4	4	7444,7
6	Улаан-уул	3	2	70926,55
7	Цагаан-уул	3	2	36310,77
8	Цагаан-үүр	2	2	30603,94
9	Цэцэрлэг	3	3	6275,76

Хөвсгөл аймгийн хэмжээнд Ашигт малтмалын газрын Геологийн албанд хянагдсан тайлангийн хэмжээнд 956.502.384.20 төгрөгийн хайгуулын зардал гарсан байна. /Жич: 2014.05.01-ний байдлаар/

9.2. Уул уурхайн газрын ашиглалтын хэтийн төлөвлөгөө**9.2.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид**

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг авч үзвэл 2014, 2015, 2016, 2017 онд 33 тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаар байна. Энэ оны 7-р сарын 1-нд батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дахин 3 жилээр сунгагдах боломжтой. Хайгуулын тусгай зөвшөөрлийг 2010 оны 6-р сараас хойш олгоогүй тул хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжих боломж 4 жил бүрдэхгүй байхаар байна. Дээрх тусгай зөвшөөрлүүдээс 2 тусгай зөвшөөрөл эзэмшигч ашиглалтын өмнөх гэрээ байгуулсан тул шууд ашиглалтын тусгай зөвшөөрөл авна. Мөн хайгуулын ажлын үр дүнгээс хамаарч 6-7 хайгуулын тусгай зөвшөөрөл ашиглалтын тусгай зөвшөөрөл болох боломжтой байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9.8. Цаашид ашиглалтын тусгай зөвшөөрөл болох боломжтой тусгай зөвшөөрлийн судалгаа

Үзүүлэлт	2015-2016	2017-2018	2019-2020	2020-2024
Хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болох боломжтой тусгай зөвшөөрлийн тоо	2	2	3	-

Цахилгаан хангамж. Эгийн гол дээр 220 МВт хүчин чадалтай усан цахилгаан станц барьж 220 кВ-ын шугамаар төвийн эрчим хүчний системд холбох, Завхан, Говь-Алтай аймгийн төвийн эрчим хүчний хангамжийг найдваржуулж төвлөрсөн эрчим хүчээр хангахын тулд Дэлгэр мөрөн дээр Чаргайтын усан цахилгаан станц, Могойн голын нүүрсний уурхайг түшиглүүлэн цахилгаан станц барьж Улиастай хүртэл 110 кВ-ын шугам барихаар төлөвлөж байна.

Төмөр зам. Хөвсгөл аймагт хамгийн ойр орших төмөр замын сүлжээ нь Эрдэнэт хот юм. Эрдэнэт хотоос Хөвсгөл аймаг хүртэл төмөр зам тавих зураг төсөл, маршрутыг хуучин төвлөрсөн төлөвлөгөөт нийгмийн үед хийж байсан. Бүрэнхааны фосфоритын ордыг ашиглах тохиолдолд Эрдэнэт-Мөрөнгийн төмөр зам тавигдах юм.

9.2.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын ашиглалтын төлөвлөлт

2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу тухайн аймагт оршиж буй орд илэрцийн хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг дарга олгож, хэрэгжилтэнд нь хяналт тавьж байхаар хуульчлагдсан юм. Зам болон барилгын салбар эрчимжтэй хөгжиж буй энэ үед Хөвсгөл аймгийн хэмжээнд аж ахуйн эргэлтэнд оруулах боломжтой Түгээмэл тархацтай ашигт малтмалын 43 ордуудыг хүснэгтээр орууллаа.

Хүснэгт №9.9 Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордууд

Барилгын элс					
1	Сортын орд	49°38'29" 99°45'00"	Мөрөн хотын төвөөс Б 27км	Орд нь шаварлаг, тоосорхог, лагархаг бодисын хэмжээ 0.04-6.11% буюу дундаж нь 1.53% байгаа нь стандартын шаардлагыг хангаж байна. Төв хэсэгтээ 10м хүртэл зузаантай, зах руугаа бүрэн алга болсон	C1=49.5 C2=9.6 (мян.м3) Ил аргаар олборлож болно.
2	Эрхэлийн орд	49°40'00" 99°42'00"	Бүрэнтогтох сумын төвөөс ЗХ 10 км	Орд нь том ба дунд ширхэгтэй элс голлон тархсан ба зузаан нь дунджаар 2м. Элсний дээд хэсэг нь хөрс ургамлын үе болон цагаан саарал өнгийн шавранцараар хучигдсан, доод хэсэг нь бараан саарал өнгийн шавраар дэвсгэгдсэн байна.	C1=2196.6 (мян.м3) Ил аргаар олборлож болно.
3	Нарст булагийн	50°32'10" 101°38'32"	Үүр, Аригийн голуудын үүлзвараас	5 км урт, 4 км өргөнтэй салхины гаралтай элсний давхарга тогтоогдсон	P2- 60мян.куб.м
Барилгын чулуу					
4	Хүрэмтийн орд	50°08'50" 99°19'25"	Ар булаг сумын төвөөс БХ 30км	Хэвтэш нь БХ бараг өргөргийн дагуу чиглэлтэй, 0.8км урт, 60-230м өргөнтэй, 1.8-21.8м зузаан. Хэвтэшийн дотоод бүтэц нь бараг нэг төрлийн. Шаарганы хэмхдэс 2x3-20x30см хэмжээтэй. Шаарганы гадаргуу хэсэг нь өгөршсөн.	V=299.3 C1=329.9 C2=769.62 (сая.м.3) Ил аргаар олборлож болно.
5	Хар чулуутын орд	50°29'40" 100°04'20"	Хатгал хотын төвөөс БХ 10-12км	Цахиурлаг, битумжсан шохойнчулуулгийг хучсан хучаас хурдасны зузаан дундажаар 0,3м. Шохойнчулуу нь бат бэх, цул структуртай. Дээд хэсэг олон тооны ан цав хагаралд автсан.	C1=593.2 сая.т

6	Их дөшийн орд	49°27'00" 97°40'00"	Цэцэрлэг сумын төвөөс 3У 7км	Орд нь Их дөш 1,2 хэсэгтэй их дөш 1 хэвтэш нь өргөргийн дагуу суналтай, 0.7км урт. 190м өргөн, 19.05м зузаан, Их дөш II-н хэвтэш нь өргөргийн дагуу суналтай. 480м урт, 190м өргөн, 19.05м зузаан. 50-100 маркийн хөнгөн бетоны дүүргэгч болно.	A+B=223.5 C1=504.6 C2=887 мян.м.3 1986 оноос ашиглаж
7	Бодь толгойн орд	49°30'00" 98°36'00"	Цагаан-Уул сумын төвөөс БУ 18км	Ордыг үүсгэгч хүрмэн чулуу нь дунд-дээд дөрөвдөгчийн үед бялхаж гарсан бөгөөд бялхалтын 2 урсгал ажиглагдана. Эхний бялхалт нь 105-115м зузаантай. Ордын шлакийн зузаалаг нь 15-20м зузаантай 0.28км2 талбайд тархсан.	C2=5663250м3
8	Мөрөнгийн орд	49°30'00" 100°10'00"	Мөрөн хотоос 3Х 5-6 КМ	Орд нь 2 участкаас бүрдэнэ. 1-р участкай биет нь тах хэлбэрийн, уртрагийн дагуу суналтай. 380м урт, 200-270м өргөн 3.4-7.6м зузаан. 2-р участкай биет нь зууван хэлбэрийн, БХ-оос 3У сунасан, 160м урт, 80-90м өргөн, 2-8м зузаан. "200" "300" маркийн бетон үйлдвэрлэхэд тохирно.	A+B=250.87 C1=151.42 C2=112.7(мян.м3) Уул техникийн нөхцөл тохиромжтой.
9	Эрхэлийн орд	49°40'00" 99°42'00"	Мөрөн хотоос БХ 32 км	Боржин нь саарал, ягаан саарал өнгөтэй, дунд зэргийн мөхлөгтэй, нягт, хатуу, гадаргуу нь өгөршсөн, ан цавархаг.	C1=1485.9 C2=1691.6 (мян.м3) Ил аргаар
10	Ширэвгэрийн орд	49°56'00" 99°50'00"	Мөрөн хотоос БХ 35 км	Орд нь 3У 1200м сунасан. 600 м өргөнтэй Бетоны туршилтаар ордын боржингийн дайргаар 200-300 түүнээс дээш маркийн бетон үйлдвэрлэж болно.	A+B+C 1=13157.3 C2=13071.7(мян.м3) Ил аргаар ашиглах
11	Шохой цахирын орд	50°14'00" 100°20'00"	Алаг-Эрдэнэ сумын төвөөс 3Х 25км	Хэвтэш нь БХ суналтай, 800-840м урт. 75-80м өргөн, 77-96.8м зузаан. Гантиг, гантигжсан шохойн чулуу нь ГОСТ-5331-63, УСТ=963-69 шаардлагыг хангаж барилгын шохойд тохирно. Технологын туршилт хийгдээгүй.	C2=4445.4 мян.т Ил уурхайгаар олборлож болно.
Элс хайрга					
12	Айзамын орд	50°16'30" 100°07'00"	Хатгал хотоос У 20км	Дээд дөрөвдөгчийн настай хөрс-ургамлын үе, элс-дайрганы хурдас тархсан. Давхрага маягийн хэвтэшийн ашигтай зузаан бүх чиглэлдээ тогтвортой. Хайгуулын талбай 6.4км2	A+B=508 C1=367.4 (мян.т)
13	Бүрэнгийн орд	49°39'40" 100°06'00"	Мөрөн хотоос БХ 4-5 км	2.3м зузаантай элс хайрганы хэвтэш тогтоогдсон. Туршилтаар элс нь өрлөг, заслын зуурмаг болон хүнд бетоны бэлдмэлд, хайрга нь хүнд бетоны дүүргэгчид тохирно.	A+B=719.1 C1=716.4 (мян.м3) Ил аргаар олборлох, нөөц өсгөх
14	Нугын тохойн орд	49°38'00" 100°01'04"	Мөрөн хотоос БХ 11-12км	Биет нь давхарга хэлбэртэй, хайгуул хийсэн ордын талбай 0.8х0.8км. "300" маркийн бетон гарган авахад тохирно.	
15	Нэргүй илрэл	49°38'00" 99°58'00"	Мөрөн хотоос Б 15 км	Элс хайрганы 2.5м өргөнтэй давхарга	Элс=0.3-0.5. элс-хайрга=2.5сая. м3

Өнгөлгөөний чулуу					
16	Цагаанчулуутын орд	50°21'00" 99°45'45"	Алаг-Эрдэнэ сумын төвөөс БХ 45км	Агуулагч чулуулаг нь доод девоны настай боржин.Гантиг, гантигжсан шохойч луу нь Хоридол уулын дэд давхаргад багтдаг.Гантигийн биет нь 1200м урттай, 320м өргөнтэй. Орд нь нөөц ба чанараараа өнгөлгөөний гантигийн үйлдвэрлэлд тохирсон түүхий эд юм.	A+B=3245.4 C1=17138.2 C2= 4971 (мян.м3) Ашиглаж байгаа
17	Эрхэлийн илрэл	49°55'00" 99°15'00"	Арбулаг сумын төвөөс БХ 15км	Магмын чулуулаг нь нэг вул каноплутон эвшлийн дунд ширхэгтэй улаавтар ягаан өнгийн лейкократ сиенит, хүрэн бор өнгийн трахиандезитын туфолав, ногоон өнгийн хүчиллэг туфолаваас бүрдэнэ.	
18	Дархинтын овоо	50°30'57" 101°17'40"	Дархинт бригадаас зүүн тийш 2.7 км-т	200м урт, 200м өргөнтэй кварц-диоритын биет	
19	Яргайт уул	50°30'58" 100°38'45"	Их яргайт уулаас БХ 1.4 км-т	2км урт. 2 км өргөнтэй боржингийн биет	P2-80 мян.куб.м
20	Бэлчир уул	50°51'30" 98°35'00"	Хөгийн голын сав Буурал голын эхэнд Бэлчир уулын ар биед	2000м урт. 1000м өргөнтэй массив тогтоогдсон. Уг массив нь харьцангуйгаар ан цавшилт багатай, өгөршилд бага өртсөн, стрүктүүрийн бүтэцэд саарал болорын мөхлөгүүд нь гинжилсэн холбоо үүсгэн хээрийн жоншны мөхлөгүүдтэй барьцалдсан өвөрмөц төрхийн бүтэц текстүүртэй нь тогтоогдсон.	
Шохойн чулуу					
21	Мөрөнгийн орд	49°40'05" 100°08'05"	Мөрөн хотоос БХ 8 км	БХ суналтай. ЗХ 64-74° уналтай, моноклинат атираа үүсгэсэн, 100м урт, 60м өргөн, 19м зузаан биет. Шохойчулуу нь гантигжсан, доломитжсон, цахиржсан.	A+B=108 C1=9 (мян.т) 1960 оноос ашиглаж эхэлсэн.
22	Хар чулуутын орд	50°30'00" 100°04'00"	Хатгал сумын төвөөс БХ 10-12км	Шохойчулууны ЗХ суналтай, 45°-ын уналтай. 350м урттай, 60м өргөнтэй, 10м өргөнтэй давхарга илрүүлэгдсэн. Шохойнчулуу нь цахиуржиж, битумжсан, гадаргуугийн хэсэгтээ их ан цавжсан байна. 0.05-1 м зузаан делювийн хурдсаар хучигджээ.	C 1 = 593.2 мян.м3 Ил аргаар олборлох боломж той.
23	Цагаан хад уулын илрэл	50°16'30" 98°38'10"	Баянзүрх сум	Шохойнчулууны 1200м урт. 1000м өргөн, 20м зузаан давхарга	624000 т
24	Байшинг уулын илрэл	50°14'30" 98°42'50"	Баянзүрх сум	Шохойнчулууны 5500м урт. 1500м өргөн, 20м зузаан давхарга	4.29сая.т
25	Зүүн харганы	50°26'00" 100°15'00"	Мөрөн хотоос Х 90-95 км	Шохойн чулууны 60-70м урт биет	
26	Бүрэнхааны илрэл	49°47'00" 99°59'00"	Мөрөн хотын төвөөс БХ 27км	Шохойн чулуу, доломитын 100-120м өргөнтэй, 2600-2800 м урттай багц үе.	Шохойн чулуу C2= 85.4 Жигд шохой чулуу C2=27.24
27	Цахир Хясаа уулын илрэл	51°03'10" 101°34'08"		Илрэлийн хэмжээнд доод рифейн настай Зуны голын дээд дэд свитийн гантиг, гантигжсан шохойн чулуу голлох бөгөөд тэдгээр нь доод палеозойн боржингуудаар үзсэгдсэн.	Таамаг нөөц : 2080000т

28	Наян-Овоо уулын илрэл	48°33'00" 99°06'20"	Их Жаргалант сумын төвөөс БУ 18 км	Цагаан, саарал өнгийн гантигжсан доломитын харагдах зузаан 200м, урт 2000м.	Орон нутгийн хэрэгцээнд ашиглаж болно
29	Илрэл-159	50°20'55" 101°51'20"	Балуу уулаас ЗУ 1.5 км-т	2000м, 200-400м өргөнтэй шохойн чулууны үе тогтоогдсон	P2-30000 мян.куб.м
30	Нарийны ам	48°54'18" 99°36'10"	Шинэ-идэр сумаас ЗУ 7 км-т	250-450м урт 100м зузаантай шохойн чулууны 2 үе тогтоогдсон. Хяналтын коэфф-3.45, цахиурын модуль-33.1, шаварлаг модуль-1.0	P-3.0 сая тн
31	Цуурагт уул	48°47'30" 99°32'00"	Агьтийн голын баруун эрэг, Цуургат уулын ЗХ бэлд	500.700м урт 100,400м зузаантай шохойн чулууны 2 үе тогтоогдсон. Хяналтын коэфф-36.4, цахиурын модуль-2.83, шаварлаг модуль-11.0	
32	Хойд буурал. морьт уул	49°48'30" 99°38'00"	Сертийн доод булагийн хойд талд, Хойд буурал морьт	шохойн чулуу нь синклиналь атираа үүсгэх ба атирааны баруун, зүүн жигүүр дээр уналын өнцөг нь 50л-70л.	P=19500мян. т
33	Цагаан уул	48°37'35" 99°13'45"	Идэрийн голын хойно оршино.	Илрэлийн өмнөт хэсэгт орших гантигжсан шохойн чулуу нь дотроо 4-5,0 м зузаан хөхөвтөр саарал доломитын үе агуулдаг.	P-40560тн
34	Могойн хяр	48°39'30" 99°08'10"	Могойн хяр уулын з.х бэлд.	шохойн чулуу нь з.у 60-70 [^] -н уналтай, моноклиналь байрлалтай.	P-47125тн
<i>Шаазангийн шавар</i>					
35	Бургалтайн голын	49°34'10" 101°36'30"	Хойд ба урьд Бургалтайн	90м урт, 40-60м өргөн, 1-2 м зузаантай шаврын үе	P2-5.4 мян. куб.м
<i>Тоосгоны шавар</i>					
36	Мөрөнгийн орд	49°44'00" 100°00'00"	Мөрөн хотоос БХ 15км	Ордын ашигтай зузаалаг болох алевро-элсэнчулууны үе агуулсан алевролитозанарын багцын зузаан 180-190м. Алевролит нь "75" маркийн тоосго бэлтгэхэд тохирно.	C2 2.97 сая.т
37	Мөрөн I орд	49°37'02" 100°15'08"	Мөрөн хотоос ЗУ 14 км	Ашигтай зузаалаг нь улаан-хүрэн өнгийн шавранцар, шавранцарын талбай 32 га. Шавранцар нь мезозойп настай алевролиттой гарал үүслээрээ холбоотой. Шавар нь ГОСТ 530-71 шаардлагыг хангаж "150" ба "75"	Л+ВК.Т 1 179 мянл
38	Дулаан-Арын орд	49°37'30" 100°12'30"	Мөрөн хотоос 3 1.8км	БХ суналтай. 1000м урт, 500м өргөн, 10.9 м зузаан давхарга хэлбэрийн шаврын зузаалаг. ГОСТ-9195-75-н шаардлагыг хангаж бага маркийн тоосго үйлдвэрлэхэд тохирно.	C2=5995 мян.т
39	Тээлийн илрэл	49°32'00" 102°22'00"	Тариалан сумын төвөөс ЗУ 27км	Шаварлаг элсний үе, мэшил агуулсан шавар, шавранцар тархсан.Элсний үеийн зузаан 0.2-1.2м. ГОСТу-9169-75 шаардлагыг хангадаг.	C2=5363.6мян .м3

40	Баянгийн баруун давааны	50°31'40" 101°26'40"	Улаан эргийн фермээс баруун тийш 2.1 км-т	500м урт. 60м өргөн: 1.4м зузаантай шаврын үе	P2-42 мян.куб.м
<i>Рашаан ус</i>					
41	Түлэгт таг	52°01'50" 98°51'49"	Рэнчинлхүмбэ сумаас 125км-т, Түлэгт таг голын баруун эхэнд	Дархад группын хүчиллэг эффүүз дотроос 2,2л/сек ундаргатай, 0,7м/сек хурдтайгаар ундарна. Уг рашааныг нутгийн ардууд элэг, цөсний өвчин ангаах зорилгоор хэрэглэдэг боловч газар нутгийн хувьд алслагдмал, зам харилцаа байхгүй, бартаатай	Усны ерөнхий хатуулаг нь хатуу устай /19,7мг/экв/, эрдэсжилт 1398,5мг/л, исэлдэх чанар-12,8мг/л байгаа нь бохирдолтын хэмжээ бага
42	Бэлдэг	51°48'12" 98°34'30"	Их бэлдэг голын хойно Монгол-Тувагийн хил дээр.	Хөвсгөл групп Дооднуур формацийн шохойжин дотроос ундарна. Уг рашааныг нутгийн ардууд 5 цулыг ангаах зорилгоор хэрэглэдэг боловч газар нутгийн хувьд алслагдмал, зам харилцаа байхгүй, бартаатай	Өнгөгүй, тунгалаг, амт үнэргүй, тундасгүй, зөөлөн шинж
43	Шаглаг	51°22'48" 98°00'20"	Бусын голын зүүн талд, Улаан уул сумаас БХ 115км-т	Мөрөн группын цайвар саарал, саарал өнгийн шохойжин дотроос ундарна. Уг рашааныг нутгийн ардууд үе мөчылг ангаах зорилгоор хэрэглэдэг боловч газар нутгийн хувьд алслагдмал, зам харилцаа байхгүй, бартаатай	Өнгөгүй, тунгалаг, амт, үнэргүй, тундасгүй, зөөлөн шинж чанартай. Рашаан нь оргилж гарах төрлийн +30°C+35°C температуртай.

АРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

10.1. ХАА-н газар ашиглалт, ХАА-н үйлдвэрлэлийн хөгжил

10.1.1. Бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалт

Аймгийн хүн ам 2020 онд 137368, 2025 онд 149271, 2030 онд 187027 хүрэхээр байгаа бөгөөд МАА-н гаралтай бүтээгдэхүүний хэрэгцээг нийт үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүний 40-50%-р аймгийн дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжтой тул бэлчээрийн даац, багтаамжид тулгуурласан төлөвлөлтийг хийх боломжийг олгож байна. Хөвсгөл аймгийн хувьд Ренчинлхүмбэ, Цагааннуур, Улаан-Уул, Цэцэрлэг сумаас бусад сумдууд бэлчээрийн даац хэтэрсэн байдалтай байгаа бөгөөд Мөрөн, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Галт, Рашаант, Тариалан, Түнэл, Их-Уул, Жаргалант сумууд бэлчээрийн даац ашиглалт 200-с дээш хувь болсон байна. Уг төлөвлөлтөд сүргийн бүтэцийг зохистой болгож, таваарлаг чанарыг дээшлүүлж, нийт мал сүргийн 20-30% нь жил бүр зах зээлд нийлүүлэгдэж эдийн засгийн эргэлтэд орж хуримтлал, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж байхаар тооцоолж малын тоог тогтвортой хэмжээнд барих замаар бэлчээрийн даацад малын тоо, толгойг тохируулах бодлого баримталсан болно.

Мөн бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр ашиглалт багатай бэлчээр нутагт усан хангамжийг нэмэгдүүлэх, зам даваа засах замаар бүрэн ашиглах, доройтож талхлагдсан бэлчээрийг тодорхой хугацаанд ашиглалтаас чөлөөлж байгалийн аясаар нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг төлөвлөв.

Хөвсгөл аймгийн хувьд 12922727,65га талхлагдсан бэлчээрийн талбай байна гэсэн судалгааг байгаа бөгөөд ойрын хугацаанд (2020он хүртэл) талхлагдсан бэлчээрийн ачаалалыг сааруулах зорилгоор доройтлын байдал, ургамалжилтын төрлийг харгалзан тухайн газрын онцлогт тулгуурлан өнжөөх, сэлгэх болон бусад тохирсон арга хэмжээнүүдийг төлөвлөж зөвлөмжийг боловсруулав.

Ашиглалт багатай /Хөвсгөл аймгийн хувьд усжуулагдаагүй шалтгаанаар ашиглалтгүй бэлчээр зонхилж байна/ бэлчээр нутгийн ашиглалтыг сайжруулж талхлагдсан доройтсон бэлчээр нутагт менежмент хийх боломжыг олгох чиглэлээр усгүйгээс ашиглалт багатай байгаа 287,4мян.га **бэлчээрийг усжуулснаар** 195,9 мянган хонь толгой малын бэлчээрийг эргэлтэд оруулж, тэр хэмжээний бэлчээрийн газрыг сэлгээнд оруулах боломж нээгдэнэ. Эхний ээлжинд нийт **71 худаг** нэн тэргүүнд шаардлагатай ба төлөвлөлтийн дараагийн үе шатуудад нийт 253 худаг гаргахаар төлөвлөв.

10.1.2. Хадлангийн талбайн ашиглалт хамгаалалт, тэжээл үйлдвэрлэл

Хөвсгөл аймаг 48.2 мян га хадлангийн газартай, жилд 200 мян тонн байгалийн хадлангийн өвс бэлтгэж байгаа бөгөөд төлөвлөгөө хэрэгжих хугацаанд өвс 201,5мян.тн, багсармал тэжээл 45,9мян.тн тус тус шаардлагатай болно. Тус аймгийн хувьд байгалийн хадлангаас бэлтгэж буй өвс хэрэгцээгээ бүрэн хангаж байна. Харин хэрэгцээтэй байгаа 46-50мян.тн тэжээл үйлдвэрлэхийн тулд тэжээлийн үр тарианы үйлдвэрлэлийг одоогийнхоос 40-50 дахин нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Үүний тулд сумдуудад

жилд 150-200тн тэжээл үйлдвэрлэх жижиг цех байгуулах, тариалан суманд 10мян.тн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр байгуулах шаардлагатай. Тэжээлийн үйлдвэр, цехийг шаардлагатай үр тариагаар хангахын тулд тэжээлийн ургамалын тариалах талбайг өргөтгөх, га-ийн ургацыг нэмэгдүүлэх шаардлага байна.

байгалийн хадлан бэлтгэх талбайг хамгаалах, нэмэгдүүлэх шаардлага байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн хэмжээнд хадланд хамгийн тохиромжтой нугын бэлчээр 293,3мян.га байгаа боловч жилийн 4-н улиралд байнга ашиглагдан талхлагддаг учир га-н ургац нь дунджаар 0,5га/цн хүртэл буурч ядуурч байна. Мөн Хээрийн судалгааны үед 14 байршилыг хадлангийн бүс нутаг болгох санал өгсөн бөгөөд тохиромжтой байдлын үнэлгээгээр бүгд тохиромжтой нь тогтоогдсон ба ургацын хувьд зарим газрууд шаардлага хангахгүй байна иймд Цаашид байгалийн нөөцийг зөв зохистой ашиглахын тулд нугын бэлчээрийг сайжруулах, хамгаалах шаардлагатай байна. Үүний тулд нугын бэлчээрийг хадлангийн зориулалтаар эзэмшүүлэх, хашиж хамгаалах зэрэг сайжруулах арга хэмжээг дэмжих хэрэгтэй. Хөвсгөл аймгийн хувьд нугын хадланг сайжруулснаар 1га-с авах ургацын хэмжээг 40-50цн хүргэх боломж байна.

10.1.3. Тариаланд тохиромжтой газрын ашиглалт, хамгаалалт, газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжил

Хөвсгөл аймгийн хувьд 2013 оны статистикийн газрын мэдээгээр 2013 онд 2,747.70тн төмс, 24,379.90тн үр тариа, 1,229.80тн хүнсний ногоо хураан авсан ба энэ нь одоогийн аймгийн нийт хүн амын хэгцээг үр тарианаас бусад төрөлд бүрэн хангах хэмжээнд хүрэхгүй байгаа ба үр тариа 145.9%, Төмс 39.1%, Хүнсний ногоо 12.3%-г хангаж байна

Ерөнхий төлөвлөгөө хэрэгжих хугцаанд хүн амын өсөлтөөс үүсэх нэмэгдэх хэрэгцээг одоогийн үйлдвэрлэлтэй харьцуулахад 2030 он гэхэд үр тарианы 107,1%, Төмсний 28,8%, хүнсний ногооны 9%-г дөнгөж хангахаар байгаа тул газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Одоо ашиглагдаж буй газар тариалангийн эргэлтийн талбай 33266,6га бөгөөд 2030 он гэхэд газар тариалангийн үйлдвэрлэлд шаардлагатай эргэлтийн 85906,58га талбай шаардагдаж байна. Энэ нь зөвхөн аймгийн хүн амыг бүтээгдэхүүнээр хангахад хэрэгцээт талбай юм. Атаршсан болон өнжөөсөн тариалангийн талбайг эргэлтэд оруулахад 10685,9га-р нэмэгдүүлэх боломж байгаа бөгөөд бас орон нутгаас гарсан санал, одоо байгаа тариалангийн талбайн хэмжээ нь газар тариалангийн эргэлтийн талбайг 4251,2га-р тэлэх боломжтой байна. Мөн усалгаатай газар тариаланг дэмжин хөгжүүлснээр 1 га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлж шаардлагатай эргэлтийн талбайн хэмжээг бууруулах боломж байна.

10.1.4. Эрчимжсэн аж ахуй

Бэлчээрийн мал аж ахуйн нь зах зээлийн хөгжлийн дагаад 2030 он гэхэд нутгийн омгийн төрөлжсөн фермийн аж ахуйн хэлбэрт шилжих бөгөөд Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох,

Рашаант, Түнэл, Тариалан, Тосонцэнгэл, Цэцэрлэг, Эрдэнэбулган, Чандмань-Өндөр, Мөрөн эрчимжсэн мах сүүний чиглэлийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх, Цагааннуур сумдуудад нутгийн шилмэл омгийн Хогоргогын монгол, сарлаг, дархад омгийн ууцан сүүлт хонины аж ахуйг уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаар төрөлжүүлэн хөгжүүлэх.

Алаг-Эрдэнэ, Чандмань, Цагаан-Үүр нутгийн омгийн монгол үхрийн аж ахуйг зонхилж хөгжүүлэхээр төлөвлөлөө.

Сум, багийн төвд тэжээл борлуулах цэгүүдийг байгуулж, өрхийн аж ахуйг түшиглэн саалийн үнээ, гахай, шувууны жижиг аж ахуйг хөгжүүлэх, үүний тулд иргэдэд газар эзэмшүүлэх, тэжээлийн ургамал тариалахад төрийн дэмжлэг үзүүлэх бодлого баримтлахыг зөвлөж байна. Эрчимжсэн АА-г хөгжүүлэхэд үйлдвэрийн багсармал тэжээлийн хэрэгцээг хангахад ихээхэн анхаарах шаардлагатай байна.

10.1.5. Отрын бүс нутаг, ашиглалт хамгаалалтын төлөвлөлт

1974-1975 онд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-уул, Бүрэнтогтох сумын нутагт Завхан аймгаас 40.0 мян мал отроор өвөлжиж байжээ (С. Жигжидсүрэн. 1982 он). Аймаг дундын оторын 7.6 мян га бэлчээр Төмөрбулаг суманд байгуулагдсан, Цэцэрлэг сумын нутагт аймаг дундын оторын бүс 87.0 мян га бэлчээр нэмэгдэнэ. Хөвсгөл аймаг оторын бүс нутгийг өргөтгөхөд их анхаарч байна. Хээрийн судалгааны үед сумдаас өгсөн саналын дагуу 15-н байршилд отрын бүс нутаг гаргахаар төлөвлөсөн ба үүнээс 2 байршил нь аймаг дундын отрын бүс, бусад нь сумын отрын нөөц нутаг байна. Цагаан-үүр суманд нутаг 11,12, 13,14-р талбарт зам засч, 269.1 мян га бэлчээрийг зун-өвлийн улиралд отор отороор ашиглана. Сумын дотор оторын хэд хэдэн бүс нутаг бий болгоно. Үүнд: Арбулаг сум 3,4-р талбарт 45 мян га, Бүрэнтогтох сум 5,6-р талбарт 17.1 мян га, Тосонцэнгэл 10-р талбарт гүн өрмийн худаг гаргаж 1.0 мян га, Цагаан-Уул сум 1,2-р талбарт 17.2 мян га бэлчээрийг өвлийн оторт ашиглахаар төлөвлөж байна. Отрын бүс нутагт аймаг, сумын төсвийн хөрөнгөөр малын хашаа саравч барих, худаг ус гаргах, өвс тэжээл бэлтгэх, сум дундын нутагт бусад сумдаас нүүж ирэх малчдын замыг тосгуулан дамжин өнгөрөх цэг байгуулж тохижуулах, ойролцоох нутгийн иргэдэд тулгуурлан хүн малын эмч, худалдаа, үйлчилгээний газар ажиллуулах арга хэмжээ авах нь зүйтэй.

Отрын бүс нутгийн бэлчээрийн ургац тачир, сийрэг байдлыг харгалзан отрын бүс нутагт даацаас хэтэрсэн мал оруулах, ган, зуд тохиогоогүй үед мал оруулахаас аль болохоор татгалзаж байхыг санал болголоо.

10.2. Хот, тосгон бусад суурин газрын газар ашиглалт, хамгаалалт, суурьшлын хөгжлийн төлөвлөлт,

Газар зохион байгуулалтын 2014-2030 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд хот байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага, төлөвлөлтийн норм ба дүрмийн дагуу тухайн хот сум суурины төвийн барилга байгууламж, нутаг дэвсгэрийн бүсүүдэд шаардагдах газрын хэмжээг тооцоолж гаргалаа.

Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний тооцооны үндэс болох хүн амын хэтийн тоог 2014-2020, 2021-2025, 2026-2030 оноор тооцоолж хүн амын тоотой уялдуулан орон сууц, цэцэрлэг сургууль эмнэлэг, худалдаа үйлчилгээний барилга байгууламжуудын хүчин чадал, шаардагдах эдэлбэр газрын хэмжээг тодорхойлж хот байгуулалтын үнэлгээг хийв тус үнэлгээгээр Арбулаг, Бүрэнтогтох, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумдууд байгалын нөхцлийн үнэлгээгээр тохиромжтой бусад сумдууд аль нэг үзүүлэлтээрээ хязгаарлагдмал тохиромжтой ангилалд орж байна.

Мөрөн, Хатгал, Ханх, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Баянзүрх, Галт, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Цагаан-Уул, Цэцэрлэг, Шинэ-Идэр сумд 2000м хүртэл өндөрт байрладаг нь хязгаарлагдмал тохиромжтой. Иймд барилга дулаан хадгалалтад тохирсон хийц сонгох шаардлагатай. Ханх, Алаг-Эрдэнэ, Жаргалант, Түнэл, Цагаан-Уул сумдад цэвдэг хөрс алаг цоог тархсан учир хязгаарлагдмал тохиромжтой. Хатгал, Баянзүрх, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Цагааннуур, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр сумдад үргэлжлэн тархсан цэвдэг хөрстэй учир тохиромжгүй нөхцөлтэй. Цэвдэг хөрстэй газарт барилга байгууламж барихад барилгын суурь, төрөл хийцийг оновчтой сонгож, нөлөөллийг харгалзсан арга хэмжээг төлөвлөх шаардлагатай. Сул овойлттой хөрс бүхий Мөрөн, Хатгал, Ханх, Могойн гол, Арбулаг, Бүрэнтогтох, Жаргалант, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумд хязгаарлагдмал тохиромжтой нөхцөлтэй бөгөөд овойлт суулттай хөрстэй газарт барилга байгууламж барихад түүнд тохирсон барилгын хийц, төрлийг сонгож, хүчний нөлөөллийн эсрэг арга хэмжээг төлөвлөх шаардлагатай. 7-8 баллын мужлалд оршдог Мөрөн, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Баянзүрх, Бүрэнтогтох, Галт, Их-Уул, Жаргалант, Рашаант, Ренчинлхүмбэ, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Түнэл, Улаан-Уул, Цагааннуур, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумд хязгаарлагдмал тохиромжтой нөхцөлтэй. Хатгал, Ханх, Могойн гол, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг сумд 9 баллын мужлалд байрладаг учир тохиромжгүй нөхцөлтэй тул 9-10-аас дээш баллтай газарт барилга байгууламж барихад газар хөдлөлийн хүчний эсрэг арга хэмжээ авах шаардлагатай. Ундны усны хангамжийн үзүүлэлтээр Хатгал, Могойн гол, Баянзүрх, Цагааннуур сумд дунд зэрэг гэсэн судалгаатай байна. Бусад бүх сум сууринд ундны усны хангамж сайн.

Хот суурин газрын ашиглалтын тохиромжтой бүсчлэлийг тогтоон, газрын нөөцийг тогтоосон бөгөөд 23-н сум, 1 тосгоны хот суурин газраас 20-н сум **суурин газрынхаа тэг гортигийг тэлэх** шаардлагатай байна. хот байгуулалтын нормоор тооцоолсон шаардлагатай газрын хэмжээг тогтоосон газар ашиглалтын бүсчлэлээр тогтоосон газрын нөөц үзэхэд бүрэн хангаж байна. тогтоогдсон нөөц газруудыг ашиглахдаа хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Хөвсгөл аймгийн сумдын төвийн нийт талбай 27083,3га байгаа бөгөөд төлөвлөлтөөр 32759,0га болох ба ашиглалтын талбай 17527,98га болно. Үүнээс засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжын бүс нийт 1106,07га, нөөц нь 1648,5га газар байна. Гэр орон сууцны бүс газар нийт 4327,89 га, нөөц нь 6307,1га байна. Үйлдвэр аж ахуйн бүс газар нийт 1190,97 га-д байрлана. Төлөвлөж буй эрчимжсэн

мал аж ахуй хөгжүүлэх бүс нутаг нийт 995,49га, ойн зурвас, ногоон байгууламжын бүс 744,24 га, амралт зугаалгын бүс 205,9 га газарт байрлана.

Аймгийн хэмжээнд 2018 онд багтаан бүх иргэдэд нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлүүлэхээр төлөвлөж хот, тосгон бусад суурины газрын хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөв.

10.3. Зам шугам сүлжээний газар, дэд бүтцийн хөгжил

10.3.1. Зам, тээврийн байгууламж

Авто зам

Хөвсгөл аймгийн нутгаар улсын болон орон нутгийн чанартай 5547 км авто зам дамжин өнгөрч байгаагаас улсын чанартай зам 1065 км, орон нутгийн чанартай зам 1848 км, сумаас баг хүртлэх 2834 км ердийн хөрсөн зам байна.

Хөвсгөл аймгийн улсын чанартай замын Мөрөн-Хатгалын А1101 чиглэлийн 89,9 км хатуу хучилттай зам ашиглалтанд орсон. Мөрөн-Булганы 180 км /253.3/ хатуу хучилттай автозам 2014 онд ашиглалтанд бүрэн орж, Улаанбаатар хот, Булган. Эрдэнэт, Дархан хотуудтай хатуу хучилттай замаар холбогдоно. Энэ чиглэлийн замтай давхцаж байгаа Их-Уул, Тосонцэнгэл сумууд хатуу хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдоно. Хатуу хучилттай зам Тариалан сумаас 9 км зайтай өнгөрнө. Мөн Мөрөн-Хатгалын хатуу хучилттай авто замаас Алаг-Эрдэнэ сумын төв 7 км зайтай байна. Ханх-Мондын замын 20.63, Мөрөнгийн төвийн Хилэнтийн 180.0, Түнэл сумын Эгийн голын 162.5, Галт сумын Идэрийн голын 162.9, Жаргалант сумын Идэрийн голын 163.1, Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөр бетон, Шишгэд, Хогоргын голын 150 у/м хөвдөг гүүрүүд баригдан ашиглалтанд оржээ.

Хөвсгөл аймгийн хувьд Босоо тэнхлэгийн Мөрөнгөөс ОХУ-ын хилийн боомт хүртэл хатуу хучилттай зам барьж дуусгах, дараа нь Монгол улсын аялал жуулчлалын гол маршрут Мөрөнг-Тэрхийн Цагаан нуурын чиглэлийн хатуу хучилттай замтай холбох ажлыг гүйцэтгэх, улмаар босоо тэнхлэгийн нэг хэсэг болох Мөрөн-Улиастай чиглэлийн авто замыг барихаар төлөвлөлөө. Ингэснээр зөвхөн хот хоорондын зам хатуу хучилттай болоод зогсохгүй тухайн чиглэл давхцаж байгаа сумууд хатуу хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдоно. Мөн Хөвсгөл болон Завхан аймгийн нүүрсний хэрэгцээг хангадаг Могойн голын уурхайг хатуу хучилттай болгохоор төлөвлөв. Мөн Тосонцэнгэл – Рашаант-Хайрхан –Өлзийт чиглэлийн зам баригдснаар Мянганы замын хэвтээ тэнхлэгийн замтай холбогдож дээр дурьдсан зорилтууд хэрэгжинэ. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 485,5тэрбум төгрөг шаардлагатай ба 1553,0га авто замын зурвас газарт орно. Мөн Сэлэнгэ мөрний Сацын булангийн 253.3, Идэр Чулуутын голын 120.0, Мөрөнгийн голын 120.0, Улаан-Уулын Багтагийн голын 100.0, Хөгийн голын 70.0, Баянзүрх сумын Бэлтэсийн голын 78.0 зэрэг у/м төмөр бетон гүүрийг барих шаардлагатай байгаа юм. Сумдаас санал өгсөн орон нутгийн чанартай авто замыг засах саналыг нэгтгэн шаардлагатай төсвийг тооцоолон төлөвлөлтөд тусгав.

Агаарын тээврийн барилга байгууламж

Мөрөн хотын нисэх буудал нь хатуу хучилттай нисэх буух зурвастай. Хуучин тус аймгийн бүх сумуудад бага оврын нисэх онгоц хүлээн авах буудалтай байсан ба одоо Хатгал тосгоны ердийн хөрсөн нисэх буух зурвастай буудал хаяахан ашиглагдаж байгаа ба бусад нь ашиглагдахгүй байна.

2015-2020 онд Мөрөн хотын нисэх буудлыг олон улсын нисэх онгоц хүлээн авах боломжтой болгохын тулд нисэх буудлыг өргөтгөн шинэчилнэ.

2015-2020 онд Мөрөнгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж олон улсын нисэх онгоц хүлээн авах боломжтой болгоно. 10 км хатуу хучилттай нисэх буух зурвасыг 4.260 тэрбум төгрөгөөр барьж байгуулна.

Төмөр замын газар

Хөвсгөл аймагт одоогийн байдлаар барьж ашигласан төмөр зам байхгүй.

УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоол гарч төмөр замын хөгжлийн бодлогыг тодорхойлсон. Тус бодлогын “1.2.1.3.Төмөр замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээтэй болох” гэж заасан билээ. Тус бодлогын хавсралтанд Эрдэнэт-Булган-Мөрөн-Цагаанхайрхан-Улаангом гэсэн чиглэлээр төмөр зам алс хэтдээ тавихаар тусгасан.

Усан замын тээвэр

1900 оны эхээр Оросын худалдаачид Ханхын чиглэлээр худалдаа хийдэг байсан бөгөөд түүхий эд, ангийн үс, мал, мах тээвэрлэхэд ашиглах зорилгоор 1905 оноос Хөвсгөл нуурын байгалийн байдал, салхины зонхилох чиглэл үргэлжлэх хугацаа, давалгааны хэмжээ, зогсоол барих байршил, замын зураг, чиглэл зэрэгт судалгаа хийж, дүгнэлт гарган 40 тн-ы даацтай 75 морины хүчтэй, уурын хөдөлгүүрт онгоцыг барьж байгуулаад 1910 онд ашиглалтад оруулж байсан байна.

Манай улсын усан замын нийт урт 400 км, үүнээс Ханх-Хатгалын чиглэл 124 км-ийг эзлэнэ. Манай орны нөхцөлд усан замыг гол төлөв аялал жуулчлалын зориулалтаар ашиглах бодлого баримталж байгаа бөгөөд улсаас түүний хяналт зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

10.3.2. Холбоо, мэдээллийн сүлжээ

Хөвсгөл аймгийн төв Мөрөн хот Улаанбаатар хоттой шилэн кабелиар холбогдсон бөгөөд нийт 24 сумын төвийн 20 сумын төв нь шилэн кабелиар аймгийнхаа төвтэй холбогдсон байна. Нийт шилэн кабелийн урт 1151.3 гаруй км байна. 2015-2020 онд Цэцэрлэг, Цагааннуур, Ринчинлхүмбэ, Ханх сумууд шилэн кабелиар холбоно. Ингэснээр бүх сум шилэн кабелиар холбогдож, радио телевиз, интернетийг чөлөөтэй ашигладаг болно.

10.3.3. Цахилгаан, дулааны сүлжээ

Хөвсгөл аймаг нь төвийн бүсийн эрчим хүчний системд багтдаг ба 23 сум нь дотоодын төвлөрсөн цахилгаан хангамжийн системд өндөр хүчдэлийн ЦДАШ-д холбогдсон. Ханх сум ОХУ-ын хил орчмын эрчим хүчний системээс эрчим хүчээ авдаг байна. Мөн Эрдэнэбулган сумын нутагт сумын төвөөс 3 км зайтай газар Эгийн гол дээрх усан цахилгаан станцыг Дани улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2006 онд барьж ашиглалтанд оруулсан. Тус аймагт шинээр барих эрчим хүчний эх үүсвэрийг Монгол орны цахилгааны хэрэглээний өсөлт, хэтийн төлөв, цаашдын хөгжил, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн талаар баримтлах хэтийн чиглэл, бодлого хэрэгжүүлэх арга замтай уялдуулан шийдэх нь оновчтой гэж үзэж байна. Сумдаас ирсэн саналуудыг нэгтгэн төлөвлөлтөд тусгав.

Мөрөн хотод хүн ам төвлөрч, барилга байгууламж ихэсч байгаа бөгөөд энэ байдал ирээдүйд ч үргэлжлэх хандлагатай байна. Тиймээс, төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээ байгуулж, 6 ш бага чадлын халаалтын зуухны газруудыг нэгтгэж 1 дулааны станцтай болох шаардлагатай байна. Мөрөн хотын төвд 2014 онд ашиглалтанд орсон 33мВт-ын дулааны станцын хүчин чадал нь хүн амын өсөлт болон барилга байгууламж олноор баригдаж байгаатай холбогдуулан хүчин чадлыг 60мВт болгон нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

10.4. Ойн сан бүхий газар, ойн ашиглалт, хамгаалалт

Хөвсгөл аймаг ойн сан бүхий 22 сумтай, ойн сангийн нийт талбай аймгийн нийт нутаг дэвсгэрийн 35.6хувийг эзэлнэ. Хөвсгөл аймгийн ойгоор бүрхэгдсэн талбай /3203,8 мян.га/-г аймгийн нийт нутаг дэвсгэр /10 960,0 мян.га/-д харьцуулж гаргахад ойрхог чанар нь 29,2 хувь байна.

Ойн сан бүхий газрын төлөвлөлтийг ойрын болон дунд хугацааны /2015-2020он/, Алс хэтийн /2020-2030он/ гэсэн 2 хугацаагаар төлөвлөсөн бөгөөд 2015-2020он хүртэлх хугацаанд ойн сангийн газрын ашиглалт, хамлаалалт, нөхөн сэргээх арга хэмжээг ойн зохион байгуулалт, ойн тооллогын материалд тулгуурлан сум тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 2020-2030 оны төлөвлөлтийг одоогийн ойн санд оруулж буй хөрөнгө оруулалт, ойн ангийн хүчин чадал зэргээс харгалзан ерөнхийлөн төлөвлөсөн болно. 2015-2020 он хүртэлх хугацаанд 450га түймрээс хамгаалах зурвас, 104300га-д ойн хөнөөлт хортон, шавж, өвчинтэй тэмцэх, 2190000га талбайд ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх, 3150га талбайг ойжуулах, 3450га талбайд ойн сэргэн ургалтад туслах арга хэмжээ авахаар төлөвлөв.

2020-2030 онд 1250га түймрээс хамгаалах зурвас, 3605700га талбайд ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх, 24486га-д ойн хөнөөлт хортон, шавж, өвчинтэй тэмцэх, 6352га талбайг ойжуулах, 7507га талбайд ойн сэргэн ургалтад туслах арга хэмжээ авахаар төлөвлөв.

Уг ажлуудыг хийхэд 2015-2020онд 9359,9сая.төг, 2021-2025онд 4607,7сая.төг, 2026-2030онд 5024,7сая.төг шаардлагатай байна.

10.5. Усны сан бүхий газар, усны нөөцийн ашиглалт хамгаалалт

2003 онд хийсэн гадаргын усны тооллогоор Хөвсгөл аймгийн хэмжээнд 1163 гол горхи тоологдсоноос 70 ширгэсэн, 902 булаг шанднаас 193 ширгэсэн, 612 нуур цөөрөм тоологдсоноос 30 ширгэсэн бөгөөд 2007 оны усны тооллогоор 916 булаг шандаас 179 ширгэсэн, 782 гол горхи тоологдоноос 451 ширгэсэн, 593 нуур, цөөрөм 49 ширгэсэн, 2011 оны тооллогоор 1101 гол горхиноос 132 ширгэсэн, 932 булаг шанднаас 163 ширгэсэн, 580 нуур тойром 62 ширгэсэн байдаг. Харин 2013 оны гадаргын усны тооллогын дүнд 1212 гол горхи тоологдсоноос устай 1173, нуур тойромоос 578 бүгд устай, 929 булаг шанд тоологдсоноос 841 устай, Рашаан нийтдээ 61 устай тоологдсон байна.

Цаашид сум, аймгийн төвийн унд ахуйн усны эрүүл ахуйн бүсийг нарийвчлан тогтоож тэмдэгжүүлэн хамгаалах, усны чанарт шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Усны сан бүхий газрын доройтолд бэлчээр ашиглалтын хэв маяг, гол горхи, нуур, худаг уст цэг дагасан бэлчээрийн талхагдал нь усны сан бүхий газрын чанар нөөцөд ихээхэн нөлөөлж байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн ихэнхи сумдын бэлчээрийн идэвхитэй ашиглагддаг газруудад даац хэтэрсэнээс бэлчээр ихээр талхлагдаж цөлжиж байна. иймд бэлчээр усжуулалтын төлөвлөлтөд тусгасан нэн тэргүүнд шаардлагатай байгаа 71 худгийг гаргах. Сумдаас санал болгосон хамгаалах шаардлагатай булгуудыг нэн тэргүүнд тохижуулах ажлуудыг төлөвлөв.

10.6. Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт

2023 он хүртэлх хугацаанд улсын тусгай хамгаалалтад Бадарын нуруу-Цагаан уул, Их Түнэл уул, Эрчимийн нуруу, Жарантайн намаг-Булнай-Их элээт, Их бараан уул, Дулаанхаан уул, Тэрхэн цагаан нуур, Халхан Булнай нуруу, Ногооннуур, Гуна ямаат, Жар Хярууны нуруу, Эг-Үүрийн бэлчир зэрэг газруудыг хамгаалалтад авахаар төлөвлөсөн /2003 онд батлагдсан УГЗБЕТ-өөс/. хээрийн судалгааны явцад сумдаас ирсэн саналыг нэгтгэн үзэхэд улсын болон аймгийн, сумын тусгай хэрэгцээний газарт хамруулах нийт 36 байршилд санал өгсөн бөгөөд үүнээс 5 сумын 6-н байршлыг улсын тусгай хэрэгцээнд хамруулах, 8-н сум 14 байршил бүхий газрыг аймгийн тусгай хэрэгцээнд, 7-н сум 16 байршил бүхий газрын сумын тусгай хэрэгцээнд хамруулан хамгаалах шаардлагатай байна гэсэн санал өгчээ. Тус санал бүхий газруудад хамрах талбайн газрын нэгдмэл сангийн ангиллын бүтэцийг тогтоон төлөвлөлтөд тусгав.

10.7. Аялал жуулчлал, амралт зугаалгын бүс газрын төлөвлөлт,

Тус аймагт сүүлийн жилүүдэд ирж байгаа жуулчны тоо 2010 онтой харьцуулахад гадаадынх 3,4, дотоодынх 4 дахин нэмэгдсэн. Дотоодын жуулчдын ихэнх нь автомашинаар ирж, зориулалтын газарт байрладаггүй. Одоогоор аялал жуулчлалын салбарт 350 хүн ажиллаж, жилдээ 20000 гаруй гадаад болон дотоодын жуулчин хүлээн авдаг байна.

Цаашид Аялал-рекреацийн чадавхын үнэлгээнд тулгуурлан тогтоосон боломжит аялал жуулчлалын хэлбэрийг хөгжүүлэх шаардлагатай бөгөөд төлөвлөлтөд аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн онцлог, суурь нөөцөд тулгуурлан цаашид дэмжин хөгжүүлэх аялалын төрлүүдийг тодорхойлсон ба Аялал рекреацийн өндөр чадавхитай нутгуудад Цэцэрлэг, Жаргалант, Галт, Улаан-уул, Цагаан нуур, Цагаан-үүр, Түнэл сумдад Байгалийн аялал жуулчлал буюу эко аялал жуулчлал, Нэн ховор амьтан түүний ул мөрөөр аялах аялал, Түүх соёлын аялал, Шувуу ажиглах аялал, Цэцэг ажиглах аялал жуулчлал, Ан агнуурын аялал, Уулын аялал, Усан аялал, Цаатан амьдралтай танилцах болон угсаатны аялал, Агуйн аялал жуулчлал, Эрүүлжүүлэх аялал жуулчлал, Эрдэм шинжилгээ, судалгааны аялалыг хөгжүүлэх бүрэн боломжтой байна. Мөн Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын нийт нөөцүүдийг хэд хэдэн бүлэгт хуваан авч үзэж болох бөгөөд 4-н замналын аялалуудыг санал болгон зохион байгуулах боломжтойг тогтоон төлөвлөлтөд тусгав.

Хөвсгөл аймаг нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний томоохон нөөцтэй юм. Иймд аялал жуулчлалын нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулан, бүс нутгуудыг төрөлжүүлэх. Аялал жуулялалыг маршрутын зохион байгуулалтад оруулж маршрутыг нэг бүрчлэн үнэлэн тогтоож зах зээлд борлуулах, үйлчилгээний цогц байдал, чанар, сэтгэл ханамж зар сурталчилгаа, идэвхижүүлэлтийн төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэх маркетингийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлуудыг төлөвлөгөөнд тусгав.

10.8. Уул уурхайн газрын төлөвлөлт

Хөвсгөл аймаг нь байгалийн өвөрмөц тогтоц бүхий Хөвсгөл нуур болон хамгийн их ойн болон усан сан бүхий аймаг юм. Тус аймгийн нутаг дэвсгэрт хамгийн цөөн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт 2014 оны 10-р сарын 28-ны байдлаар хайгуулын 33, ашиглалтын 16 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч үзвэл нүүрсний 5, алтны 1, барилгын материалын 7, фосфоритын 2, холимог металлын хүдрийн 1 тусгай зөвшөөрөл тус тус хүчин төгөлдөр байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээ 184.5 орчим мянган Га байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 6.7 орчим мянган Га байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар явуулсан геологийн судалгаа, эрэл үнэлгээ, хайгуулын ажлын үр дүнгээр 35 нэр төрлийн ашигт малтмалын 300 гаруй орд, илрэл тогтоогдсон байна. Хөвсгөл аймагт барилгын төрөл бүрийн төмөрбетон эдлэхүүн, зам талбайн өнгөт, хээтэй хавтан хашлага, тоосгоны үйлдвэрээс гадна шохой, шохойн түүхий эд бүхий сликат хөнгөн бетон, Хүрмэн бетон ханын төрөл бүрийн гулдмай, байгалийн өнгөт чулуу боловсруулах үйлдвэрлэл тухайлбал цагаан гантиг, саарал боржин өнгөлгөөний материал үйлдвэрлэх бүрэн боломжтой

10.9. Дүгнэлт

1.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь газарт суурилсан урт хугацааны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон баримт бичиг болсон гэж дүгнэж байна.

Энэхүү баримт бичгийн ач холбогдол нь аймаг сумын нийгэм-эдийн засаг, салбаруудын хөгжлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, газарт суурилсан нийгмийн, эдийн засгийн, экологийн төслүүдийг боловсруулах суурь үндэслэл болохын зэрэгцээ тогтвортой хөгжлийн үндсэн зарчмуудыг хангах, иргэд орон нутагтаа ажлын байртай, ашиг орлоготой, сайн сайхан амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн газрын менежментийг хэрэгжүүлэхэд оршиж байгаа гэж дүгнэж байна.

2.Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт төсөл, арга хэмжээ, саналууд нь 16 хүртэл жилийн хугацаанд хэрэгжих төсөөлөл/прогнозын шинжтэй тусгагдсан тул хэрэгжүүлэх үедээ бие даасан төсөл, арга хэмжээ, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж хэрэгжих юм.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээ, санал зөвлөмжүүдийг аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөө, төсөв, сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд үе шат, ээлж дараалалтайгаар тусгагдан хэрэгжүүлэх юм. Энэ нь тус төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх үндсэн механизм болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Хөтөлбөрийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хэрэгжүүлэх хугацаа
1	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” УИХ 2008 оны 01 сарын 31, 12-р тогтоол	
2	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	
3	Төрөөс хvнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого 2009 оны 7-р сарын 15	
4	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого УИХ-н 2009 оны 39 дүгээр тогтоол	
5	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр УИХ-н тогтоол 2010 оны 06 сарын 25 өдөр	
6	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол	
7	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал УИХ-н 2001 оны 57 дугаар тогтоол	
8	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого УИХ-н 2009 оны 45 дугаар тогтоол	
9	Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр /засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 120-р тогтоол/ Шинэчлэлийн засгийн газар, Яамдын үйл ажиллагааны төлөвлөгөө; Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2012-2016 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	2012-2016
10	Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1997 оны 255 дугаар тогтоол	1997-2030
11	“Сүү” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2006 оны 239 дүгээр тогтоол	2006-2020
12	Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоол	2001-2020
13	“Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр” Засгийн газрын 2008.07.08 дугаар 288	2008-2016
14	“Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2009.02.04-ний 32 дугаар тогтоол	2009-2016
15	“Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр” Засгийн газрын 2009.09.30-ны 299 дүгээр тогтоол	2009-2016
16	“Ариун цэврийн байгууламжийг сайжруулах” хөтөлбөр /Нийтийн бохирын шугам, цооног, бохир усны төрөл бүрийн цэвэрлэх байгууламж/ Засгийн газрын 2006.10.11-ний 246 дугаар тогтоол	2006-2015
17	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр Засгийн газрын 2003.06.24-ний 160 дугаар тогтоол	2003-2015
18	Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 103 дугаар тогтоол	1998-2020
19	“Малын чанар сайжруулах” хөтөлбөр. Засгийн газрын 2006.04.26-ны 93 дугаар тогтоол	2006-2015
20	“Малын тэжээл” хөтөлбөр Засгийн газрын 2007.11.07-ны 283 дугаар тогтоол	2008-2015
21	“Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” үндэсний хөтөлбөр УИХ-ын 1997 оны 106 дугаар тогт	2000-2021
22	Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 82 дугаар тогтоол	1998-2021
23	Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1996 оны 163 дугаар тогтоол	1996-2016
24	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр УИХ-ын 1998 оны 29 дугаар тогтоол	1998-2015
25	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2003.06.04-ний 141 дүгээр тогтоол	2003-2012
26	Ойн тухай үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоол.	2001-2015
27	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1999.02.10-ны 25 дугаар тогтоол	1999-2015
28	“Чанарын болон байгаль орчны удирдлага /менежмент/-ийг дэмжих үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2002.07.08-ны 146 дугаар тогтоол	2002-2016
29	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2000 оны 120 дугаар тогтоол	2000-2015
30	Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр	2008-2015

	Засгийн газрын 2008 оны 267 дугаар тогтоол	
31	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2005.03.09-ний 44 дүгээр тогтоол	2005-2025
32	“Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах” хөтөлбөр Засгийн газрын 2006. 12.20-ний 309 дүгээр тогтоол	2010-2015
33	“Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” Засгийн газрын 2008.02.27-ны 71 дүгээр тогтоол	2008-2015
34	“Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр” Засгийн газрын 2008.03.05-ны 84 дүгээр тогтоол	2008-2015
35	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2008.02.27-ны 78 дугаар тогтоол	2008-2012
36	Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө	2012 он
37	Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө	2011-2021
38	2003 онд батлагдсан УГЗБЕ төлөвлөгөө	2003-2023
39	Тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө	2012
40	Монгол улсын статистикийн эмхэтгэл	2013